

МОНГОЛ УЛС БА ЗЭРЛЭГ АМЬТАН, УРГАМЛЫН АЙМГИЙН ХОВОРДСОН ЗҮЙЛИЙГ ОЛОН УЛСЫН ХЭМЖЭЭНД ХУДАЛДААЛАХ ТУХАЙ КОНВЕНЦ

ҮНДЭСНИЙ ХОЁРДУГААР ТАЙЛАН

ЗАХИАЛЖ, САНХҮҮЖҮҮЛСЭН:



БАЙГАЛЬ ОРЧИН,
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМ

ЭМХЭТГЭСЭН:



ХАМТРАН АЖИЛЛАСАН:



ННА 20.18
ДАА 351.82
Г-531

Эмхэтгэсэн:

С. Гомбобаатар
Ш. Мягмарсүрэн

Ангилал зүйн бүлгийг бичсэн:

Шавж: Ч. Гантигмаа
Загас, мөлхөгч: Х. Тэрбиш
Шувуу: С. Гомбобаатар, Ү. Төвшин
Хөхтөн: С. Шар, Д. Лхагвасүрэн
Ургамал: Д. Суран, Б. Оюунцэцэг

Редактор:

С. Шар
Ж. Мөнх-Эрдэнэ
С. Баярхүү

Зохиогчийн эрх

© Байгаль Орчин, Аялал Жуулчлалын Яам
© Монголын Шувуу Судлалын Нийгэмлэг
© Монгол Улсын Их Сургууль, Степ Форвард Хөтөлбөр
© Монголика хэвлэлийн газар

Хэвлэлийн эх, загвар:

©Монголика хэвлэлийн газар

Гэрэл зураг:

© С. Гомбобаатар, Монголика
хэвлэлийн газар
© Ч Гантигмаа
© Д. Суран
© Х. Тэрбиш

Бүтээлийг ерөнхийлөн эш татах:

Гомбобаатар, С. ба Мягмарсүрэн, Ш. 2019. *Монгол улс ба Зэрлэг амьтан, ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенц*. Байгаль Орчин, Аялал Жуулчлалын Яам, Монголын Шувуу Судлалын Нийгэмлэг, МУИС, Степ Форвард Хөтөлбөр. Улаанбаатар хот, Монгол улс.

Амьтан, ургамлын бүлгийг эш татах:

Гантигмаа, Ч. 2019. Бүлэг: шавж;
Тэрбиш, Kh. 2019. Бүлэг: загас, мөлхөгч;
Гомбобаатар, С., Төвшин, Ү. 2019. Бүлэг: шувуу;
Шар, С., Лхагвасүрэн, Д. 2019. Бүлэг: хөхтөн;
Суран, Д., Оюунцэцэг, Б. 2019. Бүлэг: ургамал. *Монгол улс ба Зэрлэг амьтан, ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенц*. Гомбобаатар, С. ба Мягмарсүрэн, Ш. (эмхэтгэгч). Байгаль Орчин, Аялал Жуулчлалын Яам, Монголын Шувуу Судлалын Нийгэмлэг, МУИС, Степ Форвард Хөтөлбөр. Улаанбаатар хот, Монгол улс.



ISBN 978-99978-68-86-2

АГУУЛА

ӨМНӨХ ҮГ 5

ТАЙЛАНГИЙН ЗОРИЛГО 6

**ЗЭРЛЭГ АМЬТАН, УРГАМЛЫН АЙМГИЙН
ХОВОРДСОН ЗҮЙЛИЙГ ОЛОН УЛСЫН
ХЭМЖЭЭНД ХУДАЛДААЛАХ ТУХАЙ
КОНВЕНЦИЙН ТАНИЛЦУУЛГА 7**

МОНГОЛ УЛС ДАХЬ КОНВЕНЦИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА 8

КОНВЕНЦИЙН ҮДИРДАН ЗОХИЦУУЛАХ ЗӨВЛӨЛ 8

**КОНВЕНЦИЙН ХЭРЭГЖИЛТ, ХОЛБОГДОХ ХУУЛЬ ТОГТООМЖ,
БОДЛОГЫН БИЧИГ БАРИМТ БОЛОН ХӨТӨЛБӨР 9**

**ЗЭРЛЭГ АМЬТАН, УРГАМЛЫН АЙМГИЙН ХОВОРДСОН ЗҮЙЛИЙГ
ОЛОН УЛСЫН ХЭМЖЭЭНД ХУДАЛДААЛАХ ТУХАЙ
КОНВЕНЦИЙН МЭДЭЭ, ТАЙЛАН 11**

МОНГОЛ УЛСЫН МЭДЭЭ, ТАЙЛАН 11

ХОВОР АМЬТАН, УРГАМАЛ ХАМГААЛАХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР 16

ЧАДАВХ БЭХЖҮҮЛЭХ ТАЛААР ГҮЙЦЭТГЭСЭН АЖИЛ 16

КОНВЕНЦИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХТЭЙ ХОЛБОГДОН ГАРСАН БҮТЭЭЛ 17

**МОНГОЛ УЛС ДАХЬ ТАЛУУДЫН БАГА ХУРЛААС ГАРСАН
ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТ 18**

**КОНВЕНЦИЙН ХАВСРАЛТАД ОРСОН АМЬТАН, УРГАМАЛ
(ЗҮЙЛИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ, ХАНДЛАГА) 34**

**КОНВЕНЦИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХЭД ТУЛГАРЧ БҮЙ
БЭРХШЭЭЛ, ЦААШИД АНХААРАХ САНАЛ 76**

ТАЛАРХАЛ 78

ХАВСРАЛТ 79

НОМ ЗҮЙ 97



ТОВЧИЛСОН ҮГС

АНУ	Америкийн Нэгдсэн Улс
АНЭУ	Арабын Нэгдсэн Эмират Улс
АТХ	Амьтны тухай хууль
БЗАХН	Байгаль, Зэрлэг Амьтан Хамгаалах Нийгэмлэг
БНХАУ	Бүгд Найрамдах Хятад Ард Улс
БОНХЯ	Байгаль Орчин, Ногоон Хөгжлийн Яам
БОЯБТК	Биологийн Олон Янз Байдлын Тухай Конвенц
БОАЖЯ	Байгаль Орчин, Аялал Жуулчлалын Яам
БЦГ	Байгалийн цогцолборт газар
ГЕГ	Гаалийн Ерөнхий Газар
ЗГ	Засгийн Газар
ДБХС	Дэлхийн Байгаль Хамгаалах Сан
ДБХХ	Дэлхийн Байгаль Хамгаалах Холбоо
ЕБСБХ	Ерөнхий ба Сорилын Биологийн Хүрээлэн
ЗТХ	Зөрчлийн тухай хууль
ЛАСН	Лондонгийн Амьтан Судлалын Нийгэмлэг
МУИС	Монгол Улсын Их Сургууль
МШСН	Монголын Шувуу Судлалын Нийгэмлэг
МХЕГ	Мэргэжлийн Хяналтын Ерөнхий Газар
НҮБ	Нэгдсэн Үндэстний Байгууллага
ОХУ	Оросын Холбооны Улс
САЙТИС	Зэрлэг амьтан, ургамлын аймгийн ховордсон зүйлийг Олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенц (CITES)
СФХ	Степ Форвард Хөтөлбөр
ТББ	Төрийн бус байгууллага
ТБХ	Талуудын бага хурал
ТХГН	Тусгай хамгаалалттай газар нутаг
ХАУТГЭЗГХЗТХ	Ховордсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийн гадаад худалдааг зохицуулах тухай хууль
ХЗДХЯ	Хууль зүй, Дотоод Хэргийн Яам
ХХЕГ	Хил Хамгаалах Ерөнхий Газар
ЦЕГ	Цагдаагийн Ерөнхий Газар
ШУА	Шинжлэх Ухааны Академи
Эк.-э.з.ү.	Экологи-эдийн засгийн үнэлгээ
ЭХ	Эрүүгийн хууль

ӨМНӨХ ҮГ

Байгалийн нөөцийг шинжлэх ухааны үндэслэл, тооцоо судалгаагүй ашигласны улмаас амьтан, ургамлын олон зүйл манай дэлхий дээр устаж үгүй болсоор байна.

Амьтан, ургамлын зүйл устах нь улс үндэстний байгалийн нөөц баялагтай холбоотой зан үйл, сүсэг бишрэл, ард түмний уламжлалт соёл, амьдралын хэв маяг, гоо сайхны хэрэглээ, техник, технологийн дэвшил зэрэг нийгэм, эдийн засгийн олон талт асуудалтай шууд холбоотой. Амьтан ба ургамал нь хүмүүний мөнхийн хэрэгцээ тул тэдгээрийг зүй зохистой ашиглах, хамгаалах нь аль ч улсын хувьд чухал асуудал байсан, байсаар ч байх болно. Амьтан, ургамлын зүйл устахад нөлөөлдөг томоохон хүчин зүйлийн нэг нь олон улсын худалдаа билээ. Ой ба загасны төрлийн бүтээгдэхүүнийг оруулахгүйгээр 1990-ээд оны сүүлчээр тооцсон судалгаанаас үзвэл зэрлэг амьтан, ургамлын гадаад худалдааны жилийн дүн 5-6 тэрбум ам. долларт хүрчээ. Жил тутам 25-30 мянган сармагчны төрөл, 2-5 сая зэрлэг шувуу, 10 сая орчим мөлхөгч, 15 сая орчим хөхтний арьс ширийг худалдаалж байна.

Амьтан, ургамлын гадаад худалдаа жилээс жилд өсөж, худалдаанд өртөж буй зүйлүүд устах аюулд хүрсэн болохыг харгалзан дэлхийн улс орнууд ховордсон амьтан, ургамлын гадаад худалдааг олон улсын хэмжээнд хянан зохицуулах зорилгоор 1973 онд АНУ-ын Вашингтон хотноо олон улсын хэлэлцээр байгуулсан нь эдүгээ "CITES-ийн конвенц" нэрээр дэлхий дахинаа хүлээн зөвшөөрөгдсөн юм.

Монгол улс тус Конвенцид 1996 оны 4 дүгээр сарын 4-нд 131 дэх гишүүн орноор элсэн орсон. Энэ Конвенцийн үндсэн зарчим нь устах аюулд хүрсэн амьтан, ургамлын төрөл зүйлийг ялгаатай 3 хавсралтад ангилж, I хавсралтад худалдаанаас болж устаж үгүй болох эсвэл, устаж болзошгүй болсон амьтан, ургамлыг, II хавсралтад хэдийгээр устаж үгүй болох аюулд хараахан хүрээгүй ч эдгээр зүйлийн гадаад худалдааг хянан зохицуулахгүй тохиолдолд устаж болзошгүй болсон зүйлүүд, III хавсралтад худалдаалах явдлыг бусад талуудтай хамтран хянах шаардлагатай гэж үзсэн зүйлүүдийг тус тус багтаадаг.

Одоо дэлхийн хэмжээнд энэ гурван хавсралтад 5,000 орчим зүйл амьтан, 28,000 орчим зүйл ургамал бүртгэгджээ. Манай улсаас тус Конвенцийн I хавсралтад борцгор хотон, идлэг шонхор, цэн тогоруу, жороо тоодог зэрэг 13 зүйлийн шувуу, хулан, тахь, хүрэн баавгай, голын халиу, цоохор ирвэс зэрэг 5 зүйл хөхтөн, харин II хавсралтад 1 зүйл эрвээхэй, 2 зүйл загас, 1 зүйл мөлхөгч, 58 зүйл шувуу, 9 зүйл хөхтөн бүртгэгдсэн байдаг.

Монгол улс энэхүү Конвенцид нэгдэн орсноор өөрийн орны ховордсон амьтан, ургамлын зүйлийг олон улсын хэмжээнд хийгдэж байгаа худалдааны улмаас устах явдлаас сэргийлэх зорилго тавихаас гадна бусад улс орны хувьд ч ховордсон зүйлийг хамгаалахад нь туслах үүрэг хүлээдэг. Үүнээс гадна Конвенцийг хэрэгжүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулах зорилгоор "Ховордсон амьтан, ургамал тэдгээрийн гаралтай эд зүйлийн гадаад худалдааг зохицуулах тухай хууль"-ийг Монгол Улсын Их Хурлаас 2002 оны 11-р сард баталж, хэрэгжүүлж байна.

Конвенцийн талаарх ерөнхий ойлголт, мөн Конвенцид нэгдэн орсноос хойш манай улсад хийж хэрэгжүүлж байгаа ажлын талаар илтгэсэн анхдугаар тайланг 2014 онд, харин 2019 онд хоёр дахь тайланг боловсруулан гаргаж байна. Энэ нь Конвенцийн талаарх ойлголтыг нийтэд түгээх, Конвенцийн хавсралтад бүртгэлтэй ургамал, амьтны худалдааны талаарх мэдээ, баримтыг хүргэх, цаашид энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулах иргэн, аж ахуйн нэгж, байгууллагуудад бодит мэдлэг олгоход чухал ач холбогдолтой.

Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай Конвенцийн анхдугаар болон удаах тайланг боловсруулах санаачлагыг гаргасан БОАЖЯ, санаачлагыг ажил хэрэг болгосон Монголын Шувуу Судлалын Нийгэмлэг, Монгол Улсын Их Сургууль, МУИС-ийн Степ Форвард Хөтөлбөр, Лондонгийн Амьтан Судлалын Нийгэмлэгийн хамт олонд гүн талархлаа илэрхийлье.

БОАЖЯ-ны Хүрээлэн Буй Орчин, Байгалийн Нөөцийн Газрын дарга
Конвенцийн Удирдан зохицуулах зөвлөлийн дарга
П. Цогтсайхан

ТАЙЛАНГИЙН ЗОРИЛГО

Монгол улс “Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенц”-д нэгдэн орсноос хойш 18 жилд гарсан амжилт бүтээл, сургамжийг нэгтгэсэн анхдугаар тайланг 2014 онд боловсруулсан нь зэрлэг ургамал, амьтны ашиглалт, хамгааллын чиглэлээр бодлого боловсруулах, хэрэгжүүлэхэд чухал холбогдолтой байлаа. Бид энэхүү Конвенцийн үндэсний хэмжээний хоёр дахь удаагийн тайлан боловсруулан гаргаж буй зорилго нь уг Конвенцийн хэрэгжилт, үйл явцыг харьцуулан дүгнэх боломжийг хүн бүрт олгох, Монгол улсын амьтан, ургамлын гадаад худалдааны бодлогыг шинэчлэх үйл явцад дөхөмтэй мэдээ, баримтыг нэгтгэх, оролцогч талуудыг нэгдсэн мэдээллээр хангах, Конвенцийн цаашдын хэрэгжилтэнд анхаарах шаардлагатай асуудлыг тодруулах, тодорхойлоход оршино.



ЗЭРЛЭГ АМЬТАН, УРГАМЛЫН АЙМГИЙН ХОВОРДСОН ЗҮЙЛИЙГ ОЛОН УЛСЫН ХЭМЖЭЭНД ХУДАЛДААЛАХ ТУХАЙ КОНВЕНЦ –(CITES)

Анх 1973 онд гарын үсэг зурсан Вашингтон хотын нэрээр “Вашингтоны конвенц” буюу Конвенц (Convention on International Trade in Endangered Species of Wild Fauna and Flora гэсэн өгүүлбэрийн англи хэл дээрх товчлол болох- CITES) гэх нэрээр танил болсон “Зэрлэг амьтан, ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай Конвенц” нь амьтан, ургамлын ховордсон зүйлийн худалдааг зохицуулдаг Засгийн Газар хоорондын эрх зүйн акт юм. Энэ нь байгаль хамгаалал, тогтвортой ашиглалтын талаарх одоогоор мөрдөгдөж байгаа хамгийн том, урт хугацаанд хэрэгжиж байгаа Конвенц мөн. Тус Конвенц 1963 онд хуралдсан Дэлхийн Байгаль Хамгаалах Холбооны гишүүдийн уулзалтаар гаргасан шийдвэрийн үр дүн болно. 1973 оны 3 сарын 3-ны өдөр АНУ-ын Вашингтон хотод 80 орны төлөөлөл оролцсон хуралдаанаар тус Конвенцийн төслийг хэлэлцэн баталж, улмаар 1975 оны 7 сарын 1-нд хүчин төгөлдөр болсон түүхтэй. Конвенцийн эх нь Хятад, Англи, Франц, Орос, Испани хэлээр хэвлэгдсэн бөгөөд хувилбар тус бүр адил хүчинтэй байдаг.

Уг Конвенцид гарын үсэг зурж нэгдсэн орнууд Конвенцийн Талуудыг бүрдүүлдэг. Энэ Конвенц нь тухайн улс орны хууль тогтоомжийг орлохгүй боловч Талууд Конвенцийн биелэлтийг хангах албан ёсны үүрэг хүлээнэ. Конвенцийг улс орныхоо хэмжээнд хэрэгжүүлэхийн тулд Талууд хууль тогтоомждоо тохирох өөрчлөлтийг оруулдаг. Олон жилийн туршид энэ нь хамгийн олон улс нэгдэн орсон Конвенц бөгөөд одоогоор нийт 180 гишүүн орон нэгдээд байна.

Жил бүр зэрлэг амьтан, ургамлын олон улсын худалдаа дэлхийд хэдэн тэрбум доллараар хэмжигддэг бөгөөд үүний цаана хэдэн зуун сая амьтан, ургамлын зүйл, бодгалиудын худалдааны тухай асуудал хөндөгддөг. Дээрх худалдаанд амьд амьтан, ургамал, тэдгээрийн

гаралтай бүтээгдэхүүн, тухайлбал арьс ширэн бүтээгдэхүүн, мод, эм бэлдмэл зэрэг бусад олон зүйлс багтдаг. Бөхөн, ирвэс, бар, заан зэрэг олон зүйл устгах аюулд өртөөд байгаа талаарх мэдээлэл хаа сайгүй тархах болмоо. Зэрлэг амьтан, ургамлын худалдаа нь улс орнуудын хооронд хил дамнан хийгдэх учир тодорхой зүйлийг хэт ашиглалтаас хамгаалахын тулд олон улсын хамтын ажиллагаа зүй ёсоор шаардагддаг. Энэхүү хамтын ажиллагаанд тус Конвенц чухал үүрэгтэй. Ашиглах байдлаас үл хамааран 35,000 гаруй зүйл амьтан, ургамлын худалдаа тус Конвенцийн эрх зүйн баримтын дагуу явагдана.

Конвенцид улс орнууд сайн дураар нэгдэн ордог бөгөөд Талуудын бага хурал, Нарийн бичгийн дарга нарын газрын үйл ажиллагаа нь Талуудын оруулсан хувь нэмрээс бүтсэн Итгэлцлийн сангаас санхүүждэг. Харин Итгэлцлийн сан Талуудын үйл ажиллагааг санхүүжүүлдэггүй. Нарийн бичгийн дарга нарын газрын үйл ажиллагаанаас бусад ажлыг (сургалт, тухайлсан зүйлд чиглэсэн үйл ажиллагаа) санхүүгийн өөр эх үүсвэрээс, ихэвчлэн Европын холбоо зэрэг хандивлагч орнууд, бүс нутагт чиглэсэн байгууллагуудаас босгодог. Энэ Конвенц нь тодорхой зүйлүүд, тэдгээрийн гаралтай бүтээгдэхүүний олон улсын худалдааг хянахад чиглэнэ. Конвенцид хамаарах зүйлүүдийн импорт, экспорт, ре-экспорт нь эрх бүхий байгууллагаас олгосон зөвшөөрөл, шат дамжлагын дагуу хийгдэх ёстой. Конвенцид нэгдэн орсон тал, нэгдэж ороогүй аль нэг улстай зэрлэг амьтан, ургамлын аймгийн ховордсон зүйл, тэдгээрийн гаралтай эд зүйлсийн худалдаа хийх тохиолдолд Конвенцийн заалтыг мөрдөх үүрэг хүлээнэ. Конвенц нь дараах гурван хавсралттай бөгөөд хавсралт бүр нь ховордсон ургамал, амьтны зүйлийг багтаадаг. Үүнд:

Хавсралт I: Олон улсын худалдаа нь тухайн зүйлийн оршин амьдрахад нөлөө үзүүлж байгаа, эсвэл нөлөө үзүүлж болох, устгах аюулд орсон бүх зүйлийг багтаана. Конвенцийн I хавсралтад орсон зүйлийг хил дамнуулан худалдаалах асуудлыг хатуу хяналт зохицуулалттай гүйцэтгэх бөгөөд арилжааны зорилгоор худалдаалахыг үндсэндээ хориглож, судалгаа шинжилгээний зорилгоор экспортлох, импортлоход экспорт, импортын баримт бичгийг шаарддаг.

Хавсралт II: Эдүгээ устгах аюулд ороогүй ч тухайн зүйлийн цаашид оршин амьдрахад харшлахаар ашиглалт явуулахгүй байх шалтгаанаас олон улсын худалдааг хяналт зохицуулалттай явуулахгүй бол устгах аюулд орж болзошгүй зүйлүүд энэ хавсралтад багтдаг. Конвенцийн II хавсралтад багтсан зүйлүүдийг арилжааны зорилгоор худалдаалж болох бөгөөд экспортлох, импортлоход экспортлогч улсын экспортын зөвшөөрлийг шаарддаг.

Хавсралт III: Конвенцийн аль нэг тал буюу ЗГ-ын тодорхойлсон олон улсад худалдааг нь хянах шаардлагатай ургамал, амьтны зүйлийг багтаадаг.

МОНГОЛ УЛС ДАХЬ КОНВЕНЦИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Монгол улс “Зэрлэг амьтан, ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенц”-д нэгдэн орох тухай Монгол Улсын Их Хурлын 1995 оны 5 дугаар сарын 4-ний өдөр 24 тоот тогтоол гарч, улмаар Конвенцийн зөвлөл манай улсыг 1996 оны 4 дүгээр сарын 4-нд албан ёсоор бүртгэснээр Монгол улс дэлхийн 131 дэх орноор нэгдэв.

Монгол улсаас энэ Конвенцийн I, II хавсралтад нийтдээ 15 зүйл хөхтөн, 64 зүйл шувуу, 8 зүйл ургамал, 2 зүйл загас, тус бүр 1 зүйл шавж, мөлхөгч багтсан байдгаас I хавсралтад 6 зүйл хөхтөн, 13 зүйл шувуу бүртгэгдсэн байна.

Конвенцийн II хавсралтад 9 зүйл хөхтөн, 58 зүйл шувуу, 1 зүйл мөлхөгч, 2 зүйл загас, 1 зүйл шавж, 8 зүйл ургамал оржээ (хавсралт 1).

КОНВЕНЦИЙН УДИРДАН ЗОХИЦУУЛАХ ЗӨВЛӨЛ

Конвенцийн 9.1.в болон Монгол улсын “Ховордсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийн гадаад худалдааг зохицуулах тухай” хуулийн 4-р зүйл, Амьтны тухай хуулийн 36-р зүйл, Байгалийн ургамлын тухай хуулийн 17-р зүйлд заасны дагуу байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дэргэд Конвенцийг хэрэгжүүлэхтэй холбогдсон асуудлыг зохицуулах үүрэг бүхий Удирдан зохицуулах зөвлөл, Удирдан зохицуулах зөвлөлд зөвлөгөө, зааварчилгаа өгөх Шинжлэх ухааны зөвлөл ажилладаг.

Үндэсний Удирдан зохицуулах зөвлөл болон Шинжлэх ухааны зөвлөлийг БОАЖ-ын сайдын тушаалаар байгаль орчны болон хүнс, хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, гааль, мэргэжлийн хяналтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, төрийн бус байгууллагын төлөөлөл бүхий бүрэлдэхүүнтэйгээр баталдаг. Өнгөрсөн хугацаанд манай улс тус Конвенцийн олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн болзол, шаардлагуудыг биелүүлж, Талуудын бага хурлын ээлжит хуралдаанд тогтмол идэвхтэй оролцож ирлээ.

Талуудын бага хурлуудаас гарсан шийдвэрүүдийг дотоодын бодлого, төлөвлөлтөндөө тусгах ажлыг зохион байгуулж, Конвенцийн Нарийн бичгийн дарга нарын газарт тус Конвенцийн хэрэгжилтийн талаарх тайланг хүргүүлж, Нарийн бичгийн дарга нарын газартай байнгын холбоотой, Конвенцийн үйл ажиллагаанд тогтмол оролцож байна.

Монгол улс 1996 онд АНУ-д зохион байгуулагдсан Талуудын 9-р бага хуралд анх удаа ажиглагчаар орсон бөгөөд үүнээс хойш ээлжит хуралдаануудад тасралтгүй оролцож ирлээ. Конвенцийн Талуудын бага хуралд хэлэлцэж буй асуудлуудаар өөрийн орны байр сууриа илэрхийлж, Азийн бүсийн гишүүн орнуудын бага хурлыг Улаанбаатар хотод анх удаа 2002 онд амжилттай зохион байгуулсан (САЙТИС-ийн хэрэгжилтийн байдалд дүн шинжилгээ үнэлгээний танилцуулга, 2010).

Талуудын хамтын ажиллагааны хүрээнд БНХАУ болон манай Удирдан зохицуулах зөвлөл хамтран 2011 оны 3-р сард уулзалт зохион байгуулж, бөхөнгийн эврийн худалдаанд хяналт тавих, гаалийн ажилтнуудын ур чадварыг сайжруулахад анхаарч, харилцан ойлголцлын санамж бичигт гарын үсэг зурав.

Хуулийн дагуу томилогдсон Удирдан зохицуулах зөвлөл болон Шинжлэх ухааны зөвлөлийн эрх, үүрэг, гүйцэтгэх үйл ажиллагааг Монгол улсын “Ховордсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийн гадаад худалдааг зохицуулах тухай” хуулиар тогтоожээ.

КОНВЕНЦИЙН ХЭРЭГЖИЛТ, ХОЛБОГДОХ ХУУЛЬ ТОГТООМЖ, БОДЛОГЫН БИЧИГ БАРИМТ БОЛОН ХӨТӨЛБӨР

Монгол улсын Үндсэн хуулийн 6-р зүйлд “Монгол улсад газар, түүний хэвлий, ой, ус, амьтан, ургамал болон байгалийн бусад баялаг гагцхүү ард түмний мэдэл, төрийн хамгаалалтанд байна. Монгол улсын иргэдэд өмчлүүлснээс бусад газар, түүнчлэн газрын хэвлий, түүний баялаг, ой, усны нөөц, ан амьтан төрийн өмч мөн” хэмээн хуульчилсан.

Монгол улс тус Конвенцид нэгдэн орох тухай тогтоолыг Монгол улсын Их хурлаас 1995 оны 5-р сарын 4-ний өдөр баталсан.

Энэ Конвенцийн заалтыг хэрэгжүүлэх эрх зүйг зохицуулах “Ховордсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийн гадаад худалдааг зохицуулах тухай” хуулийг 2002 оны 11-р сард батлав. Энэ хууль нь Конвенцийг хэрэгжүүлэх, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад Конвенцийн хавсралтад орсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийг олон улсад худалдаалах зөвшөөрөл олгохтой холбогдсон харилцааг зохицуулах зорилготой.

Монгол улсын ЗГ улс орныхоо нийгэм, эдийн засгийн харилцаанд гарч буй өөрчлөлт шинэчлэлтэнд нийцүүлэн, эдийн засгийн үр ашигтай, байгаль орчинд сөрөг нөлөө багатай, тогтвортой хөгжлийг хангах зорилгоор эрх зүйн зохицуулалтыг улам боловсронгуй болгон, байгаль орчны багц хуульд нэмэлт өөрчлөлт оруулах, хуулийн давхардал, хийдэл, цоорхой зөрчлийг арилгах, тэдгээрийн уялдаа холбоог сайжруулах, боловсронгуй болгох чиглэлийг баримтлан ажиллаж байна. Монгол улсын хууль тогтоомжийг 2012 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл батлах тухай Монгол улсын Их хурлын 2009 оны 38-р тогтоол, Байгаль орчны салбарын эрх зүйн орчныг 2009-2012 он хүртэл боловсронгуй болгох төлөвлөгөө, Байгаль орчны багц хуулийн шинэчлэлийн хүрээнд энэхүү Конвенцийн хэрэгжилтийн эрх зүйн орчин дараах хуулиудтай уялдаа холбоотой байна. Үүнд:

о Монгол улсын Их хурлаас 2012 оны 5-р сарын 17-ны өдөр “Амьтны тухай” хуулийг батлан гаргав. Энэхүү хуулийг Амьтны аймгийн тухай хууль болон Ан агнуурын

тухай хуулийг хүчингүй болгон шинэчлэн найруулсан. Амьтны тухай хуулийн зорилт нь амьтныг хамгаалах, өсгөн үржүүлэх, түүний нөөцийг зохистой ашиглахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

о Монгол улсын Байгалийн ургамлын тухай хуулийг 1995 онд баталсан. Энэ хуулийн зорилт нь ой болон таримал ургамлаас бусад ургамлыг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээхтэй холбогдсон харилцааг зохицуулдаг.

о Байгаль орчныг хамгаалах тухай хууль нь Монгол улсын Их хурлаар 1995 оны 6-р сарын 5-ны өдөр батлагдсан. Энэ хуулийн зорилт нь хүний эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хангах, нийгэм, эдийн засгийн хөгжлийг байгаль орчны тэнцвэртэй уялдуулах, өнөө болон ирээдүйн ашиг сонирхлын үүднээс байгаль орчныг хамгаалах, түүний баялагийг зохистой ашиглах, нөхөн сэргээхтэй холбогдож төр, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хооронд үүсэх харилцааг зохицуулахад оршино. Энэхүү хуульд 1998, 2002, 2005, хамгийн сүүлд 2013 оны 5-р сарын 17-нд нэмэлт өөрчлөлт оруулсан.

о Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийг 2012 онд батлав. Энэхүү хуулийг Монгол улсын их хурлын 1995 оны 5 дугаар сарын 22-ны өдөр батлагдсан Агнуурын нөөц ашигласны төлбөр, ан амьтан агнах, барих зөвшөөрлийн хураамжийн тухай, Байгалийн ургамал ашигласны төлбөрийн тухай, Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоос байгаль орчин хамгаалах, байгалийн нөөцийн нөхөн сэргээлтийн арга хэмжээнд зарцуулах хөрөнгийн хэмжээний тухай, Ойгоос хэрэглээний мод, түлээ бэлтгэж ашигласны төлбөрийн тухай зэрэг байгалийн нөөц ашигласны төлбөртэй холбогдсон харилцааг тус тусад нь зохицуулж байсан хуулиудыг шинэчлэн найруулсан байна.

о Гаалийн тухай хууль нь 2008 онд батлагдсан бөгөөд хуулийн зорилт нь Монгол улсын хилээр нэвтрүүлэх бараа, тээврийн хэрэгсэлд гаалийн бүрдүүлэлт хийх, гаалийн хяналт хэрэгжүүлэх журам, гаалийн

бүрдүүлэлтийн горим, нөхцөл, шаардлагыг тогтоох, гаалийн байгууллагын тогтолцоо, гаалийн байгууллага, албан тушаалтны эрх, үүргийг тодорхойлох, тэдгээрийн шийдвэрт иргэдээс гаргасан гомдол, түүнийг гаалийн байгууллага, албан тушаалтан шийдвэрлэх, гаалийн хууль тогтоомжийг зөрчигчдэд хариуцлага хүлээлгэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

о Хилийн тухай хуулийн 16, 28 заалтын дагуу Засгийн Газрын 2003 оны 173 дугаар тогтоолын 1-р хавсралтаар “Ургамлын үр, үрслэг, амьтан, түүний үр хөврөл үр, түүхий мах, дайвар бүтээгдэхүүн болон бичил биетний өсгөвөр, эмгэгт материалын дээжийг улсын хилээр нэвтрүүлэх боомтын жагсаалт”-ыг (хавсралт 4) батлан, 2010 болон 2014 оны 190-р тогтоолоор нэмэлт өөрчлөлт оруулжээ.

о Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай хуулийг 2002 оны 11-р сарын 28-нд батлан, дараа нь хэд хэдэн удаа (2012.12.20, 2011.02.10, 2011.02.10, 2010.06.10, 2007.06.28) нэмэлт өөрчлөлтүүдийг хийжээ.

о 2015 онд шинэчлэн батлагдсан Монгол улсын Эрүүгийн хуульд хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэргийг зүйлчлэн 24-р бүлгийн 24.5-д заасан хууль бусаар ан агнах, 24.8-д байгалийн ургамлыг хууль бусаар бэлтгэхэд хүлээх ял шийтгэлийг заасан.

о Монгол улсын Зөрчлийн тухай хуулийг 2017 онд шинээр баталж, энэ хуулийн 7.3-д ховордсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийн гадаад худалдааг зохицуулах тухай хуулийн хариуцлагыг тусгайлан зааж, 7.6-р зүйлд Амьтны тухай хууль зөрчих, 7.7-р зүйлд Байгалийн ургамлын тухай хууль зөрчихөд хүлээлгэх хариуцлагыг тус тус багтаажээ.

о Монгол улсын Зар сурталчилгааны хууль нь 2002 онд батлагдсан ба хуулийн 14.1-д “Нэн ховор, ховор ургамал, амьтны жагсаалтад орсон болон тэдгээрийн үндэс, иш, мөчир, навч, бугын цусан эвэр, чив, засаа, согооны сүүл, сав, хүдрийн заар, баавгайн доньд зэрэг эрхтнийг бэлтгэх, худалдах, худалдан авах тухай зар сурталчилгааг хориглох”, мөн 14.2-т “Хуулиар олгогдсон бүрэн эрхийнхээ хүрээнд 3Г-аас гаргасан шийдвэрийн дагуу тодорхой хугацаанд агнах, бэлтгэхийг хориглосон амьтан, ургамлын эд эрхтэн, түүхий эдийг худалдах, худалдан авах тухай

зар сурталчилгаа явуулахыг хориглосон.

о Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль нь 1994 оны 11-р сарын 15-нд батлагдсан байгалийн бүс, бүслүүрийн онцлог, өвөрмөц тогтоц, ховор, ховордсон ургамал, амьтан бүхий газар, түүх, соёлын дурсгалт болон үзэсгэлэнт газрын хэв шинжийг хадгалах, хувьсч өөрчлөгдөх зүй тогтлыг судлах, танин мэдэх зорилгоор газар нутгийг тусгай хамгаалалтанд авах, ашиглах, түүний унаган төрхийг хадгалах, хамгаалахтай холбогдсон харилцааг зохицуулах зорилготой. Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн дагуу Монгол улсын нийт нутаг дэвсгэрийн 17.4 хувийг тусгай хамгаалалтанд авснаар хавтгай, мазаалай, тахь, бөхөн, хандгай, зэрлэг гахай, минж зэрэг амьтны тархац нутгийг бараг бүрэн хамгаалалтанд авч, ирвэс, хулан, халиу, хүдэр, аргаль, янгир зэрэг амьтны тархац нутгийн 70 хүртэл хувь нь хамгаалалтанд орсноор хууль бус агналт, хууль бус худалдааг хязгаарлахад чухал нөлөөтэй (Монгол орны нэн ховор, ховор амьтдын хамгааллын байдалд хийсэн аудитын тайлан, 2010).

о Монгол улсын 3Г-ын 2001 оны 264-р тогтоолын 3-р хавсралтаар баталсан “Агнуурын нөөц ашигласны төлбөр, агнуурын амьтан агнах, барих зөвшөөрлийн хураамжийн хувь хэмжээ”-г 2005 оны 248 тоот тогтоолоор хүчингүй болгож, 2010 оны 23-р тогтоолын 2-р хавсралтаар баталж, 4-р хавсралтад заасан “Гадаадын иргэнд тусгай төлбөртэйгөөр агнуулах агнуурын амьтны олзворын жишиг үнэ, төлбөр, хураамжийн хувь хэмжээ” нь 2011 оны 65-р тогтоолоор 22 дахь заалт хүчингүй болж, харин 2, 5, 18, 20, 21, 23-р заалтыг өөрчлөн шинэчилж, 2-р хавсралтаар баталсан “Ан амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ”-г 2005 оны 248-р тогтоолоор хүчингүй болгож, 2011 оны 23-р тогтоолын 1-р хавсралтаар батлав.

о Амьтны тухай хуульд зүйлчилснээр агнуурын амьтан агнах, барихыг хориглох хугацаа болон ховор амьтны жагсаалт, ховор амьтныг агнах, барих зөвшөөрөл олгох журмыг 3Г батална гэж заасны дагуу 3Г-ын 2013 оны 93-р тогтоолоор баталсан Ховор ан амьтан агнах, барих зөвшөөрөл олгох журам хүчин төгөлдөр байна.

о Монгол улсын 3Г-ын 2003 оны 173 дугаар тогтоолоор баталсан “Амьтан, ургамал, түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хяналт, шалгалт

хийх журам”, “Амьтан, ургамал, түүхий эд, бүтээгдэхүүнд экспорт, импортын гэрчилгээ олгох журам”-д олон улсын гэрээнд заасан шаардлага нөхцөлийг хангаагүй тохиолдолд гэрчилгээ олгохгүй гэж заасан.

Монгол улсын ЗГ-аас 2002 онд “Идлэг шонхор шувууг хамгаалах, зохистой ашиглах тухай” 163-р тогтоол, “Идлэг шонхор шувууны жишиг үнэ, төлбөр, хураамж тогтоох тухай” 171-р тогтоолыг баталсан ба 171-р тогтоолоор 2006-2007 онд гадаадад жил бүр гаргах идлэг шонхор шувууны тооны дээд хязгаарыг 300 хүртэл толгой, түүний жишиг үнийг 10,000 ам. доллар, төлбөрийг 9,000 ам. доллар, хураамжийг 800 ам. доллар байхаар тус тус тогтоов.

Амьтны тухай хуулийн хавсралтаар баталсан нэн ховор амьтны жагсаалтад орсон 31 зүйлээс 14 зүйл, ЗГ-ын 2001 оны 264 ба 2005 оны 248-р тогтоолоор баталсан 36 ховор амьтнаас 12 зүйл, Байгалийн ургамлын тухай хуулийн хавсралтаар баталсан нэн ховор ургамлын 133 зүйлээс 8 нь энэхүү Конвенцийн I, II хавсралтад бүртгэгдсэн бөгөөд ингэснээр эдгээр зүйлийн олон улсын худалдааг манай улсын хэмжээнд хянах нөхцөл бүрэлдэж байна.

ЗЭРЛЭГ АМЬТАН, УРГАМЛЫН АЙМГИЙН ХОВОРДСОН ЗҮЙЛИЙГ ОЛОН УЛСЫН ХЭМЖЭЭНД ХУДАЛДААЛАХ ТУХАЙ КОНВЕНЦИЙН МЭДЭЭ, ТАЙЛАН

Зэрлэг амьтан, ургамлын аймгийн ховордсон зүйлийн олон улсын худалдааны мэдээллийн сан болон санг бүрдүүлэгч мэдээ, баримтыг Конвенцийн Нарийн бичгийн дарга нарын газрыг төлөөлөн НҮБ-ын Байгаль Орчны Хөтөлбөр, Дэлхийн Байгаль Хамгаалмын Хяналтын Төв (НҮББОХ-ДБХХТ) удирддаг. Энэ санд уг Конвенцийн хавсралтад орсон 34,000 гаруй зүйлийн зэрлэг амьтны худалдааны талаарх 13 сая гаруй тайлан байдаг. Жил бүр ойролцоогоор сая гаруй зэрлэг амьтан, ургамлын аймгийн ховордсон зүйлүүд худалдаалсан мэдээлэл ирдэг. НҮББОХ-ын ДБХХТ эдгээр мэдээллийг хүлээн авсан даруйдаа Конвенцийн худалдааны мэдээллийн санд байршуулдаг. Конвенцийн жилийн тайланг Конвенцийн хэрэгжилт болон хавсралтуудад орсон зүйлүүдийн олон улсын худалдааны түвшинд хяналт тавихад ашиглана (www.cites.org) (<http://unep-wcmc.org/citestrade>).

Талууд хавсралтад орсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах зөвшөөрөл олгох, энэ талаар тайлан бэлтгэх үүрэгтэйг Конвенцийн 8-р зүйлд заажээ.

Энэ дагуу Талууд жилийн тайлангаа Швейцарь дахь Нарийн бичгийн дарга нарын газар, эсвэл шууд НҮББОХ-ДБХХТ (энэ тохиолдолд Конвенцийн Нарийн бичгийн дарга нарын газарт хүргүүлсэн талаараа мэдэгдэнэ)-т хүргүүлнэ.

Конвенцийн 2011 оны 2-р сарын 17-ны No. 2011/019 тоот мэдэгдлийн дагуу жилийн тайлан бэлтгэх, хүргэх удирдамжийг баримтлан Талууд тайлангаа ирүүлдэг.

МОНГОЛ УЛСЫН МЭДЭЭ, ТАЙЛАН

Ховордсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийн гадаад худалдааг зохицуулах тухай хуулийн дагуу Конвенцийн хавсралтад орсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийг экспортлох, импортлох, ре-экспортлох зөвшөөрөл, далай тэнгисээс олборлох хүсэлтээ Удирдан зохицуулах зөвлөлд гаргана. Энэ зөвлөл уг хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэхдээ Байгаль орчны асуудал эрхэлсэн ЗГ-ын баталсан зөвшөөрөл, гэрчилгээний загварын дагуу зөвшөөрөл, гэрчилгээг олгодог. Конвенцийн Удирдан зохицуулах зөвлөлөөс Конвенцид нэгдсэн орсноос өнөөг хүртэл 955 гаруй экспорт, ре-экспортын зөвшөөрлийн гэрчилгээг 85 зүйлийн (график 1) амьтан, ургамлын гаралтай 189 төрлийн 50 мянга гаруй эд, зүйлсэд олгож, манай улсын хилээр 54 улс орон руу гарсан байна.

График 1. Монгол улсаас Конвенцийн зөвшөөрөлтэй гарсан амьтны зүйлийн тоо жилээр



Эдгээрээс хамгийн олон зөвшөөрлийг саарал чоно, аргаль, идлэг шонхорт олгосон байна (хүснэгт 1).

Хүснэгт 1. Монгол улсаас 1996 -2015 онд олгогдсон Конвенцийн экспортын зөвшөөрлийн тоо (амьтны зүйлээр)

No	Зүйлийн нэр	Зөвшөөрлийн тоо
1	Саарал чоно	295
2	Аргаль	263
3	Идлэг шонхор	83
4	Цармын бүргэд	30
5	Мануул	28
6	Хүрэн баавгай	23
7	Шилүүс	16
8	Цоохор ирвэс	16
9	Нөмрөг тас	15
10	Янгир	14
11	Бусад	166

Монгол улсаас олгосон дээрх зөвшөөрлөөр (хүснэгт 1) экспортолсон амьтан, тэдгээрийн эд, эрхтний тооноос харахад идлэг шонхор, хүрэн баавгай, саарал чоно, аргаль хамгийн олон бөгөөд эдгээрээс идлэг шонхорын 3,100 бодгаль амьдаар (график 3), чонын эд, эрхтний 1,123 нь арьс (график 2), харин хүрэн баавгайн эд, эрхтэн судалгааны дээжийн зориулалтаар, аргалийн хувьд тропи агнуур голлох хувийг эзэлж байна (хүснэгт 2).

Хүснэгт 2. Монгол улсын Конвенцийн зөвшөөрлөөр хамгийн олон тоогоор экспортолсон амьтны зүйл (1996 -2015)

No	Зүйлийн нэр	Эд эрхтний тоо хэмжээ (амьд бодгаль, бүтэн бие, арьс, үс, өд, бусад эд, эрхтэн зэрэг)
1	Идлэг шонхор	24,873
2	Хүрэн баавгай	3,402
3	Саарал чоно	2,708
4	Аргаль	2,369
5	Хонин тоодог	1,912
6	Цармын бүргэд	1,529
7	Хулан	980
8	Цоохор ирвэс	664
9	Мануул	527
10	Хүдэр	309
11	Бусад	2,098

Конвенцийн I хавсралтад орсон амьтдын дотроос хулан, хүрэн баавгайн экспортын хэмжээ тэргүүлэх хувийг эзэлнэ.

Конвенцийн II хавсралтад бүртгэлтэй амьтаас идлэг шонхор, саарал чоно, аргаль зэрэг амьтан хамгийн олон тоотой экспортлов. Энэ хугацаанд Монгол улсаас судалгааны зорилгоор нийт 44 зүйлийн амьтан, түүний дотор 13 зүйл хөхтөн, 31 зүйл шувууны 5,800 гаруй эд эрхтний дээжийг 155 гэрчилгээгээр гадаадад гаргав.

Агнуур, худалдааны зориулалтаар 31 зүйл ан, түүний дотор саарал чоно (график 2), аргаль хонь (график 4), мөн янгир ямаа, шилүүс, мануул, нөмрөг тас, тарважи бүргэд зэрэг экспортолсон.

График 2. Саарал чонон эд эрхтний худалдаа




График 3. Идлэг шонхорын худалдаа





График 4. Аргалийн худалдаа



Конвенцийн хавсралтад орсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийг экспортын зөвшөөрлийн гэрчилгээний мэдээ, баримтыг Конвенцийн албан ёсны веб сайтаас авч, энэхүү тайлангийн үндсэн баримт болголоо.

Конвенцийн хавсралтад орсон зүйлийн худалдааг хязгаарлахын тулд олон улсад худалдаалж болох дээд хэмжээг тогтоох тухай ямар нэг тусгай заалт байхгүй ч, Конвенцийн Талуудын 14-р бага хурлаар (The Hague, 2007) гадаад худалдааны тоо хэмжээ нь зэрлэг амьтан, ургамлын олон улсын худалдааны зохицуулалтанд үр дүнтэй арга мөн болохыг хэлэлцэж, тогтоол баталсан юм. Улс орон бүр ургамал, амьтны гадаадад гаргах тоо хэмжээг энэ Конвенцийн хавсралтад орсон зүйлүүдийн хувьд тогтоохдоо Конвенцийн Нарийн бичгийн дарга нарын газарт мэдээлж, тэд Талуудад эргэн мэдэгддэг.

Нарийн бичгийн дарга нарын газраас Монгол улсаас гадаадад гаргах тоо хэмжээг зарим амьтдад тогтооно. Конвенцийн Нарийн бичгийн дарга нарын газраас Монгол улсаас гадаадад гаргаж буй идлэг шонхорын тоонд анхаарал хандуулах шаардлагатай байгааг онцлон 2004-2009 онд манай улсын Конвенцийн Удирдан зохицуулах зөвлөлд идлэг шонхорын худалдаа, экспорттой холбоотой хэд хэдэн удаа мэдэгдэл ирүүлж байв. 2005 оны 8-р сард болсон “Торгоны зам ба Конвенцийн хууль эрх зүйн хэрэгжилт” сэдэвт уулзалтын үеэр манай улсыг идлэг шонхорын экспортоо зогсоохыг сануулж, улмаар Конвенцийн амьтны хорооны ажилтан ирж байдалтай нь танилцжээ (Конвенцийн хэрэгжилтийн байдалд хяналт шинжилгээ үнэлгээний танилцуулга, 2010). Конвенцийн амьтны хорооны 2006 оны 11-р сард зохион байгуулагдсан 21-р хурлаас Азийн 8 орон болон ОХУ-аас идлэг шонхор экспортлох зөвшөөрөл олгохыг түдгэлзүүлэх шаардлагатай болсныг зөвлөмж болгосны дотор манай улсыг багтаасан байв. Монгол улсаас Арабын орнуудад гаргаж буй идлэг шонхорын экспортыг хязгаарлахын тулд идлэг шонхорын менежмент болон хамгааллын статусын талаарх тайлан ирүүлэхийг Талуудын бага хурлаас Монгол улсад 2009 онд хүсэлт ирүүлсэн байна.

Конвенцийн Байнгын хорооны 2011 оны 61-р хуралдаанаар Монгол улсын идлэг шонхорыг хамгаалах, зохистой ашиглах талаар Засгийн газраас хэрэгжүүлж буй арга хэмжээний эерэг үр дүн, тоо толгойн судалгааны үр дүнг харгалзан Монгол улс 300 хүртэл тооны идлэг шонхор барьж экспортлож болохыг зөвшөөрсөн тухай Конвенцийн Амьтны хорооны 25-р хуралдааны шийдвэрийг баталсан. Үүний

дагуу Монгол улсын ЗГ нь 2011 оны 8-р сарын 17-ны өдрийн 251-р тогтоолоор 2011 онд гадаадад гаргах идлэг шонхорын тоог 240 толгой байхаар тогтоож, Кувейт, Катар, Саудын Араб, АНЭУ-ын дээд хэмжээний төлөөлөгч, бусад холбогдох хүмүүст 203 идлэг шонхорыг барих нийт 10 гэрээг байгуулав.

Конвенцийн Талуудын бага хурлын 2000 оны 4-р сард хуралдсан 11-р хурлаас хүдрийн худалдаа ба хамгааллын талаар Бага хурлын 11.7 тогтоол гарч, мөн хурал дээр Талууд хүдэртэй холбоотой шийдвэрүүдийг гаргаснаас Хятад, Франц, Солонгос, Герман, Энэхэг, Япон, Казакстан, Малайз, Непал, Сингапур, Монгол зэрэг оронд хуулийн хэрэгжилт, худалдаанд хяналт тавих, хүдрийн тоо толгойг хамгаалах үйл ажиллагааг сайжруулах зөвлөмж хүргүүлсэн ба Монголын тал хүдэр агнахыг хуулиар хориглосон тухай тайланг хүргүүлжээ.

Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийг хил дамнуулан худалдах олон улсын хууль бус худалдааг хянах үүрэг бүхий ХХЕГ болон ГЕГ-аас авсан хууль бусаар хил давуулахыг завдсан ангийн болон байгалийн гаралтай эд зүйлийн судалгаанаас (хавсралт 2) үзэхэд 2002-2014 онд (эхний хагас жил) манай улсын хилээр хууль бусаар хил давуулахыг завдаж, баригдсан амьтан, ургамлын дотор хүрэн баавгай (савар, доньд), саарал чоно (бүхлээр хөлдөөсөн, арьс, соёо, ходоод, хэл), мануул, Монгол тарвага, үнэг, хярсны арьс, харин ургамлаас хушны самар, цагаан гоёо, дэрэвгэр жирэвгэр зонхилж байсан. 2015-2017 онд (график 5-7) саарал чоно, түүний эд эрхтэн, цагаан зээр, хүрэн баавгайн савар доньд, тарвага, үнэг, хярсны арьс, халиун бугын эвэр, ургамлаас цагаан гоёо зэргийг хууль бусаар хил давуулахыг завдсан ч хураагдсан байна.

Дэлхийн банкны санхүүжилтээр 2006 онд БЗАХН-ийн “Зэлүүд тал-Монголын ан агнуурын хууль бус худалдааны хямралтай асуудлууд” судалгаагаар Монгол улсын зэрлэг ан амьтдын худалдааны гол хэсгийг үслэг ангийн олон улсын худалдаа бүрдүүлэх боловч ангийн мах, эмчилгээний зориулалттай дотоод, гадаадын худалдаа ихэссэн гэж дүгнэсэн бол 2016 оны Зэлүүд тал -2 судалгаагаар ахуйн хэрэглээнд загас агнуур нэлээд хувийг эзлэх болсон байна.

Зэрлэг ан амьтдын дотор тоо хэмжээ болон үнийн хувьд томоохон байр суурь эзэлдэг үслэг ан нь БНХАУ, ОХУ төдийгүй дотоодын зах зээлд тодорхой хэмжээгээр борлуулагддаг. Үслэг ангийн худалдаанд өртдөг олон зүйл амьтан бий. Үүнд: Монгол болон Алтайн тарвага, саарал чоно, үнэг, хярс, хэрэм, цоохор ирвэс, хүрэн баавгай, шилүүс ба мануул зэрэг болно. Дараах амьтдын арьсыг бага хэмжээгээр худалддаг. Үүнд: халздай дорго, усны булга, солонго, өмхий хүрнэ, бор туулай, заарт харх, жирх, бор гөрөөс орно. Үслэг эдийн худалдаанд дангаараа дийлэнх хувийг эзэлдэг зүйл нь Монгол ба Алтайн тарвага юм. Цоохор ирвэс зэрэг ховордлын зэрэглэлтэй амьтдыг цөөн тоотойгоор худалдаж байна. Иймэрхүү төрлийн худалдааг хянаж, өртсөн зүйлийн бодгалийн тоог тогтооход бэрхшээлтэй. Монголд хулгайгаар агнасан ирвэсний 13 ширхэг арьсыг Хятадын баруун хилийн жижиг хотоос ирсэн иргэд худалдан авч, гадаад руу гаргахаар төлөвлөж байсныг цагдаагийн байгууллага таслан зогсоов. Мөн 2005 оны зун Оросын хилчид Монголын баруун хойд хилээр гарсан ирвэсний 15 ширхэг арьсыг хураасан. Монголын зэрлэг ан амьтны худалдаанд Монгол тарвага, хярс, үнэг, цагаан зээр, бор гөрөөс, хэрэм тэргүүлэх байр суурьтай. Монголын зэрлэг амьтны худалдаанд чоно голлох үүрэгтэй ч түүний агналтын тухай мэдээ бодитой биш учир үнэлэлт дүгнэлт өгөхөд бэрхшээлтэй.

Эмчилгээний зориулалтаар хэрэглэдэг зэрлэг ан амьтны эд, эрхтний худалдаа дотоод болон олон улсын зах зээл дээр өссөөр байна. Худалдааны хамгийн гол түнш - Хятад, Солонгос улс руу зэрлэг ан амьтны эд, эрхтнийг их хэмжээгээр худалддаг. Олон улсын зах зээлийн худалдан авагчид нь ихэвчлэн хүрэн баавгайн цөс (доньд), бөхөнгийн эвэр, чонын бүх эрхтэн (хэл, дэлүү, шагай, шүд гэх мэт), мөн хүдрийн заар, бугын яс болон цусан эвэр, сав, сүүл, үр хөврөл болон ирвэсний яс зэргийг эрэлхийлдэг. Ангийн махны худалдаа (загаснаас бусад) одоогоор дотоодын зах зээлд бага хувийг эзэлдэг. Цагаан зээрийн махыг Хятад улс руу худалдаж байсан боловч Монгол улс үйлдвэрлэлийн зориулалтаар амьтдыг агнахыг хориглосноос хойш Хятадын ангийн мах боловсруулдаг үйлдвэрүүд хаагдаж, Монгол улс 1990-ээд оны эхэнд Оросын зах зээлд загас нийлүүлдэг байснаа Хятадын

зах зээл дээр загасны үнэ нэмэгдсэн тул Хятад руу ихээр худалдах болов. Олон улсын ангийн махны худалдаа багасч байгаа ч дотоодын зах зээл дэх ангийн махны арилжаа өссөнөөр зарим зэрлэг амьтны популяцийн тоо толгой буурч байна. Монгол болон Алтайн тарвага, цагаан зээр, бор гөрөөс, хандгай зэрэг хөхтөн, Алтайн хойлог, зарим загас, орон нутагт хулангийн махны худалдаа дотоодын зах зээл дээр өсөх хандлагатай болов.

Дээрх судалгаагаар Монгол улсад дараах 5 төрлийн худалдааны идэвхтэй сүлжээ байгааг олж тогтоов. Үүнд: (1) хулгайн анчид дотоодын эцсийн хэрэглэгчдэд шууд нийлүүлэх; (2) анчид дотоодын зах зээлд нийлүүлэх; (3) анчид дотоодын боловсруулагчдад нийлүүлэх; (4) анчид хил дамжсан зах зээлд нийлүүлэх; (5) анчид олон улсын худалдааны сүлжээнд нийлүүлэх. Идлэг шонхорын хууль бус экспорт хийх оролдлогууд олноор бүртгэгдэж байгаа бөгөөд нийт 7 тохиолдлын 43 идлэг шонхорыг байгальд нь буцаан сулласан. Зөвшөөрөлгүйгээр 4 идлэг шонхорыг гаргахыг завдсан нэгэн гадаадын иргэнийг Сингапураас баривчилсан ба мөн гадаадын 2 иргэн 12 идлэг шонхорыг машинаар Монголоос Тува руу авч гарахыг оролдсон байна. Хууль бус экспортын үйл ажиллагааг илрүүлж буй нь Конвенцийн талуудын хамтын ажиллагааны үр дүн юм.

Монгол улсын ЗГ нь 1994 оноос дээд хэмжээний төлөөлөгчдийн хүсэлтийн дагуу Арабын орнуудад гэрээгээр 2000-2010 онд нийтдээ 2,751 толгой идлэг шонхорыг худалдаж, улс, орон нутгийн төсөвт 18.4 сая ам. доллар төвлөрүүлжээ.

Идлэг шонхор бариулах экспортлох үйл ажиллагааг журамлах, цэгцлэх зорилгоор "Монгол улсын нутаг дэвсгэр дээр идлэг шонхор амьдаар нь барих, тээвэрлэх, арчлах, экспортод гаргах үйл ажиллагаанд мөрдөх журам"-ыг БОАЖ-ын Сайдын 2010 оны А-205 тушаалаар батлан, талуудын оролцоо, идлэг шонхор барих, арчлах, маллах, тээвэрлэх, экспорлох үйл ажиллагааг хуулийн дагуу гүйцэтгэх боломжийг бүрдүүлэв.

МХЕГ-ын мэдээлснээр 2009-2014 оны эхний 5 сарын байдлаар 136 бөхөн, 209 буга, 18 баавгай, 6 хар сүүлт зээр хууль бус агнуурын 10 хүнд холбогдох хэрэг цагдаагийн байгууллагад шилжин шалгагджээ. Мөн түүнчлэн Алтайн хойлог

2, загасны хэрэгсэл 25, тарваганы арьс 50,800, үнэгний арьс 702, хярсны арьс 1,000, хөлдөөсөн чоно 304, шилүүсний арьс 1, мануулын арьс 1 ширхэгийг улсын орлого болгон хураав. Дээрх хугацаанд хууль бус ан агнуурын улмаас байгальд 479,914,000 төгрөгийн хохирол учирсан болохыг МХЕГ-аас мэдээлжээ.

ЦЕГ-ын өгсөн албан ёсны баримтаар улсын хэмжээнд 2011-2014 оны эхний хагаст Эрүүгийн хуулийн 203-р зүйлийг зөрчсөн 132 гэмт хэрэг бүртгэгдэв. Энэхүү мэдээллийг УМХЕГ-ын мэдээтэй нэгтгэн харахад (Бадамханд, 2014) дээрх хугацаанд Конвенцийн хавсралтад орсон чоно, бөхөн, хулан, хүрэн баавгай, хүдэр, шилүүс, ирвэс зэрэг 8 зүйл хулгайн агнуурт ихээр өртөж байсан бол 2015-2018 оны баримтаар Монгол тарвага, хярс, цагаан зээр, халиун буга, саарал чонон хууль бус агнуур ихэсч (график 5), Монгол улсын нэн ховор, ховор амьтан, Конвенцийн жагсаалтад орсон хулан, янгир, хүрэн баавгай, аргаль, хандгай, ирвэс зэрэг зүйл (график 6 ба 7) агнуурт өртсөөр байна.

Загасны хууль бус агнуур сүүлийн жилүүдэд нэмэгдсэн ба бүх сугас, Монгол хадран, зэвэг ихэвчлэн өртдөг ба тул загас барьсан тохиолдол мөн тэмдэглэгдсэн байна.

График 5. Хууль бус ан агнуурт хамгийн ихээр өртөж буй зүйлүүд (2015-2017)




График 6. Агнуурт өртөж буй нэн ховор, ховор зүйл (2015-2017)





График 7. Конвенцийн хавсралтад бүртгэлтэй хууль бус худалдаанд өртсөн зүйл (2015-2018)



Эдгээр баримт нь зөвхөн хууль, хяналтын байгууллагад бүртгэгдсэн буюу илэрсэн тоо юм. Монгол улс төлөвлөгөөт эдийн засгийн тогтолцооны үед ан агнуурын гаралтай бүтээгдэхүүнийг хүнс, ахуйн хэрэглээнд хэрэглэх зорилгоор агнадаг байсан бол 1990 оны зах зээлийн шилжилтийн үеийн эдийн засгийн хямралаас шалтгаалан хүн амын амьжиргааны түвшин буурсан, ажилгүйдэл ихэссэн, хууль хяналтын систем суларсан, том зах зээлтэй Хятад улстай зах зээлийн чөлөөт харилцаатай болсон зэрэг хүчин зүйлээс шалтгаалан байгалийн баялаг, ялангуяа эмийн болон тансаг хэрэглээний зориулалтаар ховордсон амьтан, ургамлын тэдгээрийн эд, эрхтнийг хууль бусаар худалдаалж, ашиглах боллоо. Тухайлбал, 2005 оны тооллогоор 5,000 байсан монгол бөхөн таван жилийн дараа 800 болж (85 хувиар) буурсан нь Хятадын эм, эмнэлгийн зах зээлд бөхөнгийн эврийн хэрэгцээ өссөн (Zahler et al., 2004), мөн байгалийн тохиромжгүй нөлөө зэрэг олон хүчин зүйлсээс шалтгаалжээ. ДБХС-гийн Монгол дахь төлөөлөгчийн газрын хууль бус агнууртай тэмцэх “Ирвэс -1” багийн тайланд 2002- 2004 онд Баян-Өлгий, Ховд, Увс аймгийн барааны зах дээр 15-20 ирвэсний арьс, 700 орчим алтайн хойлог зарагдсаныг тогтоожээ. Тус байгууллагаас 2002 оны хүдрийн заарын худалдаанд судалгаа хийхэд жилд дунджаар 2,400-3,000 хүдрийн заар хууль бусаар худалдсан болохыг тогтоов (ДБХС, 2007).

БЗАХН-ээс 2006 онд Дэлхийн банкны санхүүжилтээр зохион байгуулсан “Ан амьтны түүхий эд, бүтээгдэхүүний худалдааны шуурхай үнэлгээ”-ээр манай улсад жилд 100 сая орчим америк долларын ангийн гаралтай түүхий эд бүтээгдэхүүний худалдаа гэж тогтоожээ.

Монгол улсын Зар сурталчилгааны хуулийн хэрэгжилтэй холбоотойгоор олон нийтийн мэдээллийн хэрэгсэлд хийсэн судалгаагаар (Ан амьтны гаралтай бүтээгдэхүүний худалдааны заруудад хийсэн судалгааны тайлан, 2008) олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл нь ан амьтны гаралтай бүтээгдэхүүнийг зарж борлуулах, худалдан авах мэдээллийн үндсэн эх сурвалж болж байгааг харуулжээ. Тэр дундаа Монгол орны Улаан данс, Улаан ном болон энэхүү Конвенцийн хавсралтад орсон зарим ховордсон амьтад (хулан, зэрлэг гахай, хүрэн баавгай, шилүүс, халиун буга, мануул, Алтайн хойлог, тарважи бүргэд, саарал чоно гэх мэт)-ыг зарах, худалдаж авах тухай зар телевиз, сонинд олноор гарсан байжээ.

ХОВОР АМЬТАН, УРГАМАЛ ХАМГААЛАХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР

Монгол улсын ЗГ-аас Монгол орны ховор ургамлын удмын санг хамгаалах, тэдгээрийн тархац нутгийг орон нутгийн тусгай хамгаалалтанд авах, нөхөн сэргээх, үржүүлэх боломжийг судлах зорилго бүхий “Монгол орны ховор ургамлыг зохистой ашиглах үйл ажиллагааны хөтөлбөр”-ийг 2002-2010 онд хэрэгжүүлсэн байна. Энэхүү хөтөлбөрийг шинэчлэн “Байгалийн ургамлыг хамгаалах үндэсний хөтөлбөр”-ийг боловсруулан, уг хөтөлбөрийг 2013-2021 онд хэрэгжүүлэхээр ажиллаж байна.

ЗГ, сайдын тушаалаар өмнөх жилүүдэд ховордсон амьтдыг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх зорилготой “Халиун буга хамгаалах үндэсний хөтөлбөр” (2000), “Аргаль хамгаалах үндэсний хөтөлбөр” (2002), “Баданга хүдэр хамгаалах үндэсний хөтөлбөр” (2009), “Бөхөн хамгаалах үндэсний хөтөлбөр”, “Мазаалай хамгаалах үндэсний хөтөлбөр” (2013-2018)-ийг боловсруулан хэрэгжүүлснээс гадна, Байгаль Орчны Сайдын (хуучин нэрээр) 2005 оны 195-р тушаалаар “Цоохор ирвэс үндэсний хөтөлбөр”-ийг 2005-2010 онд, ЗГ-ын 2003 оны 121-р тогтоолоор “Монгол орны идлэг шонхорыг хамгаалах үндэсний хөтөлбөр”-ийг 2005-2010 онд хэрэгжүүлж, эдгээр хөтөлбөр нь 2010 онд дууссантай холбогдуулан Монгол улсын ЗГ-ын 2011 оны 277-р тогтоолоор “Нэн ховор, ховор амьтдыг хамгаалах үндэсний хөтөлбөр”-ийг батлав. ЗГ-ын 82 дугаар тогтоолоор баталсан “Монголын ховор амьтныг хамгаалах үндэсний комисс”-ийг “Монголын амьтан, ургамал хамгаалах үндэсний хороо” болгов.

ЧАДАВХ БЭХЖҮҮЛЭХ ТАЛААР ГҮЙЦЭТГЭСЭН АЖИЛ

Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлсийн худалдаанд байгаль хамгаалал, мал эмнэлэг, ургамлын хорио цээрийн алба, хууль сахиулах байгууллага, мэргэжлийн хяналтын газар, хил хамгаалах, гаалийн байгууллага хяналт тавин ажиллаж байна. Эдгээр байгууллагын ажилтнуудын хууль, эрх зүйн мэдлэг, олон улсын гэрээ хэлэлцээрийн талаарх ойлголт, Конвенцийн хавсралтад бүртгэгдсэн амьтан, ургамал, тэдгээрийн эд зүйлийг таних, тодорхойлох, илрүүлэх мэдлэг, үр чадвар өндөр байх тутам Конвенцийн хэрэгжилтэнд тавих хяналт сайжирч, худалдааны зорилго бүхий хууль бус ан агнуурыг хазаарлах, ховордсон амьтан ба ургамлаа олон улсын хэмжээнд хийгдэж буй худалдааны улмаас устахаас сэргийлэх, мөн бусад улс орны хувьд ховордсон зүйлийг хамгаалахад туслах, Монгол улсын олон улсын гэрээнд хүлээсэн үүргээ амжилттай гүйцэтгэн, эх болсон байгаль орчин, амьтан, ургамлаа хадгалж, хамгаалж чадна. Дээрх зорилго, чиглэлтэй холбоотой ажилтнуудын үр чадварыг дээшлүүлэх, чадавхжуулах тодорхой ажлуудыг төрийн болон төрийн бус байгууллагууд гүйцэтгэж, оролцож, хамтран зохион байгуулж байна.

Манай улсын ЦЕГ, ГЕГ болон ДБХС-гийн ажилтнууд Малайзын Куала Лумпур хотод 2014 онд зохион байгуулсан “Конвенцийн барих бодлого ба ховор зүйлийн эрхтэн, эд зүйлийг таних, тодорхойлох сургагч багш бэлтгэх” сургалтанд оролцсон байна. Уг сургалтанд хамрагдснаар цаашид сургагч багш болж, улмаар бусад талуудтай хамтран энэ төрлийн сургалтыг улс орондоо зохион байгуулах боломжтой боллоо (ДБХС, 2014).

БОАЖЯ-наас (хуучин нэрээр) Конвенцийн хэрэгжилтэнд хяналт тавих үүрэг бүхий ажилтан нарын дадлага, ажлын арга зүй, танин мэдэхүйн түвшинг дээшлүүлэх зорилгоор байгаль орчны албаны ажилтан, улсын байцаагчид, орон нутгийн гааль, хилийн хяналтын албаны ажилтнуудад семинарыг 2000 онд Японы Жайка байгууллагын санхүүгийн дэмжлэгээр Улаанбаатар хотод, ДБХС-гийн хөтөлбөрийн газрын дэмжлэгээр 2002 онд Увс, 2004 онд Баян-Өлгий аймагт, Конвенцийн хэрэгжилтийн талаарх уулзалт ярилцлагыг БОНХЯ дээр 2008 онд зохион байгуулсан.

“Амьтан, ургамал тэдгээрийн гаралтай эд зүйлийн хууль бус худалдааг бууруулахад хууль хяналтын байгууллагын хамтын оролцоог

нэмэгдүүлэх” хөдөлгөөнт сургалтыг ХЗДХ болон БОАЖ-ын сайдын 2008 оны хамтарсан 102/132 дугаар тушаалын хүрээнд ДБХС-гийн санхүүгийн дэмжлэгтэйгээр 2008 онд Увс аймаг дахь Боршоо, Баян-Өлгий аймаг дахь Цагаан нуур, Ховд аймаг дахь Ярант, Говь-Алтай аймаг дахь Бургастайн хилийн боомтод зохион байгуулжээ. Энэхүү сургалт нь дараах зорилгыг агуулсан байв. Үүнд:

- о Зэрлэг амьтан, ургамлын түүхий эд тэдгээрийн гаралтай бүтээгдэхүүний хууль бус худалдааны зөрчлийн илрүүлэлтийг нэмэгдүүлэх.

- о Сургалтанд олон талын байгууллага оролцсоноор бие биенээсээ суралцах.

- о Хилийн боомтод ажиллаж байгаа хил хамгаалах алба, гааль, мэргэжлийн хяналтын хамтран ажиллах боломжийг нээх.

- о Албан хаагчдын ажлын ур чадварыг нэмэгдүүлэх зэрэг болно.

Сургалтыг ХЗДХЯ-ны Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл, ХХЕГ-ын Хилийн Хяналтын Ерөнхий Газрын Хилийн цэргийн штабын Мэргэжил удирдлагын газрын Хил хамгааллын хэлтэс, УМХЕГ-ын Хилийн мэргэжлийн улсын алба, ЦЕГ, Гаалийн эдийн засгийн дээд сургууль, Конвенцийн Удирдан зохицуулах зөвлөл, ДБХС-ийн Монгол дахь хөтөлбөрийн газар, Алтай Саяны экобус нутгийн биологийн төрөл зүйлийг ард иргэдийн оролцоотой хамгаалах төслийн Увс дахь салбар, Байгаль орчны ноцтой зөрчилтэй тэмцэх Ирвэс шуурхай баг зэрэг олон газрууд хамтран амжилттай зохион байгууллаа. Сургалтанд нэр заасан улсын хилийн 4 боомтын нийт 120 гаруй хүн, Увс, Ховд, Баян-Өлгий, Говь-Алтай аймгийн төвд зохион байгуулагдсан сургалт-семинарт 110 орчим оролцогч хамрагджээ (ГЕГ, 2014).

Конвенцийн Удирдан зохицуулах зөвлөлийн гишүүд болон Конвенцийн хэрэгжилттэй холбоотой ажил, үүрэг хариуцдаг ажилтан нар уг сэдвээр зохион байгуулагдсан олон улсын семинар, сургалтуудад тогтмол оролцож байв. Тухайлбал, 2005 онд БНХАУ-ын Өрөмчид, 2007 онд мөн улсын Харбинд, мөн оны сүүлээр ОХУ-ын Новосибирск хотод зохион байгуулсан хурал, семинар болон 2006 онд Казахстаны Алмата хотод зохион байгуулсан бөхөн хамгаалах олон улсын уулзалтанд оролцож, санал солилцож байжээ (Конвенцийн хэрэгжилтийн байдалд хяналт шинжилгээ үнэлгээний танилцуулга, 2010).

КОНВЕНЦИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХТЭЙ ХОЛБОГДОН ГАРСАН БҮТЭЭЛ

Конвенцийг хэрэгжүүлэхтэй холбогдсон хэд хэдэн бүтээл Монгол хэлнээ хэвлэгджээ. Эдгээр бүтээлийн зонхилох нь манай орноос энэхүү Конвенцийн хавсралтад бүртгэгдсэн амьтдын тухай ерөнхий мэдээ, баримтыг агуулсан байна.

Конвенцийн хавсралтад орсон зэрлэг амьтан ба ургамал, тэдгээрийн эд эрхтнийг таних тодорхойлох гарын авлагыг 2001 онд Японы ЗГ-ын санхүүжилтээр хэвлүүлснээс хойш Конвенцийн үйл ажиллагаатай холбоотой олон томоохон бүтээл 2006-2018 онд гарчээ.

ЛАСН, МУИС, БОАЖЯ, МШСН хамтран Конвенцийн хэрэгжилтийг Талуудын бага хурлын шийдвэрийн хэрэгжилттэй харьцуулсан анхны тайланг 2014 онд Монгол, англи хэлээр хэвлэв (Мягмарсүрэн нар, 2014).

ЛАСН-ээс зэрлэг амьтны хууль бус худалдааны өнөөгийн нөхцөл байдлыг тодорхойлох, 2006 онд хийгдсэн “Зэлүүд тал: Монголын ан амьтны хууль бус худалдааны хямралтай асуудал” судалгааг хийгдснээс хойш энэ байдалд гарч буй өөрчлөлтийг үнэлэх зорилгоор “Зэлүүд тал II: Монголын ан амьтны хууль бус худалдааны хямралтай асуудал 10 жилийн дараа” судалгааны тайлан боловсруулав (Wingard et al., 2017).

ЛАСН нь Хууль хяналтын ажилтнуудын чадавхийг бэхжүүлэх, ан амьтны эд, эрхтэн, тэдгээрийн гаралтай бүтээгдэхүүнийг таних, тодорхойлох гарын авлагыг 2017, 2018 онд хэвлүүлсэн. Энэхүү бүтээлд Монгол орны хулгайн агнуурт ихээр өртдөг 70 гаруй зүйл амьтан, 10 орчим ургамлын мэдээллийг багтаав (Гомбобаатар, Мягмарсүрэн, 2018).

БОАЖЯ, Конвенцийн Үндэсний зохицуулах зөвлөл, Монгол улсад Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл, ДБХС, МУИС, МШСН зэрэг байгууллагууд хамтран ажиллаж “Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай Конвенцийн лавлах”-ыг 2018 онд баяжуулан гаргалаа (Гомбобаатар, Мягмарсүрэн, 2017, 2018).

БОАЖЯ, ДБХС-гийн Монгол дахь хөтөлбөрийн газар, МУИС болон Монгол улсад Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл хамтран 2001 онд хэвлэгдсэн энэ Конвенцийн лавлахыг шинэчлэв (Чимэддорж нар, 2018). Дээрх бүтээлүүдийн талаарх мэдээ, баримтууд хавсралт 6-д бий.

МОНГОЛ УЛС ДАХЬ ТАЛУУДЫН БАГА ХУРЛААС ГАРСАН ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТ

НҮБ-ын Байгаль орчны хөтөлбөр болон Олон улсын Интерпол байгууллагын судалгаагаар зэрлэг амьтны болон ойн хууль бус бэлтгэл сүүлийн жилүүдэд эрс нэмэгдэн жилд 200 гаруй тэрбум ам.долларын хэмжээнд хүрсэн гэсэн тооцоо гарсан байна. Зэрлэг амьтны хууль бус худалдаа нь нэг улс орны хүрээнээс хэтэрч улс хоорондын болон тив дамнан өргөжих болжээ. Уг асуудлыг олон улсын аюулгүй байдлын болон тогтвортой хөгжлийн тулгамдсан асуудлын нэг гэж үзэж НҮБ-ын Аюулгүйн зөвлөл болон НҮБ-ын Тогтвортой хөгжлийн бага хурал зэрэг өндөр түвшинд хэлэлцэж, холбогдох шийдвэрүүдийг гаргасан байна. Герман, Габон зэрэг улс санаачлан зэрлэг амьтны хууль бус худалдааг таслан зогсоох чиглэлээр НҮБ-ын Ерөнхий Ассамблейн тогтоолын төсөл боловсруулж байна.

хийж эхэлснээс хойш 2015 онд “Зэрлэг амьтны эсрэг гэмт хэргийн төлөө анхаарал хандуулья” гэсэн уриатай, 2016 онд ногоон бүсийн зэрлэг амьтдыг хавхаар барьж гэмтээдэг, урхи тавьж хууль бусаар агнадаг зөрчлийг арилгах, урьдчилан сэргийлэх зорилготой “Хавхгүй нийслэл” аян, хадгийг модонд зүүж гэмтээдэг, орчныг бохирдуулдаг явдлаас сэргийлэх зорилготой “Хадгаа дээдлээ, байгалиа хамгаалъя” уриалгыг Гандантэгчинлэн хийд, Бөөгийн нэгдсэн эвлэлтэй хамтран, нийслэлд өвөлждөг шувуудын тоолмог, шувуу сонирхогчдын танин мэдэхүйн сургалтыг Шувуу хамгаалах төвтэй хамтран зохион байгуулж, ногоон бүсийн зэрлэг амьтдад өвс тэжээл, хужир мараа тавьж өгөх зэрэг байгууллага бүр олон үйл ажиллагааг зохион байгуулж иргэдэд мэдээлэл түгээж байна.

ТАЛУУДЫН БАГА ХУРЛЫН 17-Р ХУРАЛДААН

ТБХ 17.1. ЗЭРЛЭГ АМЬТАН ХАМГААЛАХ ДЭЛХИЙН ӨДӨР. ТБХ-аас гарсан шийдвэр: Жил бүрийн 3-р сарын 3-ны өдрийг Зэрлэг амьтан хамгаалах өдөр болгон зарлан тунхаглав. Талууд болон Конвенцийн Нарийн бичгийн дарга нарын газар, НҮБ-ын Байгаль орчны хөтөлбөр, олон улсын болон бүс нутгийн төрийн бус байгууллагуудыг Зэрлэг амьтан хамгаалах дэлхийн өдөр болох 3-р сарын 3-ны өдөрт зэрлэг амьтны төлөө үйл ажиллагаа зохион байгуулах, мэдээлэл солилцон оролцохыг уриалжээ.

ХЭРЭГЖҮҮЛСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА, АРГА ХЭМЖЭЭ: Монгол улс 2014 оноос жил бүрийн 3-р сарын 3-ныг “Байгалийн амьтан, ургамлын дэлхийн өдөр” гэж зарлаж, “Амьд амьтнаар бахархъя” сэдвээр уг өдрийг тэмдэглэж, цахим ертөнцөөр амьтан, ургамлын экологийн үнэ цэнийг харуулсан сурталчилгааг

ТБХ 17.4 КОНВЕНЦИЙН ЖАГСААЛТАД ОРСОН ЗҮЙЛҮҮДИЙГ ХУУЛЬ БУС ХУДАЛДААТАЙ ТЭМЦЭХЭД ЭРЭЛТИЙГ БУУРУУЛАХ СТРАТЕГИ БОЛОВСРУУЛАХ.

Талууд зэрлэг амьтан, ургамлын хууль бус худалдааны эрэлтийг бууруулах стратеги боловсруулах, бодлого, эрх зүйн орчин, хуулийн хэрэгжилтийг сайруулах, хамтран ажиллах, иргэдийн дунд сургалт, сурталчилгааг явуулах

ХЭРЭГЖҮҮЛСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА, АРГА ХЭМЖЭЭ: БЗАХН нь талуудыг оролцуулан Конвенцид бүртгэлтэй зүйлийн хууль бус худалдааг бууруулах чиглэлээр үндэсний стратегийн төлөвлөгөө боловсруулахаар хамтран ажиллаж байна.

ТБХ 17.5 ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУДЫН ОРОЛЦООГ НЭМЭГДҮҮЛЭХ. Талууд байгаль, зэрлэг амьтан хамгааллын үйл ажиллагаанд залуу үеийг татан оролцуулах, их дээд сургууль, хүүхэд залуучуудын байгууллагуудтай хамтран ажиллах, Конвенцийн уулзалтанд тэдний төлөөллийг оролцуулахыг уриалж байна.

ХЭРЭГЖҮҮЛСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА, АРГА

ХЭМЖЭЭ: Монгол улсад үйл ажиллагаа явуулж буй олон улсын байгууллагууд болон ТББ-д хүүхэд залуучуудад хандсан, тэдний үйл ажиллагаандаа татан оролцуулсан томоохон ажлыг дурьдвал ДБХС-гаас ерөнхий боловсролын сургуулиудад Эко клубыг байгуулан байгаль зэрлэг амьтан хамгаалах ойлголтыг өгч, үе тэнгийхэндээ сургах, нөлөөлөх ажлуудыг амжилттай хийж байна.

**ТБХ 17.7 ТЭЖЭЭМЭЛ НӨХЦӨЛД
ГАРГАН АВСАН АМЬТДЫН ХУДАЛДААНЫ
МАГАДЛАГАА.**
ХЭРЭГЖҮҮЛСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА,

АРГА ХЭМЖЭЭ: 2015-2017 онд жил тус бүр 4 тахь нийт 16 тахь дахин нутагшуулах зорилгоор Прагийн амьтны хүрээлэнгээс Монгол улсад оруулж ирэв. Сүүлийн 2 жилийн зэрлэг амьтны худалдааны мэдээгээр нийт 9 удаагийн *Panthera tigris*, *Panthera leo*-г амьдаар циркийн зориулалтаар, Жороо тоодог *Chlamydotis undulata* бүтэн биенийг судалгааны зорилгоор Burmese python (*Python bivittatus*)-ны бэлэн бүтээгдэхүүн худалдааны зорилгоор, хүдрийн цусны дээжийг судалгааны зорилгоор гаршуулан тэжээсэн гэсэн эх сурвалжтай экспорт болон импортын магадлагаа хийгдсэн байна.


**ТБХ 17.8 ХУУЛЬ БУС ХУДАЛДААНААС
ХУРААГДСАН КОНВЕНЦИЙН ХАВСРАЛТАД
БҮРТГЭЛТЭЙ ЗҮЙЛҮҮД ЭД ЗҮЙЛИЙГ
УСТГАХ.**

Хууль бус худалдааг илрүүлсэн тохиолдол хил нэвтрүүлсэн тухайн улсын Удирдан зохицуулах зөвлөл мэдээлж, хууль зөрчсөний эсрэг зохих хуулийн арга хэмжээг хэрэгжүүлэх, хууль бус худалдаанаас хураагдсан Конвенцийн хавсралтад бүртгэлтэй зэрлэг амьтны гаралтай бүтээгдэхүүнийг устгалд оруулахдаа конвенцийн зорилгод нийцсэн дараагийн хууль бус худалдааг дэмжихээс сэргийлэх.

ХЭРЭГЖҮҮЛСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА,

АРГА ХЭМЖЭЭ: Энэ чиглэлээр хуулийн байгууллагуудад доор бүртээ үйл ажиллагаа гүйцэтгэж ирсэн болов ч нэгдсэн мэдээллийн сан, албан ёсны баримтууд олон нийтэд тараагүй.

**ТБХ 17.9 ХАВСРАЛТ 1 БА 2-Т БҮРТГЭЛТЭЙ
ЗҮЙЛҮҮДИЙН АГНУУР.**
ХЭРЭГЖҮҮЛСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА, АРГА

ХЭМЖЭЭ: 2015-2017 онд Монгол улсаас агнуурын зориулалтаар саарал чонын 7, аргалийн 134, янгирын 126 бодгалийг гадаадын анчид агнаж, экспорложээ (график 8).

График 8. Монгол улсаас экспортолсон агнуурын баримт (2015-2017)



ТАЛУУДЫН БАГА ХУРЛЫН 16-Р ХУРАЛДААН

ТБХ. 16.1. ЗЭРЛЭГ АМЬТАН ХАМГААЛАХ ДЭЛХИЙН ӨДӨР

Жил бүрийн 3-р сарын 3-ны өдрийг Зэрлэг амьтан хамгаалах өдөр болгон зарлан тунхаглав. Талууд болон Конвенцийн Нарийн бичгийн дарга нарын газар, НҮБ-ын Байгаль орчны хөтөлбөр, олон улсын болон бүс нутгийн төрийн бус байгууллагуудыг Зэрлэг амьтан хамгаалах дэлхийн өдөр болох 3-р сарын 3-ны өдөр зэрлэг амьтны төлөө үйл ажиллагаа зохион байгуулах, мэдээлэл солилцох.

ХЭРЭГЖҮҮЛСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА, АРГА

ХЭМЖЭЭ: Монгол улс 2014 оны 3-р сарын 3-ныг “Байгалийн амьтан, ургамлын дэлхийн өдөр”-өөр зарлаж, “Амьд амьтнаар бахархал” сэдвээр уг өдрийг тэмдэглэх, цахим ертөнцөөр амьтан, ургамлын экологийн үнэ цэнийг харуулсан сурталчилгааг хийж эхлэв.

ТБХ. 16.3 КОНВЕНЦИЙН 2008-2020 ОНЫ СТРАТЕГИ ЗОРИЛТ.

Зорилго 1: Конвенцийн үйл ажиллагааны хэрэгжилт болон Конвенцийг дэмжих хуулийн биелэлтийг хангах;
Зорилго 2: Конвенцийн үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд шаардлагатай арга барил, санхүүгийн найдвартай байдлыг хангах;
Зорилго 3: Конвенцийн үйл ажиллагааг болон өөр бусад уялдаа холбоотой, харилцан ойлголцол дээр үндэслэсэн олон талуудын оролцоотой үйл ажиллагаа, арга хэмжээг хэрэгжүүлснээр биологийн олон янз байдлын алдагдлыг бууруулах болон дэлхий нийтээрээ хүлээн зөвшөөрсөн бусад холбогдох зорилго, зорилтод хүрэхэд хувь нэмэр оруулах.

ХЭРЭГЖҮҮЛСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА, АРГА

ХЭМЖЭЭ: Конвенцийн хүрээнд гүйцэтгэж буй үйл ажиллагаа, Конвенцийн биелэлтийг дүгнэж, цаашдын гүйцэтгэх үйл ажиллагаа, шийдвэрээ тодорхойлох нь энэ тайлангийн үндсэн зорилго болно. Конвенцийн стратегийн зорилтын биелэлтийг бүлэг тус бүрээр энэхүү тайлангаас үзэж болно.

ТБХ 16.4 КОНВЕНЦ БОЛОН БУСАД ХОЛБОГДОХ КОНВЕНЦИУДЫН ХООРОНДЫН ХАМТЫН АЖИЛЛАГАА.

ТАЛУУДАД САНАЛ БОЛГОХ: Биологийн олон янз байдлыг дэмжиж буй өөрийн орны бусад конвенциудын удирдах нэгж, бусад хамтрагч нартай Конвенцийг үндэсний хэмжээнд харилцан уялдаатай хэрэгжүүлэх үндэсний хэмжээний харилцаа холбоо, хамтын ажиллагааг бэхжүүлэх.

ХЭРЭГЖҮҮЛСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА, АРГА ХЭМЖЭЭ:

Монгол улс “Биологийн олон янз байдлын тухай”, “Цөлжилттэй тэмцэх тухай”, “Уур амьсгалын өөрчлөлтийн тухай”, “Озоны давхаргыг хамгаалах тухай” конвенц, мөн “Зэрлэг амьтдын нүүдлийн зүйлүүдийг хамгаалах буюу Боннын конвенц”, “Олон улсын ач холбогдол бүхий ус, намгархаг газар, ялангуяа усны шувууд олноор амьдардаг орчны тухай конвенц” (RAMSAR)-д нэгдэн оржээ. Түүнчлэн Биологийн олон янз байдлын конвенцийн Био-аюулгүй байдлын тухай Картагены протокол, Генетикийн нөөцийг ашиглах, түүнээс гарах үр ашгийг тэгш шударгаар хуваарилах тухай Нагоягийн протокол, Уур амьсгалын өөрчлөлтийн тухай НҮБ-ын суурь конвенцийн Киотогийн протоколд нэгдэн ороод байна. Монгол улс RAMSAR-ын конвенцийн тайланг 2011 онд, Бонны конвенцийн тайланг 2012 онд, Биологийн олон янз байдлын тухай конвенцийн Үндэсний 5-р тайланг 2014 онд тус тус гаргаад байна.

Биологийн олон янз байдлын үндэсний хөтөлбөр (2015-2025)-ийг Монгол Улсын ЗГ-ын 2015 оны 06 дугаар сарын 29-ний өдрийн хуралдаанаар хэлэлцэн 2015 оны 08 дугаар сарын 04-ний өдрийн 325 дугаар тогтоолоор баталсан болно. Биологийн олон янз байдлын үндэсний хөтөлбөр нь Монгол Улсын нэгдэж орсон дээрх конвенциудын уялдаа холбоог Айчи 2020 зорилгод нийцүүлэн хангахад чухал үүрэгтэй.

Бүс нутгийн эдийн засгийн интеграцчлалын байгууллагууд болон Засгийн Газрын төлөөлүүдийн Зэрлэг ан амьтдын хууль бус худалдааны талаар 2014 оны 2 дугаар сарын 13-ны өдөр Лондон хотноо хуралдаж, дэлхийн улс орны ЗГ-ууд, Олон улсын байгууллагууд

зэрлэг амьтны хууль бус худалдааны эсрэг хамтдаа тэмцэхээр Лондонгийн тунхаг бичигт нэгдсэн. Энэ хуралд БОАЖЯ-ны дэд сайд 2016 онд Ханой хотноо болсон зэрлэг амьтны хууль бус худалдааны эсрэг олон улсын бага хуралд оролцон Монгол улс Лондонгийн тунхаглалд нэгдэн орж, хамтран ажиллахаа илэрхийлэв.



Ханой хотын уулзалт. 2016 он.

2018 оны 10 сард Английн ЗГ-ын санаачлагаар Лондон хотноо болсон Зэрлэг амьтны хууль бус худалдааны хуралд Монгол улсын Гадаад хэргийн сайд, БОАЖЯ-ны дэд сайд оролцоод зэрлэг амьтны хууль бус худалдаанаас байгаль орчин, нийгэм, эдийн засагт асар их хор хөнөөл учирч байгааг хүлээн зөвшөөрч, энэ хууль бус худалдааг эцэс болгоход хамтрахаа илэрхийлсэн байна.

ТБХ. 16.5 БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫН ТУХАЙ КОНВЕНЦИЙН УРГАМАЛ ХАМГААЛАХ ДЭЛХИЙН СТРАТЕГИ ТАЙ УЯЛДАН АЖИЛЛАХ.

ТАЛУУДЫГ: а). Дэлхийн ургамал хамгаалах 2012-2020 он хүртэлх стратегийн зорилго, зорилтонд Конвенцийн оруулах хувь нэмрийг анхаарах;
 б). Конвенцийн Үндэсний удирдан зохицуулах зөвлөл болон Дэлхий ургамал хамгаалах стратегийн хэрэгжилтийн үндэсний нэгжийн хоорондын хамтын ажиллагааг дэмжих, сайжруулах;
 с). Дэлхийн ургамал хамгаалах стратегийн Үндэсний хөтөлбөрийг боловсруулах, хэрэгжүүлэхэд ялангуяа Конвенцийн хавсралтад бүртгэлтэй зүйлүүдтэй холбоотой үйл ажиллагаанд Конвенцийн удирдлага оролцох;

д). Дэлхийн ургамал хамгаалах стратегийн хамтын ажиллагааг Биологийн олон янз байдлын конвенцийн Үндэсний тайланд тусган оруулахыг УРИАЛЖ байна.

ХЭРЭГЖҮҮЛСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА, АРГА ХЭМЖЭЭ:

Монгол улсын ЗГ-аас Монгол орны ховор ургамлын удмын санг хамгаалах, тэдгээрийн тархац нутгийг орон нутгийн тусгай хамгаалалтанд авах, нөхөн сэргээх, үржүүлэх боломжийг судлах зорилго бүхий “Монгол орны ховор ургамлыг зохистой ашиглах үйл ажиллагааны хөтөлбөрийг 2002-2010 онд хэрэгжүүлсэн байна.

“Биологийн олон янз байдлын 2011-2020 оны стратеги төлөвлөгөө” болон “Биологийн олон янз байдлын Айчигийн зорилтууд” зэрэг төрийн болон олон улсын бодлогын баримт бичгийг боловсруулах, хэрэгжүүлэх, “Монгол улсын ЗГ-ын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн “Устах аюулд орж байгаа амьтан, ургамлыг хамгаалах, уугуул нутагт нь сэргээх, тарималжуулах ажлыг эрчимжүүлэх” гэж заасны дагуу хөтөлбөрийг шинэчлэн “Байгалийн ургамлыг хамгаалах үндэсний хөтөлбөр”-ийг боловсруулж, 2013-2021 онд хэрэгжүүлэхээр ажиллаж байна.

Монголын биологийн олон янз байдлын мэдээллийн сан ажлын хүрээнд Ургамлын улаан данс 1-р ботийг гаргаж, Монгол орны зарим ховор ургамлын хамгааллын төлөвлөгөө боловсруулав. Монгол оронд ховорт тооцогдох 148 зүйл ургамлыг ДБХХ (IUCN, 2001)-ны Улаан дансны шалгуураар үнэлж, Монгол орны зарим ховор ургамлын хамгааллын төлөвлөгөө боловсруулав. 2013 онд шинэчлэн боловсруулсан Монгол улсын Улаан номд 192 зүйл ургамал устах аюулд өртсөн болохыг бичжээ. Монгол орны ургамлын гуурст аймагт хамаарах 126 зүйл нэн ховор, 345 зүйл ховор, 124 зүйл элбэг ургамлын экологи-эдийн засгийн үнэлгээг тогтоогоод байна (Мөнхжаргал, Батцэрэн нар, 2015).

Монголын Шувуу Судлалын Нийгэмлэг, МУИС, ШУА-ийн судлаачид хамтран БОАЖЯ-ны санхүүгийн дэмжлэгтэйгээр Монгол орны нэн ховор, ховор ургамлын жагсаалтыг гаргаж, БОАЖЯ-нд хүлээлгэн өгөөд байгаа бөгөөд уг бүтээлийг 2019 онд гаргахаар ажиллаж байна.

ТБХ. 16.6 КОНВЕНЦ БА АРДЫН АЖ АМЬДРАЛ.

ТАЛУУД: Конвенцийн хавсралтад бүртгэлтэй зүйлүүдийг хамруулсан хүн ба зэрлэг амьтан хоорондын зөрчлийг бууруулах стратеги боловсруулах. Энэхүү стратеги нь зөвхөн Конвенцийн хавсралтад бүртгэлтэй зүйлүүдээр хязгаарлагдахгүй экосистемийг бүхэлд нь хамруулахыг ЗӨВЛӨЖ байна.

ХЭРЭГЖҮҮЛСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА, АРГА ХЭМЖЭЭ: ДБХС-аас Ази тивийн өндөр уулсын ландшафт болон бүлгэмдлийг хамгаалах, дасан зохицох “Ирвэс” төсөл, Ирвэс хамгаалах сангаас 1997 оноос хойш хэрэгжүүлж буй “Ирвэс Энтерпрайз” хөтөлбөрөөр цоохор ирвэс болон хүний хоорондын зөрчлийг зөөлрүүлэх, өрхийн орлогыг нэмэгдүүлэх замаар нутгийн иргэдийг байгаль хамгаалахад татан оролцуулах зорилготой үйл ажиллагааг явуулж байна.

Хустайн БЦГ-т тахь нутагшуулах ажлын хүрээнд уг тусгай хамгаалалттай газрын орчны бүсийн малчин, иргэдэд чиглэсэн олон талт сургалт, бусад үйл ажиллагааг зохион байгуулж байна.



ДБХС-гийн хэрэгжүүлж буй Их Нууруудын хотгорын бөхөнгийн хамгаалал төслөөр бөхөнд ээлтэй бэлчээрийн менежментийг хэрэгжүүлж, бөхөнгийн тоо толгой, амьдрах орчинд учирч буй нөлөөг бууруулах, хуулийн хэрэгжилтэнд орон нутгийн иргэдийг оролцуулах, иргэдийн мэдлэг, мэдээллийг нэмэгдүүлснээр бөхөнгийн тоо толгой 2010 онтой харьцуулахад 30 хувиар тухайн бүс нутагт өслөө.

ТАЛУУДЫН БАГА ХУРЛЫН 15-Р ХУРАЛДААН

ТБХ. 15.2 ЗЭРЛЭГ АМЬТАН ХУДАЛДААНЫ БОДЛОГО.

Экспорт, импортлогч Талуудын Зэрлэг амьтан худалдаалах тухай бодлого нь байгаль орчин, нийгэм, эдийн засаг болон холбогдох бодлогуудыг харгалзах, Конвенцийн хавсралтад бүртгэлтэй ургамал, амьтан, тэдгээрийн гаралтай эд зүйлсийн худалдаа, ашиглалтын бодлогоо өөрсдөө дүгнэдэг байхыг УРИАЛЖ байна.

ХЭРЭГЖҮҮЛСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА, АРГА ХЭМЖЭЭ:

Монгол улс “Ховордсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийн гадаад худалдааг зохицуулах тухай” хуулийг 2002 онд батлав. Ан агнуурын тухай хууль, Амьтны аймгийн тухай хуулиудыг 2012 онд нэгтгэн шинэчлэн найруулж, батлав. Амьтны тухай хуульд ан амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эдийг худалдах, худалдан авах тухай, түүний дотор гарал үүслийн гэрчилгээний тухай заалтыг нэмж өгсөн. 2017 оны 5-р сард батлагдсан Зөрчлийн тухай хуульд ховордсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийн гадаад худалдааг зохицуулах тухай хууль зөрчихөд хүлээлгэх хариуцлагын заалт тусгагдсан. Монгол орны ан амьтны Экологи- эдийн засгийн үнэлгээг 46 зүйл хөхтөн, 242 зүйл шувуу, 27 зүйл загасанд хийснээс Конвенцийн I, II хавсралтад бүртгэлтэй амьтдын экологи-эдийн засгийн үнэлгээ бүрэн хийгдсэн байна.

ТАЛУУДЫН БАГА ХУРЛЫН 14-Р ХУРАЛДААН

ТБХ. 14.5 БИЕЧЛЭН УУЛЗАХ.

ТАЛУУД: Биечлэн уулзах нь Талуудын хооронд Конвенцийн хавсралтад орсон тодорхой эсвэл, бүлэг зүйлүүдийн талаар санал зөрөлдсөн үед зөвшилцөлд хүрэх зорилгоор хийгдэх зөвлөлдөх уулзалт юм гэдгийг ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРӨВ.

ХЭРЭГЖҮҮЛСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА, АРГА ХЭМЖЭЭ:

Монгол улс энэ зарчмыг хүлээн зөвшөөрч, Конвенцийн үйл ажиллагааг хэрэгжүүлж байна.

ТБХ. 14.7 (REV. COP15) ЭКСПОРТЫН ТОО ХЭМЖЭЭГ ТОГТООХ ҮНДЭСНИЙ МЕНЕЖМЕНТ.

ТАЛУУДАД ЗӨВЛӨМЖ болгох: Талууд энэхүү шийдвэрийн хавсралт дахь экспортын тоо хэмжээг тогтоох үндэсний менежмент боловсруулахдаа Конвенцийн гарын авлагыг ашиглах, баримтлах.

ХЭРЭГЖҮҮЛСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА, АРГА

ХЭМЖЭЭ: БОАЖЯ-наас 2010, 2015 онд Монгол орны идлэг шонхорын тархац нөөцийг тогтоох ажлыг хийж, Монгол орон 6,830 идлэг шонхортой гэсэн дүгнэлтийг гаргажээ. Үндэсний судлаачид энэ ажлыг 2018 онд гүйцэтгэж, нийт 10,380 толгой идлэг шонхор байгааг тогтоосон. Конвенцийн Амьтны хорооны 25-р хуралдааны шийдвэрээр 2011 онд Монгол улс 300 толгой идлэг шонхор барьж, экспортлож болохыг Конвенцийн байнгын хороо зөвшөөрөв. Ингэснээр Монгол улсын ЗГ нь 2011 оны 8-р сарын 17-ны өдрийн 251-р тогтоолоор 2011 онд гадаадад гаргах идлэг шонхорын тоог 240 толгой байхаар тогтоожээ. 2015- 2018 онд САЙТИС-ийн байнгын хорооноос Монгол улсад аливаа амьтны зүйл дээр худалдаалах тоо хэмжээг хязгаарласан зөвлөмж хүргүүлээгүй байна.

ТБХ. 14.8 (REV. COP16) ХАВСРАЛТАД БҮРТГЭГДСЭН ЗҮЙЛҮҮДЭД ТОДОРХОЙ ХУГАЦААНД ҮНЭЛЭЛТ, ДҮГНЭЛТ ӨГЧ БАЙХ.

ТАЛУУДЫГ болон ЗГ хоорондын байгууллагууд, ТББ-ууд, бусад сонирхогч байгууллагуудыг Ургамал, амьтны хорооноос тогтмол гүйцэтгэдэг хавсралтад бүртгэлтэй зүйлүүдэд үнэлэлт, дүгнэлт өгөх ажилд дэмжлэг үзүүлэхийг УРИАЛЖ БАЙНА.

ХЭРЭГЖҮҮЛСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА, АРГА

ХЭМЖЭЭ: Монгол улсаас Конвенцийн I хавсралтад цагаан болон шилийн шонхорыг харин II хавсралтад турамтай шонхор, ердийн орволго, балч гоорбис, сохор элээ, нугын хулд, ягаан нал зэрэг шувуудыг бүртгэв.



Рамсарын Конвенц, Wetland International байгууллагын оролцоотой борцгор хотонгийн хамгааллын үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулахад Монгол улс идэвхийлэн оролцож, Рамсарын конвенцийн хүрээнд энэхүү төлөвлөгөөг хэрэгжүүлэх талуудын үйл ажиллагааг хамтран удирдахаар Конвенцид санал оруулаад байна.

БОАЖЯ,
ШУА, МУИС, МШСН
зэрэг байгууллага хамтран
идлэг шонхорын нөөцийн судалгааг
2018 онд гүйцэтгэлээ. Судалгааны
дүнгээр манай оронд идлэг шонхорын нийт
10,380 бодгаль 683.633,70 км кв тархац
нутагт амьдарч байна. Монгол улсаас 1994-
2014 онд нийт 3,836 шувуу гаргаж байжээ.
Идлэг шонхрын экспортын энэ мэдээ манай
орны идлэг шонхрын нөөцөд эрс сөрөг
нөлөөлөөгүй гэж
үзжээ.



ТАЛУУДЫН БАГА ХУРЛЫН 13-Р ХУРАЛДААН

ТБХ. 13.2 (REV. COP14) БИОЛОГИЙН ТӨРӨЛ ЗҮЙЛИЙН ТОГТВОРТОЙ АШИГЛААЛТ: АДДИС АБАБАГИЙН ЗАРЧИМ БА ЗААВАР ТАЛУУДАД ХҮРГҮҮЛЭХ ШААРДЛАГА:

а). Биологийн олон янз байдлыг тогтвортой ашиглах зарчим ба зааврыг баримтлах, өөрийн улс орны шинжлэх ухаан, худалдаа болон хуулийн нөхцөл, мөн Амьтан ба ургамлын хорооны зөвлөгөөг харгалзах;
б). Байгалийн нөөц баялаг тогтвортой ашиглах хүрээнд үндэсний хэмжээний ялангуяа Үндэсний Удирдан зохицуулах зөвлөл, Биологийн олон янз байдлын үндэсний менежментийн нэгжийн хооронд туршлага солилцох.

ХЭРЭГЖҮҮЛСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА, АРГА

ХЭМЖЭЭ: Монгол улсын Биологийн олон янз байдлыг хамгаалах Үндэсний хөтөлбөрийг 1996 онд боловсруулан хэрэгжүүлж, 2013 онд Үндэсний хөтөлбөр 96 хувийн амжилттай хэрэгжлээ гэж дүгнэсэн. Одоо Үндэсний хөтөлбөрийг Биологийн олон янз байдлын тухай конвенц, Айчигийн зорилтод тулгуурлан шинэчлэн боловсруулсан бөгөөд энэ Конвенцийн хүрээнд хийсэн болон төлөвлөж буй ажлууд нь Конвенцийн үйл ажиллагаатай шууд холбоотой.

Биологийн олон янз байдлын үндэсний хөтөлбөр (2015-2025)-ийг Монгол улсын ЗГ 2015 онд баталсан ба уг хөтөлбөр нь Монгол улсын нэгдэж орсон конвенциудын уялдаа холбоог Айчи 2020 зорилгод нийцүүлэн хангахад чухал үүрэгтэй.

ТБХ. 13.3 КОНВЕНЦИЙН ХҮРЭЭНД НҮҮДЛИЙН ЗЭРЛЭГ АМЬТДЫГ ХАМГААЛАХ КОНВЕНЦИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХЭД ХҮЧИН ЧАРМАЙЛТ ГАРГАХ, ХАМТРАН АЖИЛЛАХ. ТАЛУУДЫГ УРИАЛАХ:

а). Нүүдлийн зэрлэг амьтдыг хамгаалах Конвенцийн хүрээнд хэрэгжүүлэх ажлын хөтөлбөрийг хамтран боловсруулах;
б). Нүүдлийн зэрлэг амьтдыг хамгаалах Конвенцийн хавсралтад бүртгэлтэй бөхөн болон цоохор ирвэс хамгаалах үйл ажиллагааг хамтран гүйцэтгэх.

ХЭРЭГЖҮҮЛСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА,

АРГА ХЭМЖЭЭ: Монгол улс “Бөхөн хамгаалах үндэсний хөтөлбөр”, “Цоохор ирвэс хамгаалах үндэсний хөтөлбөр”, “Монгол орны идлэг шонхорыг хамгаалах үндэсний хөтөлбөр”-ийг 2010 хүртэл хэрэгжүүлсэн ба эдгээр хөтөлбөр дуусаж буйтай холбогдуулан “Нэн ховор, ховор амьтдыг хамгаалах үндэсний хөтөлбөр”-ийг батлав. Монгол бөхөн болон түүний нүүдэл, шилжилт хөдөлгөөний замуудыг хамгаалалтанд авч, Шарга- Манханы нөөц газрыг байгуулсан.

Хавтгай, цагаан зээр, хулан зэрэг нүүдлийн зүйлийн үржлийн болон өвөлжих чухал газруудыг ТХГН-т хамруулсан.

БНХАУ болон ОХУ-тай хамтран хавтгай, цагаан зээр, аргалийн хил дамнасан нүүдлийн судалгааг явуулж, ТХГН-ийг байгуулав.

Конвенцийн Талуудын хамтын ажиллагааны хүрээнд БНХАУ болон Монгол улсын Удирдан зохицуулах зөвлөл хамтран 2011 оны 3-р сард уулзалт зохион байгуулж, бөхөнгийн эврийн худалдаанд тавих хяналтыг сайжруулах, хяналт тавих ур чадварыг дээшлүүлэхэд хамтран ажиллах харилцан ойлголцлын санамж бичигт гарын үсэг зурав.

Нэн ховор, ховор амьтдыг байгальд нь өсгөн үржүүлэх зорилт тавин ажиллаж, Монгол бөхөн үржүүлэх техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулан, Баянхонгор аймгийн нутагт үржүүлгийн газрыг сонгоод байна.

Конвенцийн хавсралтад бүртгэлтэй Амарын шонхор, идлэг шонхор, нөмрөг тас зэрэг шувуудын нүүдлийг судлах ажлыг амжилттай зохион байгуулж байна.

ТБХ. 13.6 (REV. COP16) КОНВЕНЦИД ОРОХООС ӨМНӨ ОЛЖ АВСАН ЭД ЗҮЙЛ КОНВЕНЦИЙН 7.2.-ЫН ЗААЛТЫН ХЭРЭГЖИЛТ.

ТАЛУУДЫГ Конвенцид нэгдэн орохоос өмнө байсан амьтан, ургамлын эд зүйлийн тоо Талуудын бага хурлаас I хавсралтад бүртгэснийг баталсан өдөр болон хүчин төгөлдөр болсон өдрийн хооронд нэмэгдэхээс сэргийлэх арга хэмжээ авахыг САНУУЛЖ БАЙНА.

ХЭРЭГЖҮҮЛСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА, АРГА

ХЭМЖЭЭ: Монгол улсын ховордсон амьтан, ургамал тэдгээрийн гаралтай эд зүйлийн гадаад худалдааг зохицуулах хуулиар Конвенцид нэгдэн орохоос өмнө олж авсан болохыг Конвенцийн Шинжлэх ухааны зөвлөл нотолж, дүгнэлт гаргадаг. Монгол улсын хилээр зааны соёо (*Elephas maximus*) 5 удаа, цармын бүргэдийн өд, цоохор ирвэсийн гавлын яс, аргалийн гавлын яс, чихмэл зэрэг гарсан тухай 17 удаагийн бүртгэл Конвенцид нэгдэн орохоос өмнө байжээ.

Конвенцийн хавсралтанд бүртгэлтэй Амарын болон идлэг шонхор, нөмрөг тас зэрэг шувуудын нүүдлийг судлах ажлыг амжилттай зохион байгуулж байна.

МШСН, МУИС болон Рамсарын Бүс Нутгийн Төв-Зүүн Ази, Зүүн Ази, Австралазийн Шувууны Нүүдлийн Замын Түншлэл олон улсын байгууллагатай хамтран Рамсард бүртгэлтэй 11 газрын усны шувууд болон бусад биологийн төрөл зүйлийн мэдээллийн санг шинэчлэв. Мөн дээрх байгууллагууд хамтран нүүдлийн замын түншлэлийн нийт 6 сүлжээ нутгийн мэдээллийн санг шинэчилж, харин 5 газрыг уг түншлэлийн сүлжээ нутагт шинээр бүртгүүлжээ.

Монголын төлөөлөгчид Рамсарын Талуудын бага хурлын 13-р хуралд 2018 оны 10-р сард оролцож, биологийн төрөл зүйлийн шийдвэрийн төсөлд саналаа өгөв.

Увс нуурт өндөглөн зусдаг, Конвенцийн 1-р хавсралтад бүртгэлтэй ямаан сүүлт нугас

ТБХ. 13.7 (REV. COP16) ХУВЬ ХҮНИЙ ХЭРЭГЛЭЭНИЙ ЭД ЗҮЙЛИЙН ХУДАЛДААНД ХЯНАЛТ ТАВИХ.

ТАЛУУДАД САНАЛ БОЛГОХ нь: Энэхүү шийдвэрийн I хавсралтаар өгсөн гарын авлагыг гэрийн тэжээвэр болон тэжээсэн амьтныг чөлөөлөхдөө ашиглах. Бүх Талууд I хавсралтад бүртгэлтэй амьтан, ургамлын эд зүйлээр хийсэн бэлэг, дурсгалыг худалдах, зөөвөрлөхдөө энэхүү шийдвэрийн III хавсралтыг баримтлах. Жуулчинд зориулсан бэлэг дурсгал дээр асуудал гарсан тохиолдолд импортлогч, экспортлогч орон ба Конвенцийн Нарийн бичгийн дарга нарын газарт хандах. ТАЛУУДЫГ үндэсний хууль эрх зүйг энэхүү шийдвэртэй нийцүүлэхийг ДЭМЖИЖ БАЙНА.

ХЭРЭГЖҮҮЛСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА, АРГА


ХЭМЖЭЭ: Монгол улсын хилээр хувь хүний хувийн хэрэглээний эд зүйл 138 удаа гадагш гарч, 40 удаа хилээр орж ирсэн гэж бүртгэгджээ. Одоогоор холбогдох хуулийн заалтад тодорхой тусгагдаагүй төдийгүй энэ чиглэлээр гүйцэтгэсэн тодорхой ажил хомс байна.

ТБХ. 13.9 ТАЛУУДЫГ EX SITU БОЛОН IN SITU ХАМГААЛЫН ХӨТӨЛБӨРТ ХАМТРАН АЖИЛЛАХЫГ УРИАЛАХ.

ЯТГАХ нь: а). Талууд I хавсралтад бүртгэлтэй амьтдын ex situ үйл ажиллагааг гүйцэтгэх ба I хавсралтад буй ургамлын зүйлүүдийг тарьж нөөцийг нэмэгдүүлэх in situ хамгааллын арга хэмжээ авах; б). Талууд ex situ ба in situ арга хэмжээг дэмжин техник, хөрөнгө, санхүүгээр туслах, дахин нутагшуулах зүйлийг солилцох, технологийн шилжүүлэлт, дэд бүтцэд хөрөнгө оруулах болон бусад арга хэмжээ, туслалцаа үзүүлэх.

ХЭРЭГЖҮҮЛСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА, АРГА

ХЭМЖЭЭ: Монгол улс 1992 оноос эхлэн Голланд, Герман, ОХУ, Швейцар, Австри зэрэг улсын амьтны хүрээлэнгээс тахийг уугуул нутагт сэргээн нутагшуулах ажлыг улс орнууд, хувь хүн, байгууллагатай хамтран зохион байгуулж байна. Хустайн нуруунд 1992 онд 15 толгой тахь, Говь-



Алтай аймгийн Бижийн голд 5 бодгалийг гадаадаас зөөвөрлөж тавьснаар тахь сэргээн нутагшуулах ажил эхэлсэн. 2004 онд Завхан аймгийн Хомын талд 12 тахь авчирснаар тахь сэргээн нутагшуулах 3 дахь төсөл эхэлсэн. 1992 онд Голланд, Украин улсаас 20, 1993 онд Украйнаас 6, 1994 онд Голландаас 10, 1995 онд Швейцар, Австри улсаас 13, 1996 онд Швейцар, Голландаас 21 тахийг Монголд авчирсан нь тахь эх нутагтаа амжилттай нутагших үндсэн нөхцөл болжээ. Сэргээн нутагшуулсан тахийн тархац нутаг улсын тусгай хамгаалалтай газарт бүрэн хамрагджээ. 2015-2017 онд жил бүр 4 тахь, нийт 16 тахийг Монгол улсад оруулжээ. Монгол улсын ЗГ-аас нэн ховор, ховор амьтдыг байгальд нь өсгөн үржүүлэх зорилт тавин ажиллаж байгаа ба Монгол бөхөн үржүүлэх техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулан Баянхонгор аймгийн нутагт үржүүлэх газрыг сонгожээ.

ТБХ. 13.10 (REV. COP14). ХАРЬ ЗҮЙЛИЙН ХУДАЛДАА.

ТАЛУУДАД САНАЛ БОЛГОХ нь:

- а). Амьтан, ургамлын худалдааг зохицуулах үндэсний хууль эрх зүйн орчинд харь зүйлийн асуудлыг тусгах;
- б). Харь зүйл байж болзошгүй байх тохиолдолд импортлогч орны Удирдан зохицуулах зөвлөлөөс тухайн импортыг зохицуулах арга хэмжээг тодорхойлох;
- с). Конвенц болон БОЯБТК хоорондын уялдаа холбоог бэхжүүлж, харь зүйлийг нутагшуулах асуудалд хамтран ажиллах боломж, бололцоог хайх.

ХЭРЭГЖҮҮЛСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА, АРГА ХЭМЖЭЭ:

Монгол улсын 2012 онд баталсан Амьтны тухай болон Байгалийн ургамлын тухай хуульд харь зүйлийн тухай заалтыг нэмж оруулсан. 2017 онд батлагдсан Зөрчлийн тухай хуульд харь зүйлтэй холбоотой заалт зөрчихөд хүлээлгэх хариуцлагыг зааж өгөв.

ТБХ. 13.11 ЗЭРЛЭГ АМЬТДЫН МАХ БЭЭЛТГЭЛ. КОНВЕНЦИЙН I ХАВСРАЛТАД ОРСОН АМЬТНЫ МАХЫГ ХҮНСЭНД ХЭРЭГЛЭХИЙГ ЗОГСООХ.

Хавсралт II, III-т бүртгэлтэй амьтныг хүнсэнд хэрэглэж байгаа бол нөөцийн судалгаатайгаар тогтвортой ашиглах,

хүнсэнд хэрэглэх, махны чиглэлээр худалдаалах, агнуурын менежментийг сайжруулах, мэдээлэл, хууль эрх зүй, мониторинг хийх, хуулийн хэрэгжилт, нийгмийн ба санхүүгийн урамшууллыг ашиглах, төрийн байгууллагуудын хариуцлагыг дээшлүүлэх, хавсралтад бүртгэлтэй амьтан, ургамлын гаралтай бүтээгдэхүүний эзэмших эрхийг тодорхой болгох, хяналтанд нутгийн иргэдийг оролцуулах, нөхөн сэргэх боломжтой тоо хэмжээгээр агнах, худалдаалах, өөр төрлийн махны хэрэглээг нэмэгдүүлэх, ангийн махны хэрэгцээг бууруулах.

ХЭРЭГЖҮҮЛСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА, АРГА

ХЭМЖЭЭ: Талууд мэргэжлийн хяналт, хууль журам сахиулах үүрэг бүхий төрийн байгууллагуудын ялангуяа хилийн хяналтын ажилтнуудын мэдлэг, мэдээллийг сайжруулах, Конвенцийн хавсралтад орсон ургамал, амьтны гаралтай хүнсний бүтээгдэхүүн экспорт, импортын гэрчилгээтэй эсэхийг хянан тогтоож байна.

Монгол улс Амьтны тухай хуульд нэн ховор амьтныг зөвхөн судалгаа шинжилгээний зориулалтаар агнах, ховор амьтдыг тусгай зөвшөөрлөөр агнахыг заасан. Ангийн махны худалдаа (загасны махнаас бусад) одоогоор дотоодын зах зээлд бага мэт байна. Цагаан зээрийн махыг нэг үе БНХАУ руу худалдаалж байсан ч Монгол улс саяхнаас үйлдвэрлэлийн зориулалтаар агнахыг хориглов.

Монгол улс 1990-ээд оны эхээр ОХУ-ын зах зээлд их хэмжээний загас нийлүүлдэг байсан ба харин сүүлийн үед БНХАУ-ын зах зээл дээрх загасны үнэ нэмэгдсэнтэй холбоотой тус орон руу гаргах болжээ.

*Дотоодын зах зээлд зарагдаж байсан
Хүдрийн мах. ЦЕГ*



Олон улсын ангийн махны худалдаа багасч байгаа ч дотоодын зах зээл дэх ангийн махны эрэлт ихэсч, зэрлэг ан амьтдын популяцийн тоо цөөрөхөд нөлөөлөгч хүчин зүйл болсоор байна.

Монгол болон Алтайн тарвага, цагаан зээр, бор гөрөөс, хандгай, хулан зэрэг хөхтөн, Алтайн хойлог мэт шувуу, зарим загасны махыг дотоодын зах зээл дээр зарсаар байгаа хэдий ч илэрсэн гэмт хэрэг, зөрчлийн тоо мэдээ бага нь хуулийн хэрэгжилт хангалтгүй гэж дүгнэхээр байна.

Хууль хяналтын байгууллагын ажилтнуудын чадавхийг бэхжүүлэх, хуулийн хэрэгжилтийг сайжруулах зорилготой төсөл хөтөлбөрүүдийг Монгол улсад үйл ажиллагаа явуулж буй ТББ-ууд хэрэгжүүлж байна. Үүнд: ЛАСН 2015-2018 онд “Хуулийн хэрэгжилтийн сайжруулснаар зэрлэг амьтны хууль бус худалдааг бууруулах нь”, 2018-2021 онд “Зэрлэг амьтны хил дамнасан хууль бус худалдааг бууруулах, хил орчмын иргэдийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх” төслийг, БЗАХНийгэмлэг болон ДБХС-гаас хууль бус худалдааны чиглэлээр төслүүд хэрэгжүүлэв.

Төслийн хүрээнд ЛАСН, ЦЕГ, МХЕГ, ГЕГ-ын ажилтнуудад зэрлэг амьтны эд, эрхтэн, тэдгээрийн гаралтай бүтээгдэхүүн таних, тодорхойлох сургалт, амьтны эд эрхтнийг таньж тодорхойлох гар утасны СОРГОГ аппликейшн, ГЕГ-ын Эрэлч нохойн сургалтын төвийн үйл ажиллагааг дэмжиж, амьтны гаралтай бүтээгдэхүүнийг илрүүлэгч нохойн тоог нэмэх, хууль бус ан агнуур, худалдааны талаарх байгууллага хоорондын мэдээллийн солилцоог дээшлүүлэх зэрэг ажлуудыг хийж байна.



ТАЛУУДЫН БАГА ХУРЛЫН 12-Р ХУРАЛДААН

ТБХ. 12.3 (REV. COP16) ЗӨВШӨӨРӨЛ БА СЕРТИФИКАТ.

а). Зөвшөөрөл болон сертификатын загварыг өөрчлөх хүсэлтээ Талууд Нарийн бичгийн дарга нарын газарт мэдэгдэж зөвлөгөө авах;
 б). Талууд энэ шийдвэрийн 2-т хавсаргасан стандарт загварын дагуу зөвшөөрлийн болон сертификатын загвараа шинэчлэх;
 с). Электрон зөвшөөрөл ба сертификат ашиглаж, эсвэл ашиглах гэж байгаа бол Конвенцийн стандарт загварыг мөрдөх. Хууль бус буюу залилан мэхлэлтээс сэргийлж, Конвенцийн загварыг дотоодын худалдааны зөвшөөрөлд ашиглахгүй байх;
 d). Тайлан болон тэмдэглэлтэй холбоотойгоор зөвшөөрөл ба сертификатын дугаарын тоог загварын дагуу 14 оронтой байлгах.

ХЭРЭГЖҮҮЛСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА, АРГА

ХЭМЖЭЭ: Монгол улс зөвшөөрлийн гэрчилгээг Талуудын уулзалтаас зөвлөсний дагуу боловсруулан хэрэглэж байна.

2015 онд CITES-ийн хавралтанд бүртгэгдсэн 13 төрөлд хамаарах 16 зүйлийн амьтны гаралтай бүтээгдэхүүн, түүний дотор эм, гоо сайхны бүтээгдэхүүн, арьсан эдлэл болон ангийн олзвор багтсанаас гадна нутагшуулах зорилгоор 4 тахь амьдаар, циркийн зориулалтаар маккак сармагчин (*Macaca mulatta*), каимен матар (*Caiman crocodilus*) Монгол орж ирсэн байна.

2017 онд Конвенцийн хавсралтад орсон 17 төрөлд багтах 20 зүйлийн амьтны гаралтай бүтээгдэхүүн, түүний дотор эм, гоо сайхны бүтээгдэхүүн, арьсан эдлэл болон хувцас, модон эдлэл багтсанаас гадна нутагшуулах зорилгоор 3 тахь амьдаар, *Cereus repandus*, *Ferocactus glaucescens*, *Ferocactus pilosus*, *Pachycereus pringlei*, *Dendrobium hybrid*, *Dendrobium nobile* зэрэг ургамлыг экспортлов.

ТБХ. 12.5 (REV. COP16) БАР БОЛОН I ХАВСРАЛТАД БҮРТГЭГДСЭН АЗИЙН ТОМ МИЙН ХАМГААЛАА.

ХОЛБОГДОХ ОРНУУДАД САНАЛ болгох нь:

- а). Хулгайн ангийн эсрэг хууль хэрэгжүүлэх нэгж болон баг байгуулах, хууль бусаар агналт, худалдаатай тэмцэх ба хуулийн хэрэгжилтийг хангах байгууллагуудын хооронд мэдээ, мэдээлэл солилцох бололцоог бүрдүүлэх;
- б). Хот, хөдөөгийн хүн ам болон бусад зорилтод бүлгүүдэд зэрлэг амьтны экологийн болон соёлын ач холбогдол, эко-туризмын ач холбогдлыг ойлгуулах сургалт-сурталчилгааны ажлыг зохион байгуулах;
- е). Хууль бус агнуурын хүчин зүйлийн судалгааг гүйцэтгэж хүчин зүйлийг бууруулах арга хэмжээ авч хэрэгжүүлэх.

ХЭРЭГЖҮҮЛСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА,

АРГА ХЭМЖЭЭ: Монгол улсын ЗГ-ын Нэн ховор, ховор амьтдыг хамгаалах Үндэсний хөтөлбөрийг 2011 оноос хэрэгжүүлж байна. ДБХС-ийн Монгол дахь хөтөлбөрийн газар, ШУА-ийн ЕБСБХ, Олон Улсын Ирвэс Хамгаалах Сан, Монголын Ирвэс Хамгаалах Төв, АНУ-ын Пантера байгууллагатай хамтран ирвэс хамгаалах төслүүдийг хэрэгжүүлж байна. Төслүүдийн хүрээнд орон нутгийн иргэдэд хандсан сургалт, сурталчилгаа, иргэдийн оролцоог хангасан үйл ажиллагааг явуулж, сайхан үр дүн гарч байна.

Хамтарсан судалгааны үед барьж хүзүүвчилсэн бие гүйцсэн ирвэс.



Монгол улсын ХЗДХЯ-ны дэргэд Монгол улсад гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийг Монгол улсын Ерөнхийлөгчийн 134-р зарлигаар 2016 онд байгуулсан ба тус зөвлөлийн бүрэлдэхүүнд холбогдох яамд, хууль хяналтын байгууллага түүний дотор шүүх, прокурор, цагдаа, тагнуул, гааль, мэргэжлийн хяналтын байгууллагын төлөөлөл багтдаг. Байгаль орчны эсрэг гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх дэд зөвлөл байгуулагдан байгууллага хоорондын хамтын ажиллагаа, уялдаа холбоог бэхжүүлэн ажиллаж байна. ЛАСН-ээс байгууллага хоорондын мэдээллийн солилцоог сайжруулах зорилгоор зэрлэг амьтан, ургамалтай холбоотой гэмт хэрэг зөрчлийн мэдээллийн санг БОАЖЯ-ны дэргэд Байгаль Орчны Мэдээллийн Төвтэй хамтран Байгаль орчны мэдээллийн санд оруулсан. Монгол орны хууль бус худалдааны өнөөгийн байдал “Зэлүүд тал-2” судалгааг 2017 онд ажиллаж гүйцэтгэсэн.

ТБХ. 12.10 (REV. COP15). КОНВЕНЦИЙН I ХАВСРАЛТАД БҮРТГЭЛТЭЙ ЗҮЙЛИЙГ ХУДАЛДААНЫ ЗОРИЛГООР ГАРШУУЛАН ТЭЖЭЭЖ ҮРЖҮҮЛСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААГ БҮРТГЭХ.

САНАЛ БОЛГОХ нь:

- а). Талууд гаршуулан тэжээсэн зүйлийг бүртгүүлэхдээ энэхүү шийдвэрийн 3-т хавсаргасан өргөдлийг загварын дагуу, ойлгомжтой заавартайгаар илгээх;
- б). Импортлогч орон нь I хавсралтад бүртгэлтэй зүйлийг гаршуулан тэжээсэн бүртгэлтэйгээр импортлох.

ХЭРЭГЖҮҮЛСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА,

АРГА ХЭМЖЭЭ: Монгол улсын хилээр Конвенцийн I хавсралтад бүртгэлтэй зүйлээс гаршуулан тэжээсэн бүртгэлтэй эгэл, цагаан болон эрлийз шонхорыг 6 удаа гадаадад гаргасан тохиолдол, гадаадаас оруулж ирсэн 15 удаа, мөн тэжээмэл матрын арьсан эдлэл бүртгэгдсэн байна.

ТАЛУУДЫН БАГА ХУРЛЫН 11-Р ХУРАЛДААН

ТБХ. 11.3 (REV. COP16) КОНВЕНЦИЙН БА ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТ.

САНАЛ БОЛГОХ нь:

- а). (i). Зэрлэг амьтан, ургамлын хууль бус худалдааны цар хэмжээг тодорхойлж, хууль хэрэгжүүлэгч үндэсний байгууллагуудын үйл ажиллагаанд энэ асуудлыг тодорхой тусгах;
- (ii). Хэрэв тохиромжтой бол Конвенцийн хууль хэрэгжилтийг хангах үндэсний болон орон нутгийн үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах.

ХЭРЭГЖҮҮЛСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА,

АРГА ХЭМЖЭЭ: Конвенцийн заалтыг хэрэгжүүлэх эрх зүйг зохицуулах “Ховордсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийн гадаад худалдааг зохицуулах тухай” хуулийг 2002 онд батлав.

Амьтны аймгийн тухай болон Ан агнуурын тухай хуулийг шинэчлэн найруулж, 2012 онд “Амьтны тухай” хуулийг батлан гаргав. Монгол улсын байгалийн ургамлын тухай хуулийг 1995 онд баталсан. “Монгол орны ховор ургамлыг зохистой ашиглах үйл ажиллагааны хөтөлбөрийг 2002-2010 онд хэрэгжүүлж, хөтөлбөрийг шинэчлэн “Байгалийн ургамлыг хамгаалах үндэсний хөтөлбөр”-ийг боловсруулан 2013-2021 онд хэрэгжүүлж байна.

“Халиун буга хамгаалах үндэсний хөтөлбөр” (2000), “Аргаль хамгаалах үндэсний хөтөлбөр” (2002), “Баданга хүдэр хамгаалах үндэсний хөтөлбөр” (2009), “Бөхөн хамгаалах үндэсний хөтөлбөр”, “Мазаалай хамгаалах үндэсний хөтөлбөр”-ийг (2013-2018) “Цоохор ирвэс хамгаалах үндэсний хөтөлбөр”-ийг 2005-2010 онд, “Монгол орны идлэг шонхорыг хамгаалах үндэсний хөтөлбөр”-ийг 2005-2010 онд хэрэгжүүлж, эдгээр хөтөлбөр нь 2010 онд дуусч байгаатай холбогдуулан “Нэн ховор, ховор амьтдыг хамгаалах үндэсний хөтөлбөр”-ийг батлав.

ТБХ. 11.7 ХҮДРИЙН ХАМГААЛАА БА ХУДАЛДАА.

ТАЛУУДАД ШААРДАХ нь:

Хүдрийн заарын худалдааг бууруулах яаралтай арга хэмжээ авч хэрэгжүүлэх. Үүнд:

- а). Хууль хэрэгжүүлэх шинэлэг аргыг ашиглах, нэн тэргүүний арга хэмжээ болох хил, гааль дээр хуулийн хэрэгжилтийг чангатгах;
- г). Хууль эрхзүйн орчин болон хуулийн хэрэгжилтийг сайжруулах.

ХЭРЭГЖҮҮЛСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА, АРГА ХЭМЖЭЭ:

Хүдэр нь 1953 оноос ахуйн болон үйлвэрлэлийн зориулалтаар агнахыг бүрэн хориглосон. Монголын Улаан дансанд ховордлын зэрэглэлээр үнэлэгдсэн, Монгол улсын Улаан ном (1987, 1997, 2013)-д бүртгэгдсэн. “Амьтны аймгийн тухай” хууль (2000) болон “Ан агнуурын тухай” хуулиар (1995) нэн ховор амьтан гэж заажээ. Гэсэн хэдий ч хүдрийн тоо толгой буурсаар байгаа шалтгааны нэг нь хууль бус агнуур, худалдаа болохыг судалгаагаар тогтоожээ.

ЛАСН-ээс хууль хяналтын ажилтнууд, тэдгээрийн дотор гаалийн ажилтнуудын зэрлэг амьтны эд эрхтэн, тэдгээрийн гаралтай бүтээгдэхүүн, түүний дотор хүдрийн заарыг таних тодорхойлох арга зүйн сургалтыг зохион байгуулж, гарын авлага боловсруулж, эд эрхтнийг таних тодорхойлох СОРГОГ гар утасны аппликейшин боловсруулан хэрэглээнд шилжүүлсэн нь амжилттай болов.

Хураагдсан хүдрийн заар. ЦЕГ 2016.



ТБХ 11.11 (REV. COP15) УРГАМАЛ ХУДАЛДАХ ЖУРАМ.

ТАЛУУДАД САНАЛ БОЛГОХ нь:

а). Хууль хяналтын байгууллагын ажилтнууд Конвенцоос тавигдах шаардлага, Конвенцид бүртгэлтэй ургамлын дээжид тавигдах хяналт, гаалийн бүрдүүлэлтийн үйл явц, хууль бус худалдааг илрүүлэх үе шатыг мэддэг байх;

б). Хууль хяналтын байгууллагууд худалдаалагдаж буй ургамлын зүйлүүд, түүний дотор байгалийн ургамлыг тарималжуулсан хэлбэрийг танихад шаардлагатай судалгааны материал болон чадвартай байх;

с). Хууль хэрэгжүүлэгч байгууллага нь хууль бус худалдааг илрүүлэхэд шаардлагатай жил бүрийн тайлан, ургамлын арчилгаа, хүний эрүүл мэндэд нөлөөлөх онцлогийн талаарх лавлагаа болон бусад холбогдох мэдээллийг ашигладаг байх;

д). Хуулийн хэрэгжилтийг сайжруулахын тулд худалдаж буй эд материалыг нарийвчлан шалгах, ялангуяа ургамлын зүйлийн тарималжуулсан гэх эргэлзээтэй сортыг экспорт, импортын аль алинд нарийвчлан шалгах шаардлагатай.

ХЭРЭГЖҮҮЛСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА, АРГА

ХЭМЖЭЭ: Японы ЗГ-ын санхүүжилтээр хэвлэсэн “Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенц-лавлах” гарын авлага (2001) нь гаалийн байгууллагын ажилтан нарт зориулсан Конвенцийн хавсралтад бүртгэлтэй амьтан, ургамлын зүйл болон тэдгээрийн эд, эрхтэн, биеийн хэсэг, түүний дагалдах бүрэлдэхүүнийг танихад дөхөмтэй бүтээл юм. Уг гарын авлага нь гаалийн байгууллагын ажилтан болон иргэдэд энэхүү конвенцийн тухай ойлголт өгөх, Конвенцийн хавсралтад орсон зэрлэг амьтан, ургамал, тэдгээрийн эд эрхтнийг танихад чухал ач холбогдолтой.

ЦЕГ, ГЕГ болон ДБХС-ийн ажилтнууд Малайзын Куала Лумпур хотод 2014 онд зохион байгуулагдсан “Конвенцийн барих бодлого ба ховор зүйлийн эрхтэн, эд зүйлийг таних, тодорхойлох сургагч багш бэлтгэх” сургалтанд оролцсон байна. ДБХС-ийн Монгол дахь төлөөлөгчийн газраас “Амьтан, ургамал, түүний эд хэсгүүдийг таних гарын авлага”, 2004 онд

“CITES-ийн хавсралтад бүртгэгдсэн амьтан, ургамлын зүйлийг таних бичиг”, 2008 онд “Амьтан, ургамал, тэдгээрийн эд, эрхтнийг таних” гарын авлагыг хэвлүүлсэн.

БОАЖЯ, Дэлхийн Банк, Нидерландын Вант улсын ЗГ-ын Итгэлийн сангийн дэмжлэгтэйгээр улсын хилээр гарч буй байгалийн ургамал, түүний эд зүйлийг хянаж шинжлэх үлгэрчилсэн гарын авлагыг 2009 онд хэвлүүлжээ.

БОАЖЯ-наас Конвенцийн хэрэгжилтэнд хяналт тавих үүрэг бүхий ажилтнуудын дадлага, арга зүй, танин мэдэхүйн түвшинг дээшлүүлэх зорилготой семинарыг байгаль орчны албаны ажилтан, улсын байцаагч, орон нутгийн гааль, хилийн хяналтын албаны ажилтнуудад 2000, 2002, 2004, 2008, 2017, 2018, 2019 онд ХЗДХЯ болон БОАЖЯ хамтран зохион байгуулав.

ЛАСН, ДБХС зэрэг байгууллагууд БОАЖЯ болон судалгааны байгууллагуудтай хамтран зэрлэг ургамал, амьтдын эд, эрхтэн, тэдгээрийг таних, хууль бус худалдаагаар илрүүлсэн эд, эрхтэн, хуулийн дагуу гарах судалгааны дээжинд бүрдүүлэх материал зэрэг өргөн агуулгатай гарын авлагуудыг 2016-2018 онд хэвлэж, нийтийн хүртээл болгоод байна.



ТБХ. 11.15 (REV. COP12). ХУДАЛДААНЫ БУС ЗОРИЛГООР ТҮР ХУГАЦААГААР АШИГЛУУЛАХ, БЭЛЭГЛЭХ, ЭСВЭЛ МУЗЕЙН ҮЗВЭР БА УРГАМЛЫН ЦУГЛУУЛГЫН САНГИЙН СОЛИЛЦОО

САНАЛ БОЛГОХ нь:

- а). Талууд устгах аюулд өртөөд байгаа болон өртөх магадлалтай амьтан, ургамлын судалгааг хийх боломжийг бүрэн ашиглах;
- б). Байгалийн түүхийн музейн сан хөмрөг, цуглуулгаас ховор зүйлийг Талуудад болон судалгааны байгууллагууд ашиглах өргөн боломжийг олгох.

ХЭРЭГЖҮҮЛСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА, АРГА

ХЭМЖЭЭ: Монгол улсын “Зэрлэг амьтан ба ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийн гадаад худалдааг зохицуулах тухай хууль” болон 2012 онд шинэчлэн найруулсан Амьтны тухай хуулиар музейн үзвэр, ургамлын цуглуулгын сангийн бусад асуудал зохицуулагдаж байна.

БЗАХН-ээс 2018-2019 онд Конвенцийн хэрэгжилтийн үндэсний стратеги боловсруулахаар хууль, хяналтын байгууллагуудын төлөөлөөс бүрдсэн ажлын хэсэг байгуулан ажиллаж байна.

ТБХ. 11.17 (REV. COP16) ҮНДЭСНИЙ ТАЙЛАН.

ТАЛУУДАД Конвенцийн 8.7а–д заасан үүрэг болох жил бүрийн тайлангаа хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр 3 жил дараалан цаг хугацаандаа хүргүүлээгүй болохыг Байнгын хорооноос мэдэгдсэн Талтай Конвенцийн хавсралтад бүртгэлтэй зүйлийн гаралтай эд зүйлийн худалдаа хийхгүй байхыг санал болгож байна.

ХЭРЭГЖҮҮЛСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА, АРГА

ХЭМЖЭЭ:

Конвенцийн хэрэгжилтийн нэгдсэн тайланг 2003-2004, 2015-2016, 2016-2017 онд Нарийн бичгийн дарга нарын газарт явуулсан болно. Харин экспорт, импорт, ре-экспортын тайланг жил тутам илгээжээ.

ТАЛУУДЫН БАГА ХУРЛЫН 10-Р ХУРАЛДААН

ТБХ 10.3 ШИНЖЛЭХ УХААНЫ ЗӨВЛӨЛИЙН ҮҮРЭГ БА ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТОДОРХОЙЛОЛТ:

- а). Талуудын Шинжлэх ухааны зөвлөлийг Удирдан зохицуулах зөвлөлөөс салангид, бие даасан байхаар зохион байгуулах;
- б). Талууд Шинжлэх ухааны зөвлөл байгуулсан тухайгаа Талуудын дараагийн уулзалтаас өмнө Нарийн бичгийн дарга нарт мэдэгдээгүй тохиолдолд экспортын зөвшөөрлийг хүлээн авахгүй;
- с). Удирдан зохицуулах зөвлөл нь Шинжлэх ухааны зөвлөлийн зөвлөгөө, дүгнэлтийг тусгаагүй тохиолдолд хавсралтад бүртгэлтэй далайн гаралтай зүйлд экспорт, импорт зөвшөөрөл, сертификат олгохгүй байх;
- е). Хөрш зэргэлдээ Талууд Конвенцийн хүрээнд шинжлэх ухааны дүгнэлт гаргахад шинжлэх ухааны байгууллагуудаа дэмжсэн мэдээллийн эх сурвалжаа хамтран ашиглахад анхаарлаа хандуулах.

ХЭРЭГЖҮҮЛСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА, АРГА

ХЭМЖЭЭ: “Ховордсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийн гадаад худалдааг зохицуулах тухай” 2002 онд батлагдсан хуулиар Удирдан зохицуулах зөвлөл болон Шинжлэх ухааны зөвлөлийн эрх, үүрэг, гүйцэтгэх үйл ажиллагааг тодорхойлов. Шинжлэх ухааны зөвлөлийг ШУА-ийн Биологийн хүрээлэнгийн тэргүүлэх эрдэмтдийн бүрэлдэхүүнтэй 1996 оноос зохион байгуулан, ажиллаж байна. Шинжлэх ухааны зөвлөл хуульд заасны дагуу Удирдан зохицуулах зөвлөлд холбогдох зөвлөгөө, саналаа өгдөг.

ТБХ. 10.7 (REV. COP15). ХУРААГДСАН АМЬД (ХАВСРАЛТАД БҮРТГЭЛТЭЙ) ЗҮЙЛ.

- а). Удирдан зохицуулах зөвлөл шийдвэр гаргахаасаа өмнө шаардлагатай өөрийн улсын Шинжлэх ухааны зөвлөлөөс, хэрэв боломжтой бол экспорлогч болон бусад шинжээчдээс зөвлөгөө авах;
- б). Шинжлэх ухааны зөвлөлийн зөвлөгөөг стандартын дагуу тэмдэглэл хөтлөнө;
- д). Конвенцийн I, II, III хавсралтад орсноос үл хамааран хураагдсан амьд зүйлийн тоо хэмжээ, гаргасан шийдвэрийн тухай Нарийн бичгийн дарга нарын газарт мэдэгдэх;

е). Зохих бичиг баримтыг бүрдүүлээгүй амьд зүйлийг импортлогч орон хүлээн авахгүй ба барааг хураан авахдаа энэхүү шийдвэрийн хавсралтын 1 ба 2-ын дагуу гүйцэтгэх ба хураагдсан I, II хавсралтад бүртгэлтэй зүйлүүдэд шаардлагатай анхаарал, арчилгааг нэн тэргүүнд тавих.

ХЭРЭГЖҮҮЛСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА, АРГА

ХЭМЖЭЭ: Хураагдсан амьд амьтан ба ургамлыг Монгол улсын Гаалийн хууль, Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль, Амьтны тухай хуулийн дагуу шийдвэрлэж байна. Санхүүгийн боломж, мэргэжилтний хангалтгүй байдал, мөн байгууллага хоорондын холбоо муугаас шалтгаалан Монгол улсад импортоор орж ирсэн амьтад тухайлбал, Катараас ирсэн идлэг шонхорын зарим нь гаалийн бүсэд байхдаа эндсэн тохиолдол бий.

ТБХ. 10.8 (REV. COP14) БААВГАЙ ХАМГААЛАХ БА ХУДАЛДААЛАХ:

ХОЛБОГДОХ ТАЛУУДЫГ Конвенцийн I, II хавсралтад бүртгэлтэй баавгайн зүйлүүдтэй холбоотой Конвенцийн заалтыг хэрэгжүүлэх үйл ажиллагааг дүгнэн харах, эрчимжүүлэхийг шаардаж байна.

ХЭРЭГЖҮҮЛСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА, АРГА

ХЭМЖЭЭ: “Мазаалай хамгаалах үндэсний хөтөлбөр”-ийг 2013-2018 хэрэгжүүлж байна. Нэн ховор, ховор амьтдыг хамгаалах Үндэсний хөтөлбөрийг 2011 онд Монгол улсын ЗГ батлан, хөтөлбөрийн хүрээнд нэн ховор амьтдын менежментийн төлөвлөгөөг боловсруулж байна.

Конвенцийн II хавсралтад орсон хүрэн баавгай нь ДБХХ-ны Улаан дансны шалгуураар олон улсын хэмжээнд “Анхааралд өртөхөөргүй”, бүс нутгийн хэмжээнд “Мэдээлэл дутмаг” гэж үнэлэгдсэн. Монгол Улсын ЗГ-ын 2012 оны 7-р тогтоолоор баталсан ховор амьтны жагсаалтад бүртгэгдсэн ба Монгол улсын улаан номонд орсон. Тархац нутгийн 21 орчим хувь улсын тусгай хамгаалалттай нутагт хамрагджээ. ЗГ-ын тогтоолоор хүрэн баавгайн экологи, эдийн засгийн үнэлгээ нь 6.5-7.5 сая төгрөг.



Баавгайн саврыг худалдахаар завдсан гэмт этгээдээс хураасан саврууд. ЦЕГ 2015.

Соёл, шинжлэх ухааны зориулалтаар агнах, барих зөвшөөрлийн төлбөрийн хэмжээг тогтоож, хууль бусаар агнасан тохиолдолд экологи, эдийн засгийн үнэлгээг гурав нугалж төлүүлэхээр заажээ. Арьсыг худалдах, цөс буюу доньдыг эмчилгээнд хэрэглэх, сарвууг домд ашиглах зорилгоор агнаж, олон улсын болон дотоодын зах зээл дээр хууль бусаар худалдаалж байна (Wingard нар, 2006). Хүрэн баавгайн савар, доньд, арьсыг хууль бусаар худалдах үйл ажиллагаа зогсохгүй, харин нэмж баавгайн шүд, соёог бэлэг дурсгалын дэлгүүр болон цахим сүлжээг ашиглан худалдаж байна.

ТБХ. 10.16 (REV.) ГАРШУУЛАН ҮРЖҮҮЛСЭН

АМЬД БИЕ. Конвенцийн I хавсралтад бүртгэлтэй үржүүлсэн зүйлийн худалдаатай холбоотой саналыг ТАЛУУДАД хүргэх нь: Гаршуулсан амьтны худалдаа нь зөвхөн Талуудын бага хурлаас гарсан шийдвэрт заасан тэмдэг тавих тухай заалтын дагуу тавьсан тэмдгийн хэлбэр, тоо нь худалдааны зөвшөөрлийн баримттай тохирох тохиолдолд зөвшөөрөл олгож байх.

ХЭРЭГЖҮҮЛСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА, АРГА

ХЭМЖЭЭ: Монгол улсын хилээр гаршуулан тэжээсэн амьтны 30 бодгаль гарч, 114 толгой орж ирсэн тохиолдол бүртгэгджээ.

ТБХ. 10.17 (REV. COP14) ЭРЛИЙЗ АМЬД

БИЕС: 3.2а, 4.2а –гийн дагуу Талууд Конвенцийн заалтад хамаарах эрлийз зүйлийн талаар дүгнэлт гаргахдаа унаган зүйлд сөрөг нөлөө үзүүлэхгүйг магадлах.

ХЭРЭГЖҮҮЛСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА, АРГА

ХЭМЖЭЭ: Манай орны хувьд Арабын зарим орноос эрлийз шонхорыг байгальд сулхал талаар санал ирүүлснийг МШСН зэрэг мэргэжлийн байгууллага эрс эсэргүүцэж байсан ч эдгээр шонхорын хор нөлөөг тооцох чадвар муутай, энэ Конвенцийн талаарх ойлголтгүй зарим судлаачид оролцон, цөөн эрлийзүүдийг Монголын төв хэсэгт сумласан.

ТБХ. 10.19 (REV. COP14) АРДЫН ЭМЧИЛГЭЭ:

- а). Нэн ховор амьтдын хууль бус ашиглалтыг бууруулах, зэрлэг амьтдыг хэт ашиглахаас зайлсхийхийг уриалж, таниулах чиглэлтэй иргэдийн боловсрол, мэдлэгийг дээшлүүлэх зорилготой хөтөлбөр хэрэгжүүлэн ардын уламжлалт эмнэлэг болон хэрэглэгч нартай ойр ажиллах;
- б). Ардын уламжлалт эмнэлэгт хэрэглэж буй амьтан, ургамлын зүйл, эд эрхтнийг таних, шүүхийн техник технологийг хөгжүүлэхийг дэмжих;
- с). Цаашид ховор амьтны эд эрхтнээс гаргаж авдаг эм бэлдмэлийг өөр бусад аргаар, тухайлбал, химийн синтезийн аргаар гаргаж авах, бусад ховордоогүй амьтнаас гаргаж авах (гэхдээ зүйлийн тоо толгойд хор хохирол учруулахааргүй байх);
- е). Аюулгүй байдлыг хангасан, тохиромжтой тохиолдолд зохиомол үржүүлгийг ашиглах аргаар зах зээлийн хэрэгцээг хангаснаар зүйлийн тоо толгойд учирч буй дарамтыг бууруулах ба энэ нь тухайн улсын хуулиар зохицуулагдах.

ХЭРЭГЖҮҮЛСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА, АРГА

ХЭМЖЭЭ: Монголчууд зэрлэг ангийн эд эрхтнийг ардын эмчилгээнд хэрэглэдэг уламжлалтай. Сүүлийн үед энэ үйл ажиллагаа ихсэх хандлагатай боллоо. Мөн эмчилгээнд хэрэглэх зорилгоор хууль бусаар агнах, гадаад, дотоодын зах зээлд худалдаалах нь түгээмэл болсныг зарим судалгаа харуулж байна (Зэлүүд тал, 2006). Конвенцийн зөвлөл цаашид үүнийг анхааран ажиллах шаардлагатай.

ТБХ. 10.20 ХУВЬ ХҮНИЙ ЭЗЭМШИЛД БАЙГАА АМЬД БИЕСИЙГ ХИЛЭЭР НЭВТРҮҮЛЭХ.

ТАЛУУДАД САНАЛ болгох нь:

- б). Гэрийн тэжээвэр болон хувийн өмчлөл, эзэмшилд байдаг амьтан, ургамалд зөвшөөрөл олгохдоо уг амьд биес тухайн орныхоо Конвенцийн Удирдан зохицуулах

зөвлөлд бүртгэлтэй, өмчлөгч, эзэмшигч нь тухайн орны иргэн бол хоёр тал харилцан тохиролцсон тохиолдолд зөвшөөрөл олгох;

д). Хэрэв тухайн амьтан, ургамал хүсэлт гаргагч хүний эзэмшил, өмчлөлд байгаа эсэх нь тогтоогдоогүй, мөн тухайн амьтныг Конвенцид заасны дагуу олж аваагүй бол зөвлөл зөвшөөрөл олгохоос татгалзах;

е). Удирдан зохицуулах зөвлөл зөвшөөрөл олгохдоо эзний нэр, хаяг болон амьтан, ургамлын зүйл, хүйс, тэмдгийн дугаар болон өөр бусад амьд биестэй холбоотой эсэх тухай мэдээлэл шаардах.

ХЭРЭГЖҮҮЛСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА, АРГА

ХЭМЖЭЭ: Хувь хүн өөрийн эзэмшил, өмчлөлд байгаа амьд биесийг хил нэвтрүүлэх үйл ажиллагаа нь Монгол улсын Амьтны тухай хуульд заасан “Ан амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эд, ан амьтны холбогдолтой судалгааны ажлын сорьц, дээжийг гадаад улсад гаргах журам”, “Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай” хууль, “Малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах тухай” хууль, “Ховордсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийн гадаад худалдааг зохицуулах тухай хууль”-аар зохицуулагдаж байна.

ТБХ. 10.21 (REV. COP16). АМЬДААР

ТЭЭВЭРЛЭХ: Амьтан, ургамлыг амьдаар тээвэрлэх нөхцөл, холбогдох байгууллагуудын хамтын ажиллагааг сайжруулах, амьтан тээвэрлэх шаардлагыг хангах, шаардлагыг хууль, журам, зааварт тусгасан байх, амьтныг амьдаар хүлээн авах, нэвтрүүлэх боомтын нөхцөлийг заах.

ХЭРЭГЖҮҮЛСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА, АРГА

ХЭМЖЭЭ: ЗГ-ын 2003.07.15-ны 173 тоот тогтоолоор “Ургамлын үр, үрслэг, суулгац, амьтан, түүний үр, хөврөл үр, түүхий мах, дайвар бүтээгдэхүүн болон бичил биетний өсгөвөр, эмгэгт материалын дээжийг улсын хилээр нэвтрүүлэх боомтуудын жагсаалт”, “Амьтан, ургамал, түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хяналт, шалгалт хийх журам” болон “Амьтан, ургамал, түүхий эд, бүтээгдэхүүнд экспорт, импортын гэрчилгээ олгох” журмыг тус тус батлан мөрдөж байна.

КОНВЕНЦИЙН ХАВСРАЛТАД БҮРТГЭГДСЭН ЗАРИМ АМЬТАН, УРГАМЛЫН ЗҮЙЛИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ



Монгол улсаас энэхүү Конвенцийн I хавсралтад 13 зүйл шувуу, 5 зүйл хөхтөн, II хавсралтад 1 зүйл шавж, 2 зүйл загас, 1 зүйл мөлхөгч, 58 зүйл шувуу, 9 зүйл хөхтөн, 8 зүйл ургамал бүртгэгджээ.

Конвенцийн I ба II хавсралтад манай улсаас бүртгэгдсэн шавж, загас, мөлхөгч, ургамлын бүхий л зүйлийн тухай мэдээ, баримтыг тусгав. Харин тайлан бичих хэвлэлийн зардал, шинжээчийн туршлага, зүйлийн талаарх мэдээ, баримтын хангалт зэргээс шалтгаалан шувуу, хөхтнөөс хууль бус худалдаанд илүүтэй өртөж буй зарим зүйлийг түүвэрлэн сонгов.

Конвенцийн I, II хавсралтад бүртгэгдсэн манай орноос олноор худалдаалж буй болон хууль бусаар гарах боломжтой, бусад орноос манай орныг дамжин гарах (ре-экспорт), цаашид Монгол улсаас гадаадын бусад олон улс орон руу тусгай зөвшөөрлөөр болон хууль бусаар гарах шувуу, хөхтний зарим зүйлийн тухай мэдээ, баримтыг иргэн бүрт нээлттэй, тодорхой болгох зорилгоор тусгайлан сонгож энэхүү тайланд товчлон бичлээ.

ШАВЖ

Манай орноос энэхүү Конвенцийн II хавсралтад бүртгэгдсэн нэг зүйл эрвээхэй бий. Конвенцийн жагсаалтад бүртгэлтэй энэ зүйлийн худалдааны тухай мэдээ, баримт хомс байдаг.

АПОЛОН

Багийн нэр: *Lepidoptera*

Латин нэр: *Parnassius apollo*

Түгээмэл буюу англи нэр: Аполлон

Адилцах нэр: Далбаалаг эрвээхэй

Олон улсын статус: Дэлхийн Байгаль Хамгаалах Холбоо (IUCN)-ны Улаан данс, Конвенцийн II хавсралт, Европын зэрлэг амьтан ба амьдрах орчныг хамгаалах тухай (Берн) конвенцийн II хавсралт, Европын холбооны зөвлөлөөс баталсан "Амьдрах орчныг хамгаалах" тухай (92/43/ЕЕС) тогтоолын IV хавсралтад тус тус бүртгэгдсэн.

Бүс нутгийн статус: Ховор. Монгол улсын Улаан номд орсон. Монгол улсын ЗГ-ын 2012 оны ховор амьтдын жагсаалт батлах тухай 07 тоот тогтоолын хавсралтад бүртгэгдсэн.

Бүс нутгийн тархац: Алтай; Ховдын Улиастайн гол; Хөвсгөл нуурын урд хэсэг, мөн Дархадын хотгорт Арсай голын хөндий, Хөвсгөлийн зүүн эргээр Далбаа голын хөндий, Саяны нурууны өмнө хэсэг; Завханы Тосонцэнгэл, Нөмрөг сумын нутаг, Тарвагатайн нуруу; Архангайн Цэнхэр жигүүр; Өвөрхангайн Хангайн нуруу, Хархорин орчимд; Улаанбаатар хотын бүсэд Богдхаан уулын Нүхт, Зайсан, Санзайн ам; Хэнтийн Норовлин, Биндэр, Дадал сумын нутаг Онон голын хөндий; Сэлэнгийн Мандал сум, Ерөө голын эх, Хиагт; Төв аймгийн Зуун мод, Сөгнөгөрийн гол, Баянголын хөндий болон Мөнгөн морьт орчмын уулын нугад тохиолдоно.

Амьдрах орчин: Их төлөв өндөр уулархаг бүс нутгийн наранд ээвэр, эгц, цавчим налуу энгэр бүхий орчныг шүтэж байрших хэдий ч тухайн өндөр уулсын систем дэх томоохон гол мөрний хөндийн алаг өвст нуга, уулсын оройд байрлах намгархаг нугаар тохиолдоно.



Ч. Гантигмаа

Судлаачид энэ зүйл эрвээхэйг гадаад шинжийн онцлог, тархац байршил нутгийн өвөрмөц төрх, байгалийн онцлогийн хувьд тусгаарлагдмал орчинд тохиолдох байдлыг харгалзан дэд зүйлийг ялгадаг. Уг эрвээхэй бие гүйцэж нисэх хүртэлх хөгжлийн бүх үе шат (өндөг, авгалдай, хүүхэлдэй, бие гүйцэх)-д тодорхой ургамал бүхий орчин шүтнэ. Тухайлбал, авгалдай шатанд могойн идээ (*Sedum* spp.) буюу идэш тэжээлд нь гол байр эзлэх ургамлын зүйл ургасан орчин шаардлагатайн зэрэгцээ хүүхэлдэйлэх үед хоргодох орчин (хад асга) байх нь чухал.

Тоо толгой: Үнэлгээ хийгдээгүй. Байршил нутагт мал олноор бэлчих, хадлан, цуглуулга зэрэг шалтгаанаас тоо толгой цөөрч байгаа хэмээн үздэг. Гэхдээ тоо толгой буурахад нөлөө үзүүлж байгааг тогтоосон баримт, нотолгоо хомс.


Худалдаа: Тухайн зүйлийг биетээр нь цуглуулгын зорилгоор худалддаг.

Экологи, эдийн засгийн үнэлгээ: Тухайн зүйлд хамрагдах дэд зүйлүүд болон популяциудын биологи, экологи онцлог, тэдгээрийн экосистемд гүйцэтгэж буй үүргийн талаар мэдээлэл дутмаг учир үнэлгээнд хамрагдаагүй.

Хууль эрх зүйн орчин: Агнах, барих тусгай зөвшөөрөл: ЗГ-ын 2013 оны 93-р тогтоол; Гадаадад гаргах, худалдах зөвшөөрөл, гэрчилгээ: ХАУТГЭЗГХЗТХ-ийн 8-р зүйл; Хуулийн хариуцлага: ЗТХ-ийн 7.3.1., 7.6.1.-7.6.5., 11.22.3., 11.22.4. болон ЭХ-ийн 24.5.1.

ШҮ, сургалт ба бусад зорилгоор гадаадад гаргасан байдал: Гадаадын зарим улс руу хууль бусаар худалдах, тээвэрлэх боломжтой ба энэ талаар сурвалж нь тодорхойгүй зарим ам мэдээ бий.

Эд, эрхтэн, бүтээгдэхүүн, тэдгээрийн хэрэглээ, таних онцлог: Дэлгэмэл байдлаар хатаамал хийж, үзэсгэлэнгийн зориулалтаар худалдаална.



ЗАГАС

Конвенцийн II хавсралтад Монгол орны 2 зүйл загас бүртгэгдсэн. Тэдгээрийн худалдаа, экспортын тухай мэдээ, баримт бараг байхгүй.

ХАР МӨРНИЙ ХИЛЭМ

Багийн нэр: ACIPENSERIFORMES

Латин нэр: *Acipenser schrencki*

Түгээмэл буюу англи нэр: Japanese sturgeon or Amur sturgeon

Адилцах нэр: *Acipenser sturio* (non Linne) (Georgi, 1775; Pallas, 1811; Maak, 1861). *Acipenser schrencki* (Brandt, 1869). *Sturio schrenki* (Dybowski, 1872; Дыбовский, 1877). *Acipenser shrencki* (Берг, 1909; Берг, 1911; Солдатов, 1915; Берг, 1916; Mori, 1927; Солдатов, Линдберг, 1930; Таранец, 1937; Ецуди, 1939; Miyadi, 1940; Кизеветтер, 1942; Пробатов, 1949; Константинов, 1950; Сони, 1951; Никольский, 1956; Юхименко, 1963; Свирский, 1967). *Acipenser baeri schrencki* (Свирский, 1968). *Acipenser schrencki* (Крыхтин, 1972; Дашдорж, 1976).

Олон улсын статус: Устаж болзошгүй. Нүүдлийн амьтныг хамгаалах Олон улсын конвенци (CMS) болон энэ Конвенцийн II хавсралтад тус тус орсон.

Бүс нутгийн статус: Монгол улсад 1995 оноос агнахыг хуулиар хориглож, Амьтны тухай хуульд нэн ховор амьтнаар оруулж хамгаалсан байна. ДБХХ-ны Бүс нутгийн ангилал ба шалгуурыг баримтлан гүйцэтгэсэн Монгол орны загасны Улаан дансанд (2006) "Мэдээлэл дутмаг" зэрэглэлээр үнэлжээ.

Дэлхийн тархац: ОХУ, БНХАУ-ын нутгаар дамжин урсах Амар мөрний эхнээс адаг хүртэл тархжээ. Мөн Шилка, Нерче, Аргун, Нонна, Уссур, Сунгар голд амьдардаг (Никольский, 1956). ОХУ-ын Чита мужийн Ханх нуураас ганц удаа тэмдэглэсэн байна.

Бүс нутгийн тархац: Онон, Балж, тэдгээрийн зарим цутгал голуудад тохиолдоно (Дашдорж, 1976; Соколов, 1983; Maurice Kottelat, 2006; Ососк нар, 2006).

Амьдрах орчин: Цэнгэг устай, урсгал усан сангуудад амьдарна. Эр амьтан 8-10, эм нь 11-14 насандаа бэлэг боловсорч үржинэ. Үржлийн үед гол мөрдийн эх өөд нүүдэллэнэ. Гол мөрний элс, хайрга, хад чулуурхаг ёроолд түрсээ шахна. Атуу нь 27,000-433,000 гаруй түрс гаргана. Энэ зүйл загасны биологи, экологийн талаар Монголд судалгаа хомс.

Тоо толгойн чиг хандлага, нөлөөлж байгаа хүчин зүйлс: Нийт тархац нутгийн хэмжээнд 2, түүнээс дээш насны бодгалиуд 2,000-аас хэтрэхгүй (Кошелев, 2010). Эдгээрийн дотор үржлийн насны бодгаль тун цөөн тохиолдоно. Хууль бус агнуур, хулгайн ан, Амар мөрний усны бохирдол, хайрганы олборлолт зэрэг нь энэ зүйл загасны тоо толгой цөөрөх үндсэн шалтгаан болно (Крыхтин, 1979). Хар мөрний хилэм загасны тоо толгойн талаар Монголд судалгаа байхгүй.

Худалдаа: Мэдээ байхгүй.

Экологи, эдийн засгийн үнэлгээ: Хийгдээгүй.

Хууль эрх зүйн орчин: АТХ-ийн 9.8.6.-ийн барихыг хориглох хугацаа: Судалгаа, шинжилгээнээс бусад тусгай зориулалтаар амьдаар барихыг хориглоно. Амьтны аймагт учирсан хохирлын нөхөн төлбөр: Эко-э.з. үнэлгээг 2 дахин өсгөж төлөх тухай АТХ-ийн 37-р зүйл; Гадаадад гаргах, худалдах зөвшөөрөл, гэрчилгээ: ХАУГЭЗГХЗТХ-ийн 8-р зүйл; Хуулийн хариуцлага: ЗТХ-ийн 7.3.1., 7.6.1.-7.6.5., 11.22.3., 11.22.4.; ЭХ-ийн 24.5.2.

ШҮ, сургалт ба бусад зорилгоор гадаадад гаргасан байдал: Үгүй.

Эд, эрхтэн, бүтээгдэхүүн, тэдгээрийн хэрэглээ, таних онцлог: Махыг нь хүнсэнд хэрэглэнэ. Түрсийг хууль бусаар худалдана.



ШИВЭР ХИЛЭМ

Багийн нэр: ACIPENSERIFORMES

Латин нэр: *Acipenser baeri*

Түгээмэл буюу англи нэр: Siberian sturgeon

Адилцах нэр: *Acipenser sturio* (Georgi, 1775);

Acipenser baeri (Brandt, 1869; Dybowski, 1872);

Acipenser baeri (Берг, 1900; 1932);

Acipenser baeri stenorhynchus natio baicalensis (Егоров, 1949);

Acipenser baeri baicalensis (Соколов, 1966).

Олон улсын статус: Эмзэг (Sturgeon Specialist Group, 1996). Нүүдлийн зүйлийг хамгаалах Олон улсын конвенц (CMS), энэхүү Конвенцийн II хавсралтад тус тус орсон байна.

Бүс нутгийн статус: ДБХХ-ны Бүс нутгийн ангилал ба шалгуурыг баримтлан гүйцэтгэсэн Монгол орны загасны Улаан дансанд (2006) "Устаж байгаа, B2ab (iii,V)" зэрэглэлээр үнэлжээ. Монгол Улсын ЗГ-ын 2012 оны 7-р тогтоолоор ховор амьтны жагсаалтад бүртгэж, Монгол улсын Улаан ном (2013)-д орсон.

Дэлхийн тархац: Обь мөрнөөс Колым хүртэлх голууд, Байгаль нуураар тархжээ.

Бүс нутгийн тархац: Монгол орны Сэлэнгэ, Орхон, Туул, Дэлгэрмөрөн, Эг, Хараа зэрэг Хойд мөсөн далайн ай савын голуудад байгалийн шивэр хилэм (*Acipenser baeri baicalensis*) хэмээх салбар зүйл идээшин амьдардаг (Дашдорж, 1976; Соколов, 1983; Maurice Kottelat, 2006; Ососк нар, 2006).

Амьдрах орчин: Цэнгэг устай усан сангуудын гүнд, ёроолын элс, лаг шавартай газруудад хошуугаа газар шүргүүлэн хэвтэх маягаар хөдөлгөөн багатай амьдарна. Шумуул, хоовгоны авгалдай, цөөн өргөст хорхой, зөөлөн биетэн зэрэг ёроолын элдэв амьтдаар хооллоно. Атуу 12-14, атуух 10-12 насандаа тус тус бэлэг боловсорч үржих чадвартай болно. Байгаль нуурын саваас Сэлэнгэ мөрнийг өгсөн нүүсээр манай орны цэнгэг устай голуудад ирж 5 сарын дундаас 6 сарын эх хүртэл хугацаанд түрсээ шахна. Бие гүйцсэн нэг атуу, голын ёроолын хайрга, хад чулууны гадарга, завсар зайд 211,000-422,000 хүртэл тооны түрс гаргана.

Тоо толгойн чиг хандлага, нөлөөлж буй хүчин

зүйлс: Байгаль нуурт хилэм агнуурын нийт хэмжээ 19-р зуунд 2.5-3.0 мянган тн хүрч байсан бол 20-р зууны дунд үед 200-215 ц болж буурчээ. Сэлэнгэ мөрний адаг орчимд амьдрах энэ зүйлийн популяци ойролцоогоор янз бүрийн насны 19,000 бодгалиас бүрдэнэ. Үүнээс Сэлэнгэд нүүдэллэн ирж түрсээ шахдаг атуу дунджаар 100 орчим хэмээн үнэлжээ (Павлов нар, 1994). Хууль бүс агнуур, хулгайн ангийн улмаас тоо толгой нь хорогдож байна. Хот, суурингийн бохир шингэн, элдэв хог хаягдал, ашигт малтмал, ялангуяа алт олборлолтын явцад үүсэж буй органик бүс бохирдол, усан сангийн татралт, голдрилын өөрчлөлт зэргийн нөлөөгөөр амьдрах орчин доройтож хомсдох болов.


Худалдаа: Мэдээ байхгүй.

Экологи, эдийн засгийн үнэлгээ: Экологи, эдийн засгийн үнэлгээ: 1 м-ээс дээш урт эр бодгаль 200,000 төг, эм бодгаль 260,000 төг, 1 м хүртэл урт эр бодгаль 150,000 төг, эм бодгаль 195,000 төг, үр төл 255,000 төг.

Хууль эрх зүйн орчин: АТХ-ийн 9.8.6.-ийн барихыг хориглох хугацаа: Судалгаа, шинжилгээнээс бусад тусгай зориулалтаар амьдаар барихыг хориглоно. Амьтны аймагт учирсан хохирлын нөхөн төлбөр: Эко-э.з. үнэлгээг 2 дахин өсгөж төлөх тухай АТХ-ийн 37-р зүйл; Гадаадад гаргах, худалдах зөвшөөрөл, гэрчилгээ: ХАВТГЭЗГХЗТХ-ийн 8-р зүйл; Хуулийн хариуцлага: ЗТХ-ийн 7.3.1., 7.6.1.-7.6.5., 11.22.3., 11.22.4.; ЭХ-ийн 24.5.1.

ШҮ, сургалт ба бусад зорилгоор гадаадад гаргасан байдал: Үгүй.

Эд, эрхтэн, бүтээгдэхүүн, тэдгээрийн хэрэглээ, таних онцлог: Махыг нь хүнсэнд хэрэглэнэ. Түрсийг хууль бусаар худалддаг.



МӨЛХӨГЧ

Манай орноос нэг зүйл мөлхөгч энэ Конвенцийн II хавсралтад бүртгэгджээ. Уг зүйл могойны худалдааны талаарх мэдээ, баримт байхгүй.

ТЭМЭЭН СҮҮЛ МОГОЙ

Багийн нэр: SQUAMATA

Латин нэр: *Eryx tataricus*

Латин нэр: *Eryx miliaris* var. *roborowskii* (Bedriaga, 1907);

Eryx miliaris var. *kozłowi* (Bedriaga, 1907);

Eryx miliaris roborowskii (Царевский, 1915);

Eryx miliaris miliaris (Никольский, 1916);

Eryx tataricus (Банников, 1958);

Eryx tataricus tataricus (Мөнхбаяр, 1976);

Eryx tataricus roborowskii (Орлов, 1986).

Олон улсын статус: Үнэлгээ хийгээгүй.

Бүс нутгийн статус: ДБХХ-ны Улаан дансны шалгуур үзүүлэлтээр бүс нутгийн хэмжээнд "Ховордож болзошгүй" хэмээн үнэлсэн (Terbish et al., 2006). Монгол Улсын ЗГ-ын 2012 оны 7-р тогтоолоор ховор амьтны жагсаалтад бүртгэж, Монгол улсын Улаан ном (Мөнхбаяр нар, 2013)-д оржээ. Мөн энэ Конвенцийн II хавсралтад бүртгэгдсэн.

Дэлхийн тархац: Иран, Туркменистан, Узбекистан, Афганистан, Тажикстан, Энэтхэгийн баруун хойд, Пакистаны баруун, Казахстаны зүүн, Хятадын баруун умард (Шинжаан, Гансугаас Өвөр Монголын Нингха хүртэл), Монголын өмнөт талын нутгууд, Узбекистанд тархжээ (Uetz et al., 2006).

Бүс нутгийн тархац: Монгол орны Алтайн Өвөр говийн бүс нутагт хамаарах Борзонгийн говь, Зээмэгийн говь, Ногоон цав, Толь булаг, Эхийн гол, Говь-Алтайн Алтай сумын төв орчим, Тахийн шар нурууны баруун хэсэг, Ногоон довонгийн ус зэрэг газарт тохиолдоно (Ананьева нар, 1997; Мөнхбаяр, 1976; Тэрбиш, 1989).



Х. Тэрбиш

Амьдрах орчин: Заг, зээргэнэ, нохой шээрэн, хармаг, торлог зэрэг мод, сөөг ургамалтай довцог элс, сайр садарга, сухай, зэгс, хулстай баян бүрдэд идээшин амьдарна. Ихэвчлэн шөнийн амьдралтай. Эхийн голын баян бүрд орчимд өглөө эрт, оройн сэрүүнд үзэгдэнэ (Тэрбиш, 1989). Гүрвэл, мэрэгчдээр хооллоно. 4 сарын эцэс, 5 сарын эхээр ороо хөөцөлдөөнд орж, 3-4 хүртэл зулзагыг 7 сарын эцсээс 8 сар хүртэл гаргана (Богданов, 1960).

Тоо толгойн чиг хандлага, нөлөөлж байгаа хүчин зүйлс: Говь, цөлийн заг, сухай зэрэг ургамлыг хэт ашигласнаас амьдардаг орчин доройтох, махчин шувууд, зараанд идүүлэх зэргээр хорогддог (Ананьева нар, 1997; Тэрбиш, 1989; Terbish et al., 2006).

Худалдаа: Энэ талаар мэдээ байхгүй.

Экологи, эдийн засгийн үнэлгээ: Үнэлгээ хийгдээгүй.

Хууль эрх зүйн орчин: Амьтны аймагт учирсан хохирлын нөхөн төлбөр: Эко-э.з. үнэлгээг 2 дахин өсгөж төлөх тухай АТХ-ийн 37-р зүйл; Гадаадад гаргах, худалдах зөвшөөрөл, гэрчилгээ: ХАУТГЭЗГХЗТХ-ийн 8-р зүйл; Хуулийн хариуцлага: ЗТХ-ийн 7.3., 7.6.1.-7.6.5., 11.22.3., 11.22.4. болон ЭХ-ийн 24.5.1.-р зүйлд заасан хариуцлага хүлээнэ.

ШҮ, сургалт ба бусад зорилгоор гадаадад гаргасан байдал: Үгүй.

Эд, эрхтэн, бүтээгдэхүүн, тэдгээрийн хэрэглээ, таних онцлог: Хууль бүс худалдаанд бага өртөнө. Гэхдээ амьтны дэлгүүрт зарж байж болзошгүй.



ШУВУУ

Манай орноос нийт 71 зүйл шувуу бүртгэгджээ. Манай оронд шувуунаас хамгийн олон тоотойгоор идлэг шонхорыг гадаадад гаргажээ.

УСНЫ НӨМРӨГ БҮРГЭД

Багийн нэр: FALCONIFORMES

Латин нэр: *Haliaeetus leucorhynchus*

Түгээмэл буюу англи нэр: Pallas's fish eagle

Конвенцийн хавсралт: I

Олон улсын ховордлын зэрэглэл: Устаж болзошгүй

Бүс нутгийн ховордлын зэрэглэл: Устаж болзошгүй

Статус: Нүүдлийн өндөглөдөг зүйл

Амьдрах орчин: Хөвсгөл нуур (үржлийн тухай тэмдэглэгдсэн, ялангуяа Хороо, Ходон, Бэрх, Алагцар, Жаргалант голын тохойд үржих боломжтой), Увс нуур, Зост, Айраг, Ачит нуур, Буянт гол, Чонохарайх гол, Хар нуур, Ховд гол, Хар-Ус нуур, Дөргөн нуур, Булган гол, Завхан гол, Тамирын гол, Өгий нуур, Бөөнцагаан нуур, Өвөрхангайн Хужирт, Орхон, Туул голын хөндий, Монгол Дагуур болон Нөмрөгийн ТХГН-т тэмдэглэгдсэн. Нүүдлийн үедээ дээрх газруудаас гадна Говь-Алтайн уулархаг муж, Дундат Халхын хээр, Нууруудын Хөндийгөөр тохиолдоно. Өгий нуурын хойд эрэгт 2 бие гүйцсэн, 1 залуу шувуу 2010 оны 8-р сарын 15-нд бүртгэгдсэн (Gombobaatar et al., 2011).

Тоо толгой: Дэлхийн популяци 2011 онд 2,500-9,999 бие гүйцсэн бодгаль байснаа 1,000-2,500 болж огцом буурсан байна (BirdLife International, 2017). Манай орны хувьд тоо толгойн үнэлгээ хийгдээгүй.

Тоо толгойн чиг хандлага, нөлөөлж буй хүчин

зүйлс: Тоо толгой буурах гол шалтгаан нь нүүдлийн мал аж ахуй, уул уурхай, аялал жуулчлалын бааз, хүн амын төвлөрлийн шууд ба дам нөлөөнөөс үүссэн ус намгархаг орчны доройтол, бохирдол, Өгий болон бусад загастай нуурын хэт загасчлал нь энэ зүйл шувууны идэш тэжээлийн нөөцийг бууруулж байна. Мөн загасчдын хаясан тор, ойн түймэр зэрэг аюулаас шалтгаалж тоо толгой буурна (Gombobaatar et al., 2011).

Худалдаа: Одоогоор манай орны хувьд гадаад худалдааны мэдээ баримт байхгүй байна.

Экологи, эдийн засгийн үнэлгээ: Монгол улсын ЗГ-ын 23-р тогтоолоор баталсан "Ан амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ"-гээр нэг бодгалийн экологи-эдийн засгийн үнэлгээ нь 525,000 төгрөг болно.

Хууль эрх зүйн орчин: Амьтны аймагт учирсан хохирлын нөхөн төлбөр: Эко-э.з. үнэлгээг 2 дахин өсгөж төлөх тухай АТХ-ийн 37-р зүйл; Гадаадад гаргах, худалдах зөвшөөрөл, гэрчилгээ: ХАУТГЭЗГХЗТХ-ийн 8-р зүйл; Хуулийн хариуцлага: ЗТХ-ийн 7.3.1., 7.6.1.-7.6.5., 11.22.3., 11.22.4. болон УТХГН-т агнасан барьсан тохиолдолд ЭХ-ийн 24.5.1.-р зүйлд заасан хариуцлага хүлээнэ. **ШУ, сургалт ба бусад зорилгоор гадаадад гаргасан байдал:** Гадаад улс руу тээвэрлэсэн мэдээ, баримт одоогоор байхгүй.

Эд, эрхтэн, бүтээгдэхүүн, тэдгээрийн хэрэглээ, таних онцлог: Энэ зүйлийн сарвуу, хумсыг худалдаж байх талтай ч одоогоор энэ талаарх баримт алга байна.



ЭГЭЛ ШОНХОР

Багийн нэр: FALCONIFORMES

Латин нэр: *Falco peregrinus*

Түгээмэл буюу англи нэр: Peregrine falcon
Конвенцийн хавсралт: I

Олон улсын ховордлын статус: Анхааралд өртөхөөргүй

Бүс нутгийн ховордлын статус: Мэдээлэл дутмаг

Статус: Монгол оронд нүүдлийн өндөглөдөг зүйл

Амьдрах орчин: Монгол орны Ховд аймгийн Ховд голын хөндий, Хэнтийн уулсын зарим голын хөндийн усны шувуу элбэгтэй цавчим хад цохиотой орчинд үүрлэнэ. Хавар, намрын нүүдлийн үедээ томоохон гол, нуур зэрэг усны шувуу олонтой ус намгархаг газар бараадан тохиолдоно. Нүүдлийн үедээ говь цөлд цөөн тоогоор таарна (Gombobaatar et al., 2011).

Тоо толгой: Дэлхийн популяцийн хэмжээ 100,000-499,999 бие гүйцсэн бодгаль бөгөөд тоо толгой тогтвортой (Birdlife international, 2017). Монгол орны хувьд тоо толгойн талаарх судалгааны дүн одоогоор хэвлэгдээгүй.

Тоо толгойн чиг хандлага, нөлөөлж байгаа хүчин зүйлс: Уул уурхайн олборлолт, мод бэлтгэлийн шууд ба дам нөлөөлөөс үүссэн амьдрах орчны доройтол, бохирдол, түймэр, Арабын шонхорчдын нөлөө, өндөр хүчдэлийн шугам мөргөж эндэх зэрэг болно (Gombobaatar et al., 2011).

Экологи, эдийн засгийн үнэлгээ: Монгол улсын ЗГ-ын 23-р тогтоолоор баталсан “Ан амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ”-гээр нэг бодгалийн экологи-эдийн засгийн үнэлгээ нь 62,000 төгрөг болно.

Хууль эрх зүйн орчин: Амьтны аймагт учирсан хохирлын нөхөн төлбөр: Эко-э.з. үнэлгээг 2 дахин өсгөж төлөх тухай АТХ-ийн 37-р зүйл; Гадаадад гаргах, худалдах зөвшөөрөл, гэрчилгээ: ХАУТГЭЗГХЗТХ-ийн 8-р зүйл; Хуулийн хариуцлага: ЗТХ-ийн 7.3.1., 7.6.1.-7.6.5., 11.22.3., 11.22.4. болон УТХГН-т агнасан барьсан тохиолдолд ЭХ-ийн 24.5.1.-р зүйлд заасан хариуцлага хүлээнэ. ШҮ, сургалт ба бусад зорилгоор гадаадад гаргасан байдал: 1998, 2001, 2003 онд худалдааны зорилгоор 19 бодгалийг ОХУ, Итали, Саудын Араб улс руу гаргасан. 2001, 2003 онд хувийн болон худалдааны зорилгоор 10 бодгалийг импортлов.

Эд, эрхтэн, бүтээгдэхүүн, тэдгээрийн хэрэглээ, таних онцлог:

- Идлэг шонхороос гадна эгэл болон шилийн шонхорыг Арабын улс орнууд руу амьдаар худалдаж байх болзошгүй.
- Түүний хөлийн хүмсыг мөнгөлөн бэлэг дурсгалын хэлбэрээр дотоод, гадаадад худалдаж байх боломжтой.
- Залуур болон дэвүүр өдийг шашин, бөөгийн зан үйлд хэрэглэж байх талтай. Түүний хөлийн хуруу, тарсны диаметр идлэгийнхээс бага.



ЖОРОО ТООДОГ

Багийн нэр: GRUIFORMES

Латин нэр: *Chlamydotis undulata*

Түгээмэл буюу англи нэр: Houbara bustard

Адилцах нэр: Жороо тоодгой. Манай оронд *Chlamydotis undulata masqueenii* гэх салбар зүйл тархсан ба үүнийг сүүлийн үед бие даасан зүйл гэж тооцжээ.

Конвенцийн хавсралт: I

Олон улсын ховордлын статус: Эмзэг

Бүс нутгийн ховордлын статус: Эмзэг

Статус: Өндөглөн зусдаг нүүдлийн зүйл.

Амьдрах орчин: Манай орны цөлийн хээр, цөлийн бут, бутлаг ургамал бүхий задгай чулуурхаг хөрстэй орчинд амьдарна.

Тоо толгой: Манай орны хувьд тоо толгой нь тодорхойгүй ч, нийт 200-300 бодгаль байна (MNE & JICA, 2001).

Тоо толгойн чиг хандлага, нөлөөлж байгаа хүчин зүйлс: Мал, уул уурхай зэрэг хүний нөлөөнөөс хамаарсан амьдрах орчны алдагдал, мах идэшт амьтдын нөлөөгөөр тоо толгой нь цөөрөх хандлагатай.


Албан бус мэдээгээр Катар, Арабын шонхорын наймаачид агнадаг байх боломжтой.

Худалдаа: Монгол орноос худалдсан тухай баримт байхгүй. Амьдаар болон биеийн тодорхой хэсэг өд, толгой зэргийг гадаад руу гарах магадлал өндөр.

Экологи, эдийн засгийн үнэлгээ: Монгол улсын ЗГ-ын 23-р тогтоолоор баталсан “Ан амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ”-гээр нэг тоодгойн экологи-эдийн засгийн үнэлгээ нь 210,000 төгрөг болно. Дээрх тогтоолоор баталсан “Ан амьтны нөөц ашигласны төлбөр, ан амьтан агнах, барих зөвшөөрлийн хураамжийн хэмжээ”-г нэг тоодгойн хувьд соёл шинжлэх ухаан, эмчилгээний зориулалтаар агнах, барихад 42,000 төгрөг байхаар тогтоожээ.

Хууль эрх зүйн орчин: Амьтны аймагт учирсан хохирлын нөхөн төлбөр: Эко-э.з. үнэлгээг 2 дахин өсгөж төлөх тухай АТХ-ийн 37-р зүйл; Гадаадад гаргах, худалдах зөвшөөрөл, гэрчилгээ: ХАУТГЭЗГХЗТХ-ийн 8-р зүйл; Хуулийн хариуцлага: ЗТХ-ийн 7.3.1., 7.6.1.-7.6.5., 11.22.3., 11.22.4. болон УТХГН-т агнасан барьсан тохиолдолд ЭХ-ийн 24.5.1.-р зүйлд заасан хариуцлага хүлээнэ. ШҮ, сургалт ба бусад зорилгоор гадаадад гаргасан байдал: Мэдээ, баримт байхгүй.

Эд, эрхтэн, бүтээгдэхүүн, тэдгээрийн хэрэглээ, таних онцлог: Энэ зүйлийг ихэвчлэн амьдаар авч гарах боломжтой ч одоогоор баримт алга.



БОРЦГОР ХОТОН

Багийн нэр: PELECANIFORMES

Латин нэр: *Pelecanus crispus*

Түгээмэл буюу англи нэр: Dalmatian pelican

Адилцах нэр: Pelican

Конвенцийн хавсралт: I

Олон улсын ховордлын статус: Эмзэг

Бүс нутгийн ховордлын статус: Устаж байгаа

Статус: Монгол оронд нүүдлийн өндөглөдөг зүйл.

Амьтны тухай хуульд нэн ховор амьтнаар оруулж хамгаалсан байна.

Амьдрах орчин: Ховдын Хар-Ус нууранд өндөглөн зусдаг. Хар-Ус, Айраг, Эрээн, Увс, Ойгон, Орог, Бөөнцагаан, Өгий зэрэг загас ихтэй томоохон нууранд нүүдлийн үедээ тэмдэглэгджээ.

Тоо толгой: Манай оронд 1950-1970 онд нийт 200-400 хос хотон байсан тухай баримт бий (MNE & JICA, 2001; Gombobaatar et al., 2011). Хамгийн сүүлийн байдлаар О.Мөнхтогтох нар Хар-Ус нуурт 2013 оны 6-р сард 57 бодгаль 5 ангаахайн хамт байхыг Ховд аймгийн Чоно Харайх голын цутгалд олжээ. Тоо толгой нь эрс цөөрч байна. Дэлхийд нийт 10,000-13,900 бодгаль хотон бий (BirdLife International, 2011).

Тоо толгойн чиг хандлага, нөлөөлж байгаа хүчин зүйлс: Монгол орны төдийгүй дэлхийн тоо толгой нь эрс цөөрч байгаа тул ОУБХХ-ны Улаан дансанд олон улсын болон бүс нутгийн хэмжээнд ховордсон зэрэглэлээр орсон. Амьдрах орчны доройтол, хууль бус агнуур, зэгс шагшуургын түймэр, малын нөлөө, хуурайшил зэргээс шалтгаалан тоо толгой нь эрс цөөрч байна (Gombobaatar et al., 2011).

Манай орны баруун бүс нутгийн Хар-Ус нуурт үржиж байсан хосын тоо жил бүр цөөрсөөр, сүүлчийн 10 жил үржлийн хос бүртгэгдээгүй.

Худалдаа: Хотонгийн хошууг хурдан морины хусуур хийхэд нутгийн иргэд ашиглана. Хулгайгаар агнасан шувуудын толгой бүхий хошууг дотоодод худалдана. Түүний тоо толгой ховордож буй шалтгааны нэг нь энэ болно.

Экологи, эдийн засгийн үнэлгээ: Монгол улсын ЗГ-ын 23-р тогтоолоор баталсан “Ан амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ”-гээр нэг бодгаль хотонгийн экологи-эдийн засгийн үнэлгээ нь 6,570,000 төгрөг болно.

Хууль эрх зүйн орчин: АТХ-ийн 7.2.-ийн агнах барих зөвшөөрөл: Судалгаа, шинжилгээнээс бусад зориулалтаар барихыг хориглоно. Амьтны аймагт учирсан хохирлын нөхөн төлбөр: Эко-э.з. үнэлгээг 2 дахин өсгөж төлөх тухай АТХ-ийн 37-р зүйл; Гадаадад гаргах, худалдах зөвшөөрөл, гэрчилгээ: ХАУТГЭЗГХЗТХ-ийн 8-р зүйл; Хуулийн хариуцлага: ЗТХ-ийн 7.3.1., 7.6.1.-7.6.5., 11.22.3., 11.22.4.; ЭХ-ийн 24.5.2.-р зүйлд заасан хариуцлага хүлээнэ.

ШҮ, сургалт ба бусад зорилгоор гадаадад гаргасан байдал: Гадаад улс руу тээвэрлэсэн мэдээ, баримт одоогоор байхгүй. Монгол орны хэмжээнд цөөн удаагийн тохиолдол бүртгэгдсэн.

Эд, эрхтэн, бүтээгдэхүүн, тэдгээрийн хэрэглээ, таних онцлог:

- Хотонгийн толгой бүхий хошууг уяачид хурдан морины хусуур болгон ашигладаг. Хошууг мөнгөлөх, алтдах зэргээр чимсэн байх нь бий.
- Хотон нь Хятадад мөн эмийн чанартайд тооцогддог ба түүний өд, арьсаар эд зүйлс хийдэг).
- Европын орнуудад хотонгийн хошууг хутганы хуй, тамхины сав болгон олон зууны турш ашиглаж ирсэн түүхтэй.



БАЙГАЛИЙН НУГАС

Багийн нэр: ANSERIFORMES

Латин нэр: *Anas formasa*

Түгээмэл буюу англи нэр: Baikal teal

Конвенцийн хавсралт: II

Олон улсын ховордлын статус: Анхааралд өртөхөөргүй

Бүс нутгийн ховордлын статус: Эмзэг

Статус: Нүүдлийн дайрч өнгөрдөг зүйл.

Амьдрах орчин: Нүүдлийн үедээ томоохон нуур, цөөрөмд бусад нугасны хамт таарна. Манай орны хувьд нүүдэллэн өнгөрдөг ховор зүйл бөгөөд Монгол орны төв, зүүн хэсгээр 4-р сарын сүүлчээс 6-р сарын эхэн үед дамжин өнгөрдөг. Энэ хэсгээр намрын нүүдлийн үе буюу 9-р сарын эхээс 10-р сарын дунд хүртэлх хугацаанд зөвхөн залуу шувууд бүртгэгдсэн. Тэд нүүдлийн үедээ цагаан хөмсөгт, шовтгор алаг зэрэг нугастай хамт цэнгэг болон давст нууруудаар байршдаг. Усны болон хуурай газрын ургамал, түүний үндсээр хооллох ба намрын нүүдлийн үедээ бусад нугасны хамт тариалангийн талбайд ч тохиолдоно.

Тоо толгой: Дэлхийн популяцийн хэмжээ тодорхой бус. 2004 онд БНСУ-д 455,000-658,000, Хятадад 50-10,000, ОХУ-д 10,000-100,000 бие гүйцсэн бодгаль бий гэж тооцсон (IUCN, 2017). Монгол оронд тоо толгойн талаарх баримт алга.

Тоо толгойн чиг хандлага, нөлөөлж байгаа хүчин зүйлс: Тоо толгой буурах гол шалтгаан нь мал аж ахуй, уул уурхайн шууд ба дам нөлөөнөөс үүдэлтэйгээр нуур, гол орчмын зэгс, ургамал талхлагдсаны улмаас үүссэн амьдрах орчны доройтол юм. Махыг хүнсэнд, өдийг нь гоёл чимэглэлд ашиглах зорилгоор хууль бусаар агнана (Gombobaatar et al., 2011; Гомбобаатар ба Одохүү, 2018).

Худалдаа: Одоогоор манай орны хувьд гадаад худалдааны мэдээ, баримт байхгүй. Гэхдээ зөвшөөрөлтэй нугас, галуу агнах үед өртөх эрсдэл өндөр.

Экологи, эдийн засгийн үнэлгээ: Монгол улсын ЗГ-ын 23-р тогтоолоор баталсан “Ан амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ”-гээр нэг бодгалийн экологи-эдийн засгийн үнэлгээ нь 143,000 төгрөг болно.

Хууль эрх зүйн орчин: Агнах, барих тусгай зөвшөөрөл: ЗГ-ын 2013 оны 93-р тогтоол; Амьтны аймагт учирсан хохирлын нөхөн төлбөр: Эко-э.з. үнэлгээг 2 дахин өсгөж төлөх тухай АТХ-ийн 37-р зүйл; Гадаадад гаргах, худалдах зөвшөөрөл, гэрчилгээ: ХАУТГЭЗГХЗТХ-ийн 8-р зүйл; Хуулийн хариуцлага: ЗТХ-ийн 7.3.1., 7.6.1.-7.6.5., 11.22.3., 11.22.4.; ЭХ-ийн 24.5.1.-р зүйлд заасан хариуцлага хүлээнэ.

ШҮ, сургалт ба бусад зорилгоор гадаадад гаргасан байдал: Гадаад улс руу тээвэрлэсэн мэдээ, баримт одоогоор байхгүй.

Эд, эрхтэн, бүтээгдэхүүн, тэдгээрийн хэрэглээ, таних онцлог: Эрийн толгойн ногоон-шаргал-бор хүрэн судал нь энэ зүйлийг ялгах чухал шинж болно. Харин эм бодгалийг хошууны уг орчмын цагаан толбоор таних боломжтой.



ХАЛБАГАН ХОШУУТ

Багийн нэр: CICONIIFORMES

Латин нэр: *Platalea leucorodia*

Түгээмэл буюу англи нэр: Eurasian spoonbill

Адилцах нэр: Халбаган хушуут

Конвенцийн хавсралт: II

Олон улсын ховордлын статус: Анхааралд өртөхөөргүй

Бүс нутгийн ховордлын статус: Анхааралд өртөхөөргүй

Статус: Нүүдлийн өндөглөдөг зүйл.

Амьдрах орчин: Монгол орны загас, усны сээр нуруугүй амьтан ихтэй томоохон нуурын гүехэн устай хэсэгт байршижтай. Нүүдлийн үедээ тал хээрийн жижиг нуур, цөөрөм, голын хөндийд тохиолдоно.

Тоо толгой: Увс нуурын савд 600-700 үүр байдаг тухай баримт бий (MNE & JICA, 2001). Тоо толгойн талаарх мэдээ, баримт хомс. Дэлхийн популяци нь 66,000-140,000 бие гүйцсэн бодгалиас тогтоно (BirdLife International, 2011).

Тоо толгойн чиг хандлага, нөлөөлж байгаа хүчин зүйлс: Тоо толгой нь харьцангуй тогтвортой байгаа боловч малын нөлөө, зохион байгуулалт муутай аялал жуулчлал, Дөргөн, Тайширын усан цахилгаан станцын нөлөө, хуурайшил зэрэг хүчин зүйл болон хулгайн агнуурын нөлөөгөөр тоо толгой нь ховордох аюултай (Gombobaatar et al., 2011).

Худалдаа: Хошууг нутгийн иргэд авахын тулд хулгайгаар олзворлодог цөөн баримт бий.

Экологи, эдийн засгийн үнэлгээ: Монгол улсын ЗГ-ын 23-р тогтоолоор баталсан “Ан амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ”-гээр нэг бодгаль халбаганын экологи-эдийн засгийн үнэлгээ нь 110,000 төгрөг болно. Мөн дээрх тогтоолоор баталсан “Ан амьтны нөөц ашигласны төлбөр, ан амьтан агнах, барих зөвшөөрлийн хураамжийн хэмжээ”-г нэг шувууны хувьд соёл шинжлэх ухаан, эмчилгээний зориулалтаар агнах, барихад 22,000 төгрөг байхаар тогтоожээ.

Хууль эрх зүйн орчин: Амьтны аймагт учирсан хохирлын нөхөн төлбөр: Эко-э.з. үнэлгээг 2 дахин өсгөж төлөх тухай АТХ-ийн 37-р зүйл; Гадаадад гаргах, худалдах зөвшөөрөл, гэрчилгээ: ХАВТГЭЗГХЗТХ-ийн 8-р зүйл; Хуулийн хариуцлага: ЗТХ-ийн 7.3.1., 7.6.1.-7.6.5., 11.22.3., 11.22.4. болон УТХГН-т агнасан барьсан тохиолдолд ЭХ-ийн 24.5.1.-р зүйлд заасан хариуцлага хүлээнэ. **ШҮ, сургалт ба бусад зорилгоор гадаадад гаргасан байдал:** Гадаад улс руу тээвэрлэсэн мэдээ, баримт одоогоор байхгүй.

Эд, эрхтэн, бүтээгдэхүүн, тэдгээрийн хэрэглээ, таних онцлог: Халбага хэлбэрийн хар хошуу нь ялгах чухал шинж болно.



ХАР ӨРӨВТАС

Багын нэр: CICONIIFORMES

Латин нэр: *Ciconia nigra*

Түгээмэл буюу англи нэр: Black stork

Конвенцийн хавсралт: II

Олон улсын ховордлын статус: Анхааралд өртөхөөргүй

Бүс нутгийн ховордлын статус: Анхааралд өртөхөөргүй

Статус: Нүүдлийн өндөглөдөг зүйл

Амьдрах орчин: Загас, усны амьтан элбэгтэй гол, нуур, ус намгархаг газар, тэдгээрийн хөндийн хад цохио, сийрэг ойд амьдарна. Буянт, Булган, Ховд гол, Хотон, Дунд, Ачит, Үүрэг нуур (Монгол-Алтай), Увс нуур, Тэс ба Торхилог гол (Увс нуурын хотгор), Хар-Ус нуурын Улаан уул, Хар Ямаат уул, Хар, Дөргөн, Хяргас, Айраг нуур, Ховд гол (Их Нууруудын Хотгор), Завхан, Хүнгүй гол, Их Богд (Говь-Алтай), Идэр, Чулуут Тамир, Орхон гол, Сангийн Далай, Өгий нуур (Хангай), Тэрхийн Цагаан, Сангийн Далай, Тэлмэн, Хар нуурын сав (Тарвагатай-Булнайн нуруу), Хөвсгөл нуур, Эгийн гол (Хөвсгөл), Шишхид гол, Доод Нуур (Дархадын Хотгор), Орхон, Сэлэнгэ, Эг, Хараа, Ерөө гол (Орхон-Сэлэнгийн сав), Туул, Онон, Балж, Хэрлэн гол (Хэнтий), Үлз, Дөч гол (Хэрлэн-Үлз голын сав), Халх, Дэгээ, Нөмрөг, Азарга гол (Буйр нуур-Халх гол-Хянган) үржинэ. Нүүдлийн үедээ ойт хээр, хээр болон говийн баян бүрдээр таарна (Gombobaatar et al., 2011).

Тоо толгой: Дэлхийн популяцийг 2006 онд 24,000-44,000 бие гүйцсэн бодгаль гэж үнэлсэн (Birdlife International, 2006). Түүнээс хойш тоо толгойн үнэлгээ хийгдээгүй. Манай оронд 1,000-1,500 бодгаль бий гэжээ (Болд ба Цэвээнмядаг, 2001).


Тоо толгойн чиг хандлага, нөлөөлж байгаа хүчин зүйлс: Малын тооны хэт өсөлт, уул уурхай, гол, нуурын экосистемийн бохирдол, хуурайшилт, усан цахилгаан станцтай холбоотой амьдрах орчны доройтол болон өвөл, зуны загасчлал зэрэг хүний олон талт шууд нөлөөнөөс шалтгаалан энэ зүйлийн тоо толгой буурч байна.

Худалдаа: Одоогоор манай орны хувьд гадаад худалдааны мэдээ баримт байхгүй. Өд, хошууг хэрэглэх зорилгоор агнаж байж болзошгүй.

Экологи, эдийн засгийн үнэлгээ: Монгол улсын ЗГ-ын 23-р тогтоолоор баталсан "Ан амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ"-гээр нэг бодгалийн үнэлгээ нь 204,000 төгрөг.

Хууль эрх зүйн орчин: Амьтны аймагт учирсан хохирлын нөхөн төлбөр: Эко-э.з. үнэлгээг 2 дахин өсгөж төлөх тухай АТХ-ийн 37-р зүйл; Гадаадад гаргах, худалдах зөвшөөрөл, гэрчилгээ: ХАУТГЭЗГХЗТХ-ийн 8-р зүйл; Хуулийн хариуцлага: ЗТХ-ийн 7.3.1., 7.6.1.-7.6.5., 11.22.3., 11.22.4. болон УТХГН-т агнасан барьсан тохиолдолд ЭХ-ийн 24.5.1.-р зүйлд заасан хариуцлага хүлээнэ. **ШУ, сургалт ба бусад зорилгоор гадаадад гаргасан байдал:** Гадаад улс руу тээвэрлэсэн мэдээ, баримт одоогоор байхгүй.

Эд, эрхтэн, бүтээгдэхүүн, тэдгээрийн хэрэглээ, таних онцлог: Эд, эрхтний худалдааны талаарх мэдээ, баримт одоогоор алга. Бие гүйцсэн шувууны хэвлий цагаан. Нуруу, хүзүү, толгой, гүеэ, далавч, сүүл ногоовор туяатай хар. Хошуу, нүдийг тойрсон нүцгэн арьс, хөл улаан. Дээрх шинжээр биеийн хэсгийг таньж болно.



ҮЛЭГ ХАРЦАГА

Багийн нэр: ACCIPITRIFORMES

Латин нэр: *Accipiter gentilis*

Түгээмэл буюу англи нэр: Northern goshawk

Конвенцийн хавсралт: II

Олон улсын ховордлын статус: Анхааралд өртөхөөргүй

Бүс нутгийн ховордлын статус: Анхааралд өртөхөөргүй

Статус: Нүүдлийн өндөглөдөг зүйл.

Амьдрах орчин: Шилмүүст болон холимог ой, голын хөндий, татмын ой шүгүй. хот суурин газрын цэцэрлэг. Тайгын болон ойт хээрийн навчит болон шилмүүст ой, Ховд голын хөндий (Монгол-Алтайн уулархаг муж), Хангай, Хэнтий, Хөвсгөлийн уулархаг муж, Орхон-Сэлэнгэ мөрний сав, Хэрлэн-Улз гол сав, Буйр нуур-Халх гол-Хянганы бүсэд үржинэ. Нүүдлийн үедээ дээрх газруудаас гадна Увсын Хотгор, Их Нууруудын Хотгор, Хан Хөхий, Тарвагатай, Булнай, Гурвансайхан уул, Нууруудын Хөндий, Дорнод Монголын тал хээрт байршина.

Тоо толгой: Дэлхийн популяци 1,000,000-2,500,000 бие гүйцсэн бодгаль гэж үнэлэгдсэн (BirdLife International, 2017). Манай оронд тоо толгойг нэгтгэн гаргасан баримт байхгүй.

Тоо толгойн чиг хандлага, нөлөөлж байгаа хүчин зүйлс: Тоо толгой буурах гол шалтгаан нь үржлийн нутагт модыг зүй бусаар ашиглах, уул уурхай, жуулчны бааз байгуулах гал түймэр тавих зэргээр амьдрах орчныг доройтуулах,

Арабын шонхорын наймаачдын идлэг шонхор барихаар тавьсан урхитай тагтааг барьж эндэх, бэлчээрийн хордуулсан мэрэгчээр хооллох, хууль бусаар барих зэрэг болно (Gombobaatar et al., 2011).


Худалдаа: Одоогоор манай орны хувьд гадаад худалдааны мэдээ баримт байхгүй.

Экологи, эдийн засгийн үнэлгээ: Монгол улсын ЗГ-ын 23-р тогтоолоор баталсан “Ан амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ”-гээр нэг бодгалийн экологи-эдийн засгийн үнэлгээ нь 86,000 төгрөг болно.

Хууль эрх зүйн орчин: Амьтны аймагт учирсан хохирлын нөхөн төлбөр: Эко-э.з. үнэлгээг 2 дахин өсгөж төлөх тухай АТХ-ийн 37-р зүйл; Гадаадад гаргах, худалдах зөвшөөрөл, гэрчилгээ: ХАУТГЭЗГХЗТХ-ийн 8-р зүйл; Хуулийн хариуцлага: ЗТХ-ийн 7.3.1., 7.6.1.-7.6.5., 11.22.3., 11.22.4. болон УТХГН-т агнасан барьсан тохиолдолд ЭХ-ийн 24.5.1.-р зүйлд заасан хариуцлага хүлээнэ.

ШҮ, сургалт ба бусад зорилгоор гадаадад гаргасан байдал: Гадаад улс руу тээвэрлэсэн мэдээ, баримт одоогоор байхгүй.

Эд, эрхтэн, бүтээгдэхүүн, тэдгээрийн хэрэглээ, таних онцлог: Манай улсад энэ зүйлийг ан авд сургах, гэрэл зураг татуулах зорилгоор хувь хүн, ТББ-ууд хууль бусаар барьдаг. Түүний хүмс, сарвууг мөнгөлөн бэлэг дурсгалын дэлгүүрт зарж байх боломжтой.



ЦАРМЫН БҮРГЭД

Багийн нэр: ACCIPITRIFORMES

Латин нэр: *Aquila chrysaetos*

Түгээмэл нэр: Golden eagle

Адилцах нэр: -

Конвенцийн хавсралт: II

Олон улсын ховордлын статус: Анхааралд өртөхөөргүй

Бүс нутгийн ховордлын статус: Анхааралд өртөхөөргүй

Статус: Суурин өндөглөдөг зүйл

Амьдрах орчин: Монгол орны тарвага, зурам, туулай зэрэг мэрэгч, туулай хэлбэртэн ихтэй өндөр уулс, тал хээрийн бүсийн хад цохио бүхий уулын хажуу, уулын ойт хээрийн задгай энгэр бүхий чулуурхаг орчныг бараадан үүрлэнэ. Уулын хөндий, хээрийн ухаа толгод бүхий орчинд тэжээлийн нөөцөөс хамааран өвөлжинө.

Тоо толгой: Тоо толгойн талаарх мэдээ, баримт хомс. 2001 оны байдлаар Казакууд нийт 300 гаруй цармын бүргэдийг тэжээж, ан ав хийхэд ашиглаж байсан (MNE & JICA, 2001). Дэлхийн популяци нь 170,000 бие гүйцсэн бодгалиас тогтоно (BirdLife International, 2011).

Тоо толгойн чиг хандлага, нөлөөлж байгаа хүчин зүйлс:

- Арабын шонхорын наймаачдын идлэг барих зорилгоор тавьсан тагтааны урхинд эндэнэ.
- Чихмэл хийх, эсвэл хөл, хумс, толгой, өд зэргээр бэлэг дурсгалын эд зүйл хийх зорилгоор хууль бусаар буудаж хороодог.
- Аялал жуулчлал, гэрэл зураг, видео бичлэг хийх зориулалтаар зөвшөөрөлгүй барьж ашиглах хандлага ихэсч байна.
- Хавар мал төлөх үеэр ишиг, хурга шүүрч болзошгүй хэмээн буудаж хөнөөдөг.

•Өндөр хүчдэлд цохиулж, эсвэл мөргөж үхдэг.

•Үлийн цагаан оготны эсрэг хэрэглэсэн хор бромадиолоныг идсэн үлийн оготно болон бусад мэрэгчдийг идсэнээр дам байдлаар хордоно.

Худалдаа: Барьсан залуу шувуу, үүрнээс авсан ангаахайг зарна. Хууль бус аргаар агнасан бүргэдийн хумсыг түлхүүрийн оосор, өдийг нум сум болон бөөгийн хэрэглэд ашиглана. Японы нум суманд хэрэглэхээр Монгол улсаас өдийг нь Япон руу гаргаж байсан баримт бий.

Экологи, эдийн засгийн үнэлгээ: Монгол улсын ЗГ-ын 23-р тогтоолоор баталсан “Ан амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ”-гээр нэг бүргэдийн экологи-эдийн засгийн үнэлгээ нь 402,000 төгрөг болно. Дээрх тогтоолоор баталсан “Ан амьтны нөөц ашигласны төлбөр, ан амьтан агнах, барих зөвшөөрлийн хураамжийн хэмжээ”-г нэг бүргэдийн хувьд соёл шинжлэх ухаан, эмчилгээний зориулалтаар агнах, барихад 80,400 төгрөг байхаар тогтоожээ.


Хууль эрх зүйн орчин: Амьтны аймагт учирсан хохирлын нөхөн төлбөр: Эко-э.з. үнэлгээг 2 дахин өсгөж төлөх тухай АТХ-ийн 37-р зүйл; Гадаадад гаргах, худалдах зөвшөөрөл, гэрчилгээ: ХАУТГЭЗГХЗТХ-ийн 8-р зүйл; Хуулийн хариуцлага: ЗТХ-ийн 7.3.1., 7.6.1.-7.6.5., 11.22.3., 11.22.4. болон УТХГН-т агнасан барьсан тохиолдолд ЭХ-ийн 24.5.1.-р зүйлд заасан хариуцлага хүлээнэ. **ШҮ, сургалт ба бусад зорилгоор гадаадад гаргасан байдал:** Гадаад улс руу амьдаар тээвэрлэсэн баримт одоогоор байхгүй.

Эд, эрхтэн, бүтээгдэхүүн, тэдгээрийн хэрэглээ, таних онцлог:

•Цармын бүргэдийн өдийг нум сумны үүсгэрийн өд болгон ашигладаг бөгөөд зарим төрийн бус байгууллагууд гадаад улсад экспортоддог.

•Цармын бүргэдийн хөл, хумс зэргийг гоёлын зүүлт, түлхүүрийн оосор болон бөө, шашны эд зүйл хийхэд ашиглаж байна.

•Хатаасан толгой, хошууг бэлэг дурсгалын зүйл, ханын чимэглэл, хувцасны гоёлд ашиглана.



ТАРВАЖИ БҮРГЭД

Багийн нэр: ACCIPITRIFORMES

Латин нэр: *Aquila nipalensis*

Тэгээмэл буюу англи нэр: Steppe eagle

Конвенцийн хавсралт: II

Олон улсын ховордлын статус: Устаж болзошгүй

Бүс нутгийн ховордлын статус: Анхааралд өртөхөөргүй

Статус: Нүүдлийн өндөглөдөг зүйл

Амьдрах орчин: Монгол орны бэсрэг уулс, ойт хээр, тал хээр, цөлөрхөг хээрийн уулс хоорондын хөндийн мэрэгчид, ялангуяа үлийн цагаан оготно элбэгтэй нутагт түгээмэл тохиолдох хүчирхэг бүргэд бөгөөд 1- 3 ширхэг, гол төлөв 2 өндөг гаргана.

Тоо толгой: Дэлхийн популяци 50,000-75,000 бие гүйцсэн бодгалтай бөгөөд тоо толгой буурч байгаа (Birdlife International, 2017). Манай оронд 1,500-2,000 хосоос цөөнгүй бий.

Тоо толгойн чиг хандлага, нөлөөлж байгаа хүчин зүйлс: Тоо толгой буурах гол шалтгаан нь малын тоо толгойн хэт өсөлт, уул уурхай, ой, хээрийн түймэр нь амьдрах орчныг доройтох, хордсон мэрэгчээр хооллох, Арабын шонхор баригчдын тавьсан урхитай тагтааг барих, өндөр хүчдэлд цохиулах, мөргөх, үзмэр хийх, хөл, хумсыг гоёл чимэглэл хийх, эд эрхтнийг шашны зан үйлд ашиглах зорилгоор хууль бусаар агнах, хурга ишиг шүүрч болзошгүй гэж нутгийн малчид буудах, машинд мөргүүлэх зэрэг болно (Gombobaatar et al., 2011, 2017, 2018).

Мөн идэш бологч үлийн цагаан оготно, чичүүл зэрэг тал хээрийн мэрэгчид ховордох нь энэ зүйл бүргэдийн үржлийн амжилт буурах шалтгаан болно.

Худалдаа: 2004, 2006 онд агнуурын зорилгоор 2 бодгалийг агнуулан АНУ руу гаргасан.

Экологи, эдийн засгийн үнэлгээ: Монгол Улсын ЗГ-ын 23-р тогтоолоор баталсан “Ан амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ”-гээр нэг бүргэдийн экологи-эдийн засгийн үнэлгээ нь 253,000 төгрөг болно.


Хууль эрх зүйн орчин: Амьтны аймагт учирсан хохирлын нөхөн төлбөр: Эко-э.з. үнэлгээг 2 дахин өсгөж төлөх тухай АТХ-ийн 37-р зүйл; Гадаадад гаргах, худалдах зөвшөөрөл, гэрчилгээ: ХАУТГЭЗГХЗТХ-ийн 8-р зүйл; Хуулийн хариуцлага: ЗТХ-ийн 7.3.1., 7.6.1.-7.6.5., 11.22.3., 11.22.4. болон УТХГН-т агнасан барьсан тохиолдолд ЭХ-ийн 24.5.1.-р зүйлд заасан хариуцлага хүлээнэ. **ШҮ, сургалт ба бусад зорилгоор гадаадад гаргасан байдал:**

2002, 2006, 2009, 2011 онд шинжлэх ухааны зорилгоор шувууны дээжийг АНУ, Герман, Словак улс руу гаргасан.

Эд, эрхтэн, бүтээгдэхүүн, тэдгээрийн хэрэглээ, таних онцлог:

•Хээрийн бүргэдийн хөл, хумсыг гоёлын зүүлт, түлхүүрийн оосор болон бөөгийн шашны эд зүйл хийхэд бусад бүргэдээс ялгалгүйгээр ашиглаж байна. Эдгээрийг хооронд нь ялгахад ихээхэн хүндрэлтэй бөгөөд цармын бүргэдийн сарвуу, хумс арай том байдаг онцлогтой. Хөл нь хуруугаа хүртэл өдөөр бүрхэгдсэн. Гэхдээ энэ нь таних чухал шинж болохгүй.

•Дэвүүр болон залуур өдийг бөө, шашны зан үйлд ашигладаг. Дэвүүр болон залуур өд олон хөндлөн бараан судалтай.



ШИЛИЙН САР

Багийн нэр: ACCIPITRIFORMES

Латин нэр: *Buteo hemilasius*

Түгээмэл буюу англи нэр: Upland buzzard

Конвенцийн хавсралт: II

Олон улсын ховордлын статус: Анхааралд өртөхөөргүй

Бүс нутгийн ховордлын статус: Анхааралд өртөхөөргүй

Статус: Суурин өндөглөдөг зүйл

Амьдрах орчин: Тал хээр, ойт хээр, голын хөндий, татам, нуга. Монгол-Алтай, Говь-Алтай, Их Нууруудын Хотгор, Хангай, Хөвсгөл, Хэнтий (тайга болон д.т.д 3,000 м-ээс дээш газрууд орохгүй), Дундад Халхын хээр, Дорнод Монголын хээр, Буйр нуур-Халх гол-Хянган, Нууруудын Хөндий, Хойд ба Зүүн говийн хотгорт идэш тэжээлийн элбэгшлээс хамааран үржинэ.

Тоо толгой: Дэлхийн популяци 2001 онд 10,000 бие гүйцсэн бодгальтай гэж үнэлэгдсэн боловч түүнээс хойш тоо толгойн үнэлгээ хийгдээгүй байна. Монгол орон даяар тоо толгойн үнэлгээ хийгдээгүй.

Тоо толгойн чиг хандлага, нөлөөлж байгаа хүчин зүйлс: Тоо толгой буурах гол шалтгаан нь малын тоо толгойн хэт өсөлт, уул уурхай, газрын тос олборлолт, хээрийн түймэр зэргээс шалтгаалсан амьдрах орчин доройтох, хордуулсан мэрэгчээр хооллох, өндөр хүчдэлд цохиулах, өндөр хүчдэл дээрх үүрний өндөг,

ангаахайг зориудаар унагах, хууль бусаар агнах, машинд мөргүүлэх зэрэг болно (Gombobaatar et al., 2011).

Худалдаа: 2016 онд хувийн хэрэгцээнд 1 хөлийг АНУ руу гаргасан. 2007 онд БНСУ-аас 1 шувууг импортолсон.

Экологи, эдийн засгийн үнэлгээ: Монгол улсын ЗГ-ын 23-р тогтоолоор баталсан “Ан амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ”-гээр нэг бодгалийн экологи-эдийн засгийн үнэлгээ нь 84,000 төгрөг болно.

Хууль эрх зүйн орчин: Амьтны аймагт учирсан хохирлын нөхөн төлбөр: Эко-э.з. үнэлгээг 2 дахин өсгөж төлөх тухай АТХ-ийн 37-р зүйл; Гадаадад гаргах, худалдах зөвшөөрөл, гэрчилгээ: ХАУТГЭЗГХЗТХ-ийн 8-р зүйл; Хуулийн хариуцлага: ЗТХ-ийн 7.3.1., 7.6.1.-7.6.5., 11.22.3., 11.22.4. болон УТХГН-т агнасан барьсан тохиолдолд ЭХ-ийн 24.5.1.-р зүйлд заасан хариуцлага хүлээнэ.


ШУ, сургалт ба бусад зорилгоор гадаадад гаргасан байдал:

1981 онд ЗХУ руу амьтны хүрээлэнд, 2000, 2002, 2006, 2011, 2012 онд шинжлэх ухааны зорилгоор дээж, өндөг зэргийг АНУ, Герман улс руу гаргасан.

Эд, эрхтэн, бүтээгдэхүүн, тэдгээрийн хэрэглээ, таних онцлог:

- Хөл, хумсыг гоёлын зүүлт, түлхүүрийн оосор болон бөөгийн шашны эд зүйл хийхэд ашиглаж байна. Хөл нь хуруугаа хүртэл өдөөр бүрхэгдсэн байдгаараа онцлог.

- Дэвүүр болон залуур өдийг шашны зан үйлд ашигладаг.



СОХОР ЭЛЭЭ

Багийн нэр: ACCIPITRIFORMES

Латин нэр: *Milvus migrans*

Түгээмэл буюу англи нэр: Black kite

Конвенцийн хавсралт: II

Олон улсын ховордлын статус: Анхааралд өртөхөөргүй

Бүс нутгийн ховордлын статус: Анхааралд өртөхөөргүй

Статус: Нүүдлийн өндөглөдөг зүйл.

Амьдрах орчин: Монгол орны тайгаас говь цөл хүртэлх хад цохио, мод бүхий үүрлэх боломжтой бүх газарт тархсан. Хот суурин газрын ойролцоо харьцангуй олон тоогоор байршина.

Тоо толгой: Дэлхийн популяци 1,000,000-2,500,000 бодгальтай (Birdlife International, 2017). Манай орны популяцийн хэмжээ тодорхойгүй.

Тоо толгойн чиг хандлага, нөлөөлж байгаа хүчин зүйлс: Тоо толгойд сөргөөр нөлөөлж буй хүчин зүйл бол ойг зүй бусаар ашиглах, түймэр зэргээс шалтгаалсан амьдрах орчны доройтол, үлийн цагаан оготно цөөлөх зорилгоор цацсан хорт бдист хордох, элэг нь хүний элэгний хорт хавдрыг анагаадаг хэмээх цуу үгэнд итгэж хууль бусаар агнах, арилжих, хурга ишиг шүүрч болзошгүй гэж нутгийн малчид буудан хороох зэрэг болно (Gombobaatar et al., 2011, 2017, 2018).


Худалдаа: 2006 онд агнуурын зорилгоор 1 бодгалийг агнуулан АНУ руу гаргажээ.

Экологи, эдийн засгийн үнэлгээ: Монгол улсын ЗГ-ын 23-р тогтоолоор баталсан “Ан амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ”-гээр нэг бодгалийн экологи-эдийн засгийн үнэлгээ нь 78,000 төгрөг болно.

Хууль эрх зүйн орчин: Амьтны аймагт учирсан хохирлын нөхөн төлбөр: Эко-э.з. үнэлгээг 2 дахин өсгөж төлөх тухай АТХ-ийн 37-р зүйл; Гадаадад гаргах, худалдах зөвшөөрөл, гэрчилгээ: ХАУТГЭЗГХЗТХ-ийн 8-р зүйл; Хуулийн хариуцлага: ЗТХ-ийн 7.3.1., 7.6.1.-7.6.5., 11.22.3., 11.22.4. болон УТХГН-т агнасан барьсан тохиолдолд ЭХ-ийн 24.5.1.-р зүйлд заасан хариуцлага хүлээнэ. **ШҮ, сургалт ба бусад зорилгоор гадаадад гаргасан байдал:** 2002, 2006, 2011 онд шинжлэх ухааны зорилгоор дээж, өд, өндөг зэргийг АНУ, Герман улс руу гаргасан.

Эд, эрхтэн, бүтээгдэхүүн, тэдгээрийн хэрэглээ, таних онцлог:

•Хөл, хумсыг гоёлын зүүлт, түлхүүрийн оосор болон бөөгийн шашны эд зүйл хийхэд ашиглана. Мөн элгийг ардын эмчилгээнд хэрэглэх зорилгоор буудаж хөнөөнө. Бие гүйцсэн шувуу нь бусад махчин шувуудаас ац хэлбэрийн сүүлээрээ ялгагдана. Мөн нүцгэн шилбэ болон цайвар шаргал зэтэр нь бусад зүйл сараас харьцангуй жижиг, нарийн байдаг онцлогтой.



СААРАЛ ХҮЛД

Багийн нэр: ACCIPITRIFORMES

Латин нэр: *Circus cyaneus*

Түгээмэл буюу англи нэр: Hen harrier

Олон улсын ховордлын статус: Анхааралд өртөхөөргүй

Бүс нутгийн ховордлын статус: Анхааралд өртөхөөргүй

Статус: Нүүдлийн өндөглөдөг зүйл

Амьдрах орчин: Хээр тал, голын хөндий, зэгс бүхий ус намаг, ойт хээрт амьдардаг. Орхон, Сэлэнгэ (Орхон-Сэлэнгэ голын сав), Онон, Балж гол (Хэнтийн уулархаг муж), Халх, Дэгээ, Нөмрөг, Цагаан Чулуут, Азарга гол, Буйр, Шавар, Ташгайн Таван нуур (Буйр нуур-Халх гол-Хянган)-т үрждэг. Нүүдлийн үедээ Монгол-Алтай, Их Нууруудын Хотгор, Хангай, Хөвсгөл, Дархадын Хотгор, Орхон-Сэлэнгэ голын сав, Хэнтий, Дундад Халхын хээр, Дорнод Монголын хээр, Буйр нуур-Халх гол-Хянган, Нууруудын хөндий, Зүүнгарын говиор тохиолдоно.

Тоо толгой: Дэлхийн популяци 2011 онд 1,300,000 бие гүйцсэн бодгаль байсан бол өдгөө 100,000- 500,000 болж буурсан байна (Birdlife International, 2017).

Тоо толгойн чиг хандлага, нөлөөлж байгаа

хүчин зүйлс: Үржлийн нутагт малын тоо ихсэх, уул уурхай болон усан цахилгаан станц, аялал жуулчлалын бааз байгуулах зэргээр хуурайшилтыг түргэсгэн нуур, голын зэгсийг талхлах, түймэр гарах зэрэг нь ус намгархаг газрыг доройтуулж, үржлийн амжилтыг бууруулж байна. Мөн бэлчээрийн хортон мэрэгч цөөлөх зорилгоор хэрэглэсэн хоронд идэш тэжээлээр дамжин хордож энддэг (Gombobaatar et al., 2011).

Худалдаа: Одоогоор манай орны хувьд гадаад худалдааны мэдээ баримт байхгүй.

Экологи, эдийн засгийн үнэлгээ: Монгол улсын ЗГ-ын 23-р тогтоолоор баталсан “Ан амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ”-гээр нэг бодгалийн экологи-эдийн засгийн үнэлгээ нь 36,000 төгрөг болно.

Хууль эрх зүйн орчин: Амьтны аймагт учирсан хохирлын нөхөн төлбөр: Эко-э.з. үнэлгээг 2 дахин өсгөж төлөх тухай АТХ-ийн 37-р зүйл; Гадаадад гаргах, худалдах зөвшөөрөл, гэрчилгээ: ХАУТГЭЗГХЗТХ-ийн 8-р зүйл; Хуулийн хариуцлага: ЗТХ-ийн 7.3.1., 7.6.1.-7.6.5., 11.22.3., 11.22.4. болон УТХГН-т агнасан барьсан тохиолдолд ЭХ-ийн 24.5.1.-р зүйлд заасан хариуцлага хүлээнэ. **ШҮ, сургалт ба бусад зорилгоор гадаадад гаргасан байдал:** Шинжлэх ухааны зорилгоор эдийн дээж, өд, өндөг зэргийг гадаад улс руу гаргасан баримтгүй.

Эд, эрхтэн, бүтээгдэхүүн, тэдгээрийн хэрэглээ, таних онцлог: Хөл, хумсыг гоёлын зүүлт, түлхүүрийн оосор болон бөөгийн шашны эд зүйл хийхэд ашиглана. Мөн элээтэй андууран буудах эрсдэл ихтэй.



ООЧ ЁЛ

Багийн нэр: ACCIPITRIFORMES

Латин нэр: *Gypaetus barbatus*

Түгээмэл буюу англи нэр: Lammergeier or Bearded vulture

Олон улсын ховордлын статус: Ховордож болзошгүй

Бүс нутгийн ховордлын статус: Эмзэг

Статус: Суурин өндөглөдөг зүйл.

Амьдрах орчин: Ихэвчлэн өндөр уулсын эгц өндөр хад асгатай орчин, тал хээрийн өндөр хадан цохио шүтэн тархдаг. Монгол Алтайн нуруу, түүний дундаас Говь Гурван Сайхан уулын Ёлын аманд элбэг ч, Алтайн нурууны зүүн үзүүрийн салбар уулс болох Нэмэгт, Сэврэй, Ноён, Баян Бор нуруу зэрэг говийн уулсаар харьцангуй элбэг тааралдана. Хүн, амьтан хүрэхэд бэрх эгц өндөр халил бүхий хадан цохионд ургамлын иш, мөчир, малын яс, үсээр үүр засна.

Тоо толгой: Дэлхийн популяци 2011 онд 2,000 - 10,000 бие гүйцсэн бодгальтай байсан бол өдгөө 1,300- 6,700 болж буурсан байна (Birdlife International, 2011, 2017). Монгол оронд тоо толгойн талаарх мэдээлэл байхгүй.

Тоо толгойн чиг хандлага, нөлөөлж байгаа хүчин зүйлс: Тоо толгой буурах гол шалтгаан нь уул уурхай, аялал жуулчлалын баазыг хэт олноор байгуулах, бохирдол болон хуурайшилт зэргээс шалтгаалсан амьдрах орчны доройтол, чихмэл зэрэг үзмэр хийх, эд эрхтнийг ардын эмчилгээ,

гоёл чимэглэлд ашиглах зорилгоор хууль бусаар агнах, хурга ишиг шүүрч болзошгүй гэж нутгийн малчид буудан хороох зэрэг болж байна (Gombobaatar et al., 2011, 2017, 2018).

Худалдаа: 2002, 2004 онд агнуурын зорилгоор 2 бодгалийг АНУ руу гаргажээ.


Экологи, эдийн засгийн үнэлгээ: Монгол улсын ЗГ-ын 23-р тогтоолоор баталсан “Ан амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ”-гээр нэг бодгалийн экологи-эдийн засгийн үнэлгээ нь 540,000 төгрөг болно.

Хууль эрх зүйн орчин: Амьтны аймагт учирсан хохирлын нөхөн төлбөр: Эко-э.з. үнэлгээг 2 дахин өсгөж төлөх тухай АТХ-ийн 37-р зүйл; Гадаадад гаргах, худалдах зөвшөөрөл, гэрчилгээ: ХАУТГЭЗГХЗТХ-ийн 8-р зүйл; Хуулийн хариуцлага: ЗТХ-ийн 7.3.1., 7.6.1.-7.6.5., 11.22.3., 11.22.4. болон УТХГН-т агнасан барьсан тохиолдолд ЭХ-ийн 24.5.1.-р зүйлд заасан хариуцлага хүлээнэ.

ШҮ, сургалт ба бусад зорилгоор гадаадад гаргасан байдал: 2002 онд шинжлэх ухааны зорилгоор шувууны дээжийг АНУ руу гаргасан.

Эд, эрхтэн, бүтээгдэхүүн, тэдгээрийн хэрэглээ, таних онцлог: Амьдаар худалдсан тухай баримт одоогоор байхгүй. Чихмэл хийж олон нийтийн үйлчилгээний байгууллагад ховор худалдана. Тас, бүргэд зэрэгтэй андуурч буудна. Мах, ходоод зэрэг дотор эрхтнийг үнэлэн нууцаар худалдана.

-52-



НӨМРӨГ ТАС

Багийн нэр: ACCIPITRIFORMES

Латин нэр: *Aegypus monachus*

Түгээмэл буюу англи нэр: Cinereous vulture

Адилцах нэр: Black vulture, Eurasian black vulture

Конвенцийн хавсралт: II

Олон улсын ховордлын статус: Ховордож болзошгүй

Бүс нутгийн ховордлын статус: Анхааралд өртөхөөргүй

Статус: Суурин өндөглөдөг зүйл

Амьдрах орчин: Уулын ойт хээр, өндөр уулсаас тал хээр, цөлөрхөг хээр хүртэл уудам нутагт өргөн тархсан зүйл бөгөөд уулсын оройн болон хажуугийн хадан цохио, шилмүүст модонд үүрлэнэ. Залуу шувууд Өмнөд Солонгос, Хятад, Непал руу нүүнэ. Өвөлжих болон улирлын шилжилтийн үедээ Монгол орны тайгын ой, жинхэнэ цөлөөс бусад амьдрах орчинд таарна.

Тоо толгой: Тоо толгойн талаарх мэдээ, баримт хомс. Дэлхийн популяци 15,600-21,000 бие гүйцсэн бодгальтай бөгөөд тоо толгой буурч байгаа (Birdlife International, 2017).


Тоо толгойн чиг хандлага, нөлөөлж байгаа хүчин зүйлс: Тоо толгой нь харьцангуй тогтвортой. Гэхдээ нөлөөлөх олон хүчин зүйл бий. Малын нөлөөгөөр үүрлэх орчин хумигдаж байна. Хулгайгаар агнаж хумс, өдийг нь шашны зан үйлд ашиглахаас гадна цармын бүргэдийн хамт жуулчинд үзүүлэхээр үүрнээс нь ангаахайг барьдаг. Нутгийн иргэд бүргэдтэй андууран буудна. Өндөр хүчдэлд цохиулж болон утас мөргөж үхдэг.

Ангаахай хөгжлийн эртний шатандаа осгож, өлсөж энддэг (Gombobaatar et al., 2011).

Худалдаа: Зарим Казак иргэд ангаахайг үүр дээрээс нь хууль бусаар барьж, тохиромж муутай тор, хашаанд байлгаснаар зарим шувууд эндэж байна. Барьсан залуу шувуу, үүрнээс авсан ангаахайг зарна. Хууль бус аргаар агнасан тасын хумсыг түлхүүрийн оосор, өдийг бөөгийн үйлд ашиглахаас гадна зарим шувууг чихмэл хийж олон нийтийн үйлчилгээний газар байрлуулна.

Экологи, эдийн засгийн үнэлгээ: Монгол улсын ЗГ-ын 23-р тогтоолоор баталсан “Ан амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ”-гээр нэг тасын үнэлгээ нь 972,000 төгрөг болно. Дээрх тогтоолоор баталсан “Ан амьтны нөөц ашигласны төлбөр, ан амьтан агнах, барих зөвшөөрлийн хураамжийн хэмжээ”-г нэг тасын хувьд соёл шинжлэх ухаан, эмчилгээний зориулалтаар агнах, барихад 194,400 төгрөг байна.

Хууль эрх зүйн орчин: Амьтны аймагт учирсан хохирлын нөхөн төлбөр: Эко-э.з. үнэлгээг 2 дахин өсгөж төлөх тухай АТХ-ийн 37-р зүйл; Гадаадад гаргах, худалдах зөвшөөрөл, гэрчилгээ: ХАУТГЭЗГХЗТХ-ийн 8-р зүйл; Хуулийн хариуцлага: ЗТХ-ийн 7.3.1., 7.6.1.-7.6.5., 11.22.3., 11.22.4. болон УТХГН-т агнасан барьсан тохиолдолд ЭХ-ийн 24.5.1.-р зүйлд заасан хариуцлага хүлээнэ. **ШҮ, сургалт ба бусад зорилгоор гадаадад гаргасан байдал:** Манай орноос нэг бодгалийг АНУ-ын Денверийн амьтны хүрээлэн рүү гаргав. **Эд, эрхтэн, бүтээгдэхүүн, тэдгээрийн хэрэглээ, таних онцлог:** Чихмэл хийж олон нийтийн үйлчилгээний байгууллагад худалдана. Өдийг шашны үйлд, харин саврыг мөнгөлөн бэлэг дурсгалын дэлгүүрт зарж байна. Өд нь судал толбогүй хар хүрэн. Саврын хумс нь мохоодуу, харьцангуй шулуун, богино байдгаараа бүргэдийнхээс ялгарна.



ИДЛЭГ ШОНХОР

Багийн нэр: FALCONIFORMES

Латин нэр: *Falco cherrug*

Түгээмэл буюу англи нэр: Saker falcon

Адилцах нэр: Saker

Конвенцийн хавсралт: II

Олон улсын ховордлын статус: Устаж болзошгүй

Бүс нутгийн ховордлын статус: Эмзэг

Статус: Суурин өндөглөдөг зүйл

Амьдрах орчин: Уулын ойт хээр, далайн төвшнөөс дээш 3,000 м-ээс доош өндөр уулсаас тал хээр, цөлөрхөг хээр хүртэл уудам нутгийн мэрэгч, жижиг туулай хэлбэртэн, идэш тэжээл бологч шувуу ихтэй уулсын оройн болон хажуугийн хадан цохио, модонд үүрлэнэ.

Тоо толгой: Тоо толгойг нь одоогоор нэгтгэн гаргаагүй. 1999 оны судалгаагаар манай орны идлэг шонхор нийт 3,000 үржлийн хостой. Харин 2000 онд 2,200 хос болжээ (Shagdarsuren et al., 2001). 2002 оны тооллогоор нийт идлэг шонхорын тоо нь 6,050 бодгаль байна гэжээ. 1998-2005 онд манай орны идлэг шонхорын нягтшил 100 км²-д дунджаар 0.47 бодгаль байжээ (Гомбобаатар, 2006, 2013). Идлэг шонхорын 2018 оны тооллогоор Монгол орны популяци 10,380 бодгалиас тогтдог.


Тоо толгойн чиг хандлага, нөлөөлж байгаа хүчин зүйлс: Тоо толгой харьцангуй тогтвортой ч цөөрөх хандлага ажиглагдаж байгаа нь шонхорын тусгай зөвшөөрөлтэй болон хууль бус худалдаа, өндөр хүчдэлд цохиулан эндэх, хордох, идэш тэжээл хомсдохтой шууд холбоотой. Өндөг, ангаахайн зүй бус хорогдол, шувууны ханиад, цахилгаан шугамын ажилчид сөргөөр нөлөө үзүүлж байна (Гомбобаатар, 2003, 2013).

Худалдаа: Монгол орноос хууль бусаар гадаадад гарсан шонхорын бодит, мэдээ баримт алга. Монгол Улсын ЗГ-аас Саудын Араб, Кувейт, АНЭУ, Катар зэрэг дундад дорны олон улс руу гаргаж байна. 1994-1995 онд нийт 80 бодгалийг, 1996 онд 25 бодгалийг, 1997 онд 202 бодгалийг, 1998 онд 25 бодгалийг Кувейт, 1999 онд 21 бодгалийг, 2000 онд 50 бодгалийг, 2001 онд 184 бодгалийг, 2002 онд 303 бодгалийг, 2003 онд 392 бодгаль, 2004 онд 365, 2005 онд 385, 2006 онд 185, 2007 онд 233, 2008 онд 204, 2009 онд 292, 2010 онд 216, 2011 онд 140, 2012 онд 148 бодгалийг Саудын Араб, Кувейт, АНЭУ, Катар, Сири зэрэг улс руу албан ёсоор гаргажээ (Гомбобаатар, 2006, 2013).

Экологи, эдийн засгийн үнэлгээ: Монгол улсын ЗГ-ын 23-р тогтоолоор баталсан “Ан амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ”-гээр нэг шонхорын үнэлгээ нь 16,000,000 төгрөг болно. Дээрх тогтоолоор баталсан “Ан амьтны нөөц ашигласны төлбөр, ан амьтан агнах, барих зөвшөөрлийн хураамжийн хэмжээ”-г нэг шонхорын хувьд соёл шинжлэх ухаан, эмчилгээний зориулалтаар агнах, барихад 3,200,000 төгрөг байхаар тогтоожээ.

Хууль эрх зүйн орчин: Амьтны аймагт учирсан хохирлын нөхөн төлбөр: Эко-э.з. үнэлгээг 2 дахин өсгөж төлөх тухай АТХ-ийн 37-р зүйл; Гадаадад гаргах, худалдах зөвшөөрөл, гэрчилгээ: ХАУТГЭЗГХЗТХ-ийн 8-р зүйл; Хуулийн хариуцлага: ЗТХ-ийн 7.3.1., 7.6.1.-7.6.5., 11.22.3., 11.22.4. болон УТХГН-т агнасан барьсан тохиолдолд ЭХ-ийн 24.5.1.-р зүйлд заасан хариуцлага хүлээнэ. **ШҮ, сургалт ба бусад зорилгоор гадаадад гаргасан байдал:** 1994-2012 онд нийт 2,816 толгой шонхорыг Арабын улс руу гаргажээ.

Эд, эрхтэн, бүтээгдэхүүн, тэдгээрийн хэрэглээ, таних онцлог: Чихмэл хийж олон нийтийн үйлчилгээний байгууллагад худалдана. Өдийг шашны үйлд, харин саврыг мөнгөлөн бэлэг дурсгалын дэлгүүрт олноор зарж байна. Өд нь хөндлөн бор хүрэн судалтай.



НАЧИН ШОНХОР

Багийн нэр: FALCONIFORMES

Латин нэр: *Falco tinnunculus*

Түгээмэл нэр: Common kestrel

Адилцах нэр: Kestrel

Конвенцийн хавсралт: II

Олон улсын ховордлын статус: Анхааралд өртөхөөргүй

Бүс нутгийн ховордлын статус: Анхааралд өртөхөөргүй

Статус: Өндөглөн зусдаг нүүдлийн зүйл

Амьдрах орчин: Ойт хээр, уулын хээр, говь, цөлийн хад, хавцал, элсэн эрэг, ойн зах, ойт хээр, хээрийн навчит болон шилмүүст модтой гуу жалга, сайр, голын хөндийд амьдарна. Монгол орны ус намаг, тайгын өтгөн шигүү ой, д.т.д 3,500 метрээс өндөр уулаас бусад бүх нутагт тархан үрждэг.

Тоо толгой: Дэлхийн популяцийн хэмжээ 4,000,000-6,500,000 бие гүйцсэн бодгаль гэж үнэлжээ (Birdlife International, 2017). Монгол орны популяцийн хэмжээ тодорхойгүй.

Тоо толгойн чиг хандлага, нөлөөлж байгаа хүчин зүйлс: Тоо толгой буурах гол шалтгаан нь малын хэт өсөлт, уул уурхай, ойн ашиглалт,


түймэр, аялал жуулчлалын зохисгүй үйл ажиллагааны улмаас амьдрах орчин доройтох, бохирдох, улмаар үржлийн нутгаас дайжих, үржлийн үед үүрэнд хүн мал ойртож үржлийн амжилтыг бууруулах, үлийн цагаан оготно цөөлөх зорилгоор хэрэглэсэн химийн хорт бодист дам хордож эндэх, иргэд идлэг шонхортой андууран хууль бусаар барих, худалдахыг оролдох, өндөр хүчдэлийн шугамын утас мөргөх, авто замын дээр машинд мөргүүлэх гэх мэт болно (Gombobaatar et al., 2011).

Худалдаа: 2002 онд агнуурын зорилгоор 3 бодгалийг АНУ руу гаргажээ.

Экологи, эдийн засгийн үнэлгээ: Монгол улсын ЗГ-ын 23-р тогтоолоор баталсан “Ан амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ”-гээр нэг бодгалийн экологи-эдийн засгийн үнэлгээ нь 21,000 төгрөг болно.

Хууль эрх зүйн орчин: Амьтны аймагт учирсан хохирлын нөхөн төлбөр: Эко-э.з. үнэлгээг 2 дахин өсгөж төлөх тухай АТХ-ийн 37-р зүйл; Гадаадад гаргах, худалдах зөвшөөрөл, гэрчилгээ: ХАВТГЭЗГХЗТХ-ийн 8-р зүйл; Хуулийн хариуцлага: ЗТХ-ийн 7.3.1., 7.6.1.-7.6.5., 11.22.3., 11.22.4. болон УТХГН-т агнасан барьсан тохиолдолд ЭХ-ийн 24.5.1.-р зүйлд заасан хариуцлага хүлээнэ. **ШҮ, сургалт ба бусад зорилгоор гадаадад гаргасан байдал:** 2002 онд шинжлэх ухааны зорилгоор 3 дээжийг АНУ гаргасан байна.

Эд, эрхтэн, бүтээгдэхүүн, тэдгээрийн хэрэглээ, таних онцлог: Идлэг шонхортой андууран худалдахаар завдсан баримт бий. Чихмэл хийж олон нийтийн үйлчилгээний байгууллагад худалдана. Харьцангуй жижиг биетэй төдийгүй зээрд хүрэн зүстэй. Хумсыг нь мөнгөлөн худалддаг ба жижиг хэмжээтэй байдгаараа ялгардаг.



ӨВӨГТ ТОГОРУУ

Багийн нэр: GRUIFORMES

Латин нэр: *Grus virgo*

Түгээмэл буюу англи нэр: Demoiselle crane

Адилцах нэр: *Anthropoides virgo*; Өвөгт тогируу

Конвенцийн хавсралт: II

Олон улсын ховордлын статус: Анхааралд өртөхөөргүй

Бүс нутгийн ховордлын статус: Анхааралд өртөхөөргүй

Статус: Өндөглөн зусдаг нүүдлийн зүйл

Амьдрах орчин: Жинхэнэ тайгын ой, өндөр уулс, говь цөлөөс бусад байгалийн бүс, бүслүүрт түгээмэл тохиолдоно. Ялангуяа голын хөндий, уулс хоорондын хөндий, задгай тал хээрт өндөр нягтшилтай амьдарна.

Тоо толгой: Манай орны хувьд тоо толгой нь тодорхойгүй. Дэлхийн популяци нь нийт 230,000-280,000 бие гүйцсэн бодгалиас тогтоно (BirdLife International, 2011).

Тоо толгойн чиг хандлага, нөлөөлж байгаа хүчин зүйлс: Одоогоор тоо толгой нь харьцангуй тогтвортой.


Мах идэшт хөхтөн, шувууд дэгдээхэйг идэх, үлийн цагаан оготныг цөөрүүлэх зорилгоор хэрэглэсэн хоронд хордох, өндөр хүчдэлийн шугам мөргөх, хуурайшил болон хүний хүчин зүйлийн нөлөөгөөр тоо толгой нь цөөрөх аюултай.

Худалдаа: Монгол орноос худалдсан тухай баримт байхгүй. Арьс болон өд хил гаалиар гарах эрсдэл их.

Экологи, эдийн засгийн үнэлгээ: Монгол улсын ЗГ-ын 23-р тогтоолоор баталсан “Ан амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ”-гээр нэг өвөгтийн экологи-эдийн засгийн үнэлгээ нь 112,000 төгрөг болно. Дээрх тогтоолоор баталсан “Ан амьтны нөөц ашигласны төлбөр, ан амьтан агнах, барих зөвшөөрлийн хураамжийн хэмжээ”-г нэг тогорууны хувьд соёл шинжлэх ухаан, эмчилгээний зориулалтаар агнах, барихад 22,400 төгрөг байхаар тогтоожээ.

Хууль эрх зүйн орчин: Амьтны аймагт учирсан хохирлын нөхөн төлбөр: Эко-э.з. үнэлгээг 2 дахин өсгөж төлөх тухай АТХ-ийн 37-р зүйл; Гадаадад гаргах, худалдах зөвшөөрөл, гэрчилгээ: ХАУТГЭЗГХЗТХ-ийн 8-р зүйл; Хуулийн хариуцлага: ЗТХ-ийн 7.3.1., 7.6.1.-7.6.5., 11.22.3., 11.22.4. болон УТХГН-т агнасан барьсан тохиолдолд ЭХ-ийн 24.5.1.-р зүйлд заасан хариуцлага хүлээнэ. ШҮ, сургалт ба бусад зорилгоор гадаадад гаргасан байдал: Мэдээ, баримт байхгүй.

Эд, эрхтэн, бүтээгдэхүүн, тэдгээрийн хэрэглээ, таних онцлог: Чихмэл хийж олон нийтийн үйлчилгээний байгууллагад ховор худалдана. Гээг мэт цагаан өд толгойн хажуугаас гарсан байдгаараа онцлогтой.



ЭГЭЛ ШАРШУВУУ

Багийн нэр: STRIGIFORMES

Латин нэр: *Bubo bubo*

Түгээмэл буюу англи нэр: Eagle owl

Адилцах нэр: Шар шувуу

Конвенцийн хавсралт: II

Олон улсын ховордлын статус: Анхааралд өртөхөөргүй

Бүс нутгийн ховордлын статус: Анхааралд өртөхөөргүй

Статус: Өндөглөдөг суурин зүйл

Амьдрах орчин: Манай орны говь цөл, гүн тайга, өндөр уулсын тагаас бусад байгалийн бүхий л бүс, бүслүүрийн хадан цохио, өндөр бут, бутлаг ургамал бүхий орчинд амьдарна.

Тоо толгой: Манай орны хувьд тоо толгой нь тодорхойгүй. Дэлхийд нийт 250,000-2,500,000 бодгаль байна (Birdlife International, 2011). Манай орны популяцийн тоо тодорхойгүй.


Тоо толгойн чиг хандлага, нөлөөлж байгаа хүчин зүйлс: Тоо толгой нь харьцангуй тогтвортой. Малын тооны өсөлт, уул уурхай зэрэг хүний нөлөөнөөс хамааран амьдрах орчин алдагдах, өндөр хүчдэлийн шугамын утас мөргөх зэрэг шалтгаанаар олноор энддэг. Казак иргэд болон бөө зан үйлдээ ашиглах зорилгоор хууль бусаар агнаж, мах, савар, өдийг нь зарж байна.

Худалдаа: 1998 онд аялал жуулчлалын үзэсгэлэн, сургалтын зорилгоор 1 чихмэлийг Япон руу, 2004 онд агнуурын зорилгоор 1 бодгаль, 2016 онд хувийн зорилгоор 3 өдийг АНУ руу гаргав.

Экологи, эдийн засгийн үнэлгээ: Монгол улсын ЗГ-ын 23-р тогтоолоор баталсан “Ан амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ”-гээр нэг нь 454,000 төгрөг болно. Дээрх тогтоолоор баталсан “Ан амьтны нөөц ашигласны төлбөр, ан амьтан агнах, барих зөвшөөрлийн хураамжийн хэмжээ”-г нэг шувууны хувьд соёл шинжлэх ухаан, эмчилгээний зориулалтаар агнах, барихад 90,800 төгрөг байхаар тогтоожээ.

Хууль эрх зүйн орчин: Амьтны аймагт учирсан хохирлын нөхөн төлбөр: Эко-э.з. үнэлгээг 2 дахин өсгөж төлөх тухай АТХ-ийн 37-р зүйл; Гадаадад гаргах, худалдах зөвшөөрөл, гэрчилгээ: ХАУТГЭЗГХЗТХ-ийн 8-р зүйл; Хуулийн хариуцлага: ЗТХ-ийн 7.3.1., 7.6.1.-7.6.5., 11.22.3., 11.22.4. болон УТХГН-т агнасан барьсан тохиолдолд ЭХ-ийн 24.5.1.-р зүйлд заасан хариуцлага хүлээнэ. **ШҮ, сургалт ба бусад зорилгоор гадаадад гаргасан байдал:** Монгол орноос худалдсан тухай баримт байхгүй. Амьдаар болон биеийн тодорхой хэсэг өд, савар, мах зэрэг нь дотоодын зах зээлд ихээр борлуулагддаг.

Эд, эрхтэн, бүтээгдэхүүн, тэдгээрийн хэрэглээ, таних онцлог: Өдийг нь шашны үйлд хэрэглэх ба бор шаргал нарийн бор хүрэн судалтай мөн зөөлөн байдгаараа ялгарна. Чихмэл хийж зарах ба биеэр том төдийгүй чих мэт урт өд толгойн хажууд тод харагдана. Хумс бүхий савар нь өдөөр хучигдсан хүчирхэг, урт махир хумстай зэргийг харгалзан хялбар таньж болно.



СООТОН ГҮЙВАНГА

Багийн нэр: STRIGIFORMES

Латин нэр: *Asio otus*

Түгээмэл буюу англи нэр: Long-eared owl

Адилцах нэр: -

Конвенцийн хавсралт: II

Олон улсын ховордлын статус: Анхааралд өртөхөөргүй

Бүс нутгийн ховордлын статус: Анхааралд өртөхөөргүй

Статус: Нүүдлийн өндөглөдөг зүйл.

Амьдрах орчин: Ой, ойт хээр, нуур, голын хөндийн төгөл, бургасан шугуй, нүүдлийн үедээ говь цөлд тохиолдоно. Хотон, Хоргон, Ачит нуур, Ховд, Булган голын хөндий (Монгол-Алтай), Увс нуурын баруун хойд хэсэг, Тэс гол (Их Нууруудын хотгор), Тамир, Хануй, Орхон голын эх, Тарвагатай-Булнайн нуруу (Хангай), Хөвсгөл нуур, Эг гол (Хөвсгөл), Шишгид гол, Доод нуурын ус намгархаг газар (Дархадын хотгор), Орхон, Сэлэнгэ, Эг, Хараа гол (Орхон-Сэлэнгэ голын сав), Туул, Тэрэлж, Онон, Балж, Хүдэр, Булнай голын эх, Хэрлэн Баян Улаан, Богдхаан уул (Хэнтий), Улз, Хэрлэн гол, Монгол Дагуурын хээр, Дундад Халхын хээр, Буйр Нуур-Халх Гол-Хянган, Булган гол (Зүүнгарын говь)-д үржинэ.

Тоо толгой: Дэлхийн популяци 2,000,000-5,500,000 бие гүйцсэн бодгалиас тогтох ба тоо нь буурч буй (Birdlife International, 2017).

Тоо толгойн чиг хандлага, нөлөөлж байгаа

хүчин зүйлс: Тоо толгой буурах гол шалтгаан нь тархац нутгийн хүрээнд ой, бэлчээрийг хэт ашиглах, уул уурхай, жуулчны бааз байгуулах, ой, хээрийн түймэр, машин техникээр их холхих, орчны бохирдол зэргээс шалтгаалсан амьдрах орчны доройтол, өндөр хүчдэлийн шугамын утас мөргөх эндэх, бөөгийн шашны зан үйлд өд, сарвууг ашиглах болон гоёл чимэглэлийн зорилгоор хулгайгаар агнах, худалдах зэрэг болно (Gombobaatar et al., 2011, 2017).


Худалдаа: 2002 онд агнуурын зорилгоор 1 бодгалийг АНУ руу гаргасан.

Экологи, эдийн засгийн үнэлгээ: Монгол улсын ЗГ-ын 23-р тогтоолоор баталсан “Ан амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ”-гээр нэг бодгалийн үнэлгээ нь 50,000 төгрөг болно.

Хууль эрх зүйн орчин: Амьтны аймагт учирсан хохирлын нөхөн төлбөр: Эко-э.з. үнэлгээг 2 дахин өсгөж төлөх тухай АТХ-ийн 37-р зүйл; Гадаадад гаргах, худалдах зөвшөөрөл, гэрчилгээ: ХАУТГЭЗГХЗТХ-ийн 8-р зүйл; Хуулийн хариуцлага: ЗТХ-ийн 7.3.1., 7.6.1.-7.6.5., 11.22.3., 11.22.4. болон УТХГН-т агнасан барьсан тохиолдолд ЭХ-ийн 24.5.1.-р зүйлд заасан хариуцлага хүлээнэ.

ШҮ, сургалт ба бусад зорилгоор гадаадад гаргасан байдал: 2002 онд шинжлэх ухааны зорилгоор 1 дээжийг АНУ руу гаргажээ.

Эд, эрхтэн, бүтээгдэхүүн, тэдгээрийн хэрэглээ, таних онцлог: Өдийг нь шашны үйлд хэрэглэх ба бор шаргал нарийн бор хүрэн судалтай, зөөлөн зэргээрээ шар шувууныхтай төсөөтэй ч богино, жижиг байдгаараа ялгаатай. Шар шувуутай андууран түүний өд, хуруу, хумс, толгойг бөөгийн зан үйлд ашигладаг. Магадгүй шар шувууны махтай андууран махыг эмчилгээний зорилгоор худалдаж байх боломжтой. Махыг нь бусад шувууныхаас ялгах бараг боломжгүй.



ХӨХТӨН

Монгол улсаас энэхүү Конвенцийн I, II хавсралтад нийт 14 зүйл хөхтөн бүртгэгджээ.

ИРВЭС

Багийн нэр: CARNIVORA

Латин нэр: *Uncia uncia*

Түгээмэл буюу англи нэр: Snow leopard

Конвенцийн хавсралт: I

Олон улсын ховордлын статус: Устаж болзошгүй

Бүс нутгийн ховордлын статус: Устаж болзошгүй

Таних шинж: Монголын мийн овгийн амьтдын дотроос хамгийн том биетэй. Зүс боровтор эсвэл шаравтар туяатай саарал, бие бүхэлдээ гархи хэлбэртэй бараан толботой. Сүүлний урт бараг биеийн уртад хүрнэ. Сүүл урт, өтгөн үстэй. Тавхай хүчирхэг, том.

Амьдрах орчин: Монгол Алтай ба Говийн Алтай, Алтайн өвөр говь, Хангай, Хөвсгөлийн уулсаар тархсан. Жинхэнэ өндөр уулын амьтан. Ирвэс 2,500- 3,500 м өндөр уулсын гүн хавцал жалга, хад цохиот эгц хажуу зэрэг гөрөөл амьтан отох, гэтэж ойртох, довтлох боломжтой бартаат газарт байршина. Мөн говь, цөлийн хад чулуут уулс, баянбүрд шүтэж амьдарна (Batsaikhan et al., 2014).

Тоо толгой: Монгол оронд 1970-аад оны дундуур 700 бодгаль, 2000 онд 800-1,500 бодгаль байна гэж үзжээ (McCarthy, 2000).

Тоо толгойн чиг хандлага, нөлөөлж байгаа

хүчин зүйлс: Арьс болон ясыг нь Хятадын ардын эмнэлэгт ашиглах зорилгоор хууль бусаар агнадаг. Махыг нь эмийн түүхийн эд болгодог. Идэш бөлөгч туруутан амьтны тоо толгой эрс ховордож байгаа нь ховордлын шалтгаан болж байна. Зарим газар гэрийн мал руу дайрах тохиолдолд агнах явдал бий.

Экологи, эдийн засгийн үнэлгээ: 2011 оны 23-р тогтоолоор баталсан “Ан амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ”-гээр эр нь 11,200,000 төгрөг, эм нь 13,000,000 төгрөг болно.

Хууль эрх зүйн орчин: АТХ-ийн 7.2-ийн агнах барих зөвшөөрөл: Судалгаа, шинжилгээнээс бусад зориулалтаар барихыг хориглоно. Амьтны аймагт учирсан хохирлын нөхөн төлбөр: Эко-э.з. үнэлгээг 2 дахин өсгөж төлөх тухай АТХ-ийн 37-р зүйл; Гадаадад гаргах, худалдах зөвшөөрөл, гэрчилгээ: ХАУТГЭЗГХЗТХ-ийн 8-р зүйл; Хуулийн хариуцлага: ЗТХ-ийн 7.3.1., 7.6.1.-7.6.5., 11.22.3., 11.22.4.; ЭХ-ийн 24.5.2.-р зүйлд заасан хариуцлага хүлээнэ.

ШУ, сургалт ба бусад зорилгоор гадаадад гаргасан байдал: Шинжлэх ухаан, судалгааны зорилгоор 2011-2014 онд 560 ширхэг сорьц дээжийг АНУ, Япон улс руу гаргажээ.

Эд, эрхтэн, бүтээгдэхүүн, тэдгээрийн хэрэглээ, таних онцлог: Хууль бусаар агнасан ирвэсний арьс, ясыг гоёл чимэглэл, уламжлалт эмд ашиглана. Арьсыг нь толботой цоохор зүсээр танина.



ХҮРЭН БААВГАЙ

Багийн нэр: CARNIVORA

Латин нэр: *Ursus arctos*

Түгээмэл буюу англи нэр: Brown bear

Адилцах нэр: -

Конвенцийн хавсралт: I

Олон улсын ховордлын статус: Анхааралд өртөхөөргүй

Бүс нутгийн ховордлын статус: Мэдээлэл дутмаг

Таних шинж: Биеэр том, лагс. Мөч бахим, тавхай үстэй, таван хуруу нь хүчирхэг бор хумстай. Толгой данхар, хоншоор богино. Хүзүү богино, бүдүүн. Чих намхан, дугариг. Сүүл ахар, үснээс цухуйх төдий. Зүс бараан хүрэн, цайвар хүрэн, хар хүрэн, бор хул ч тохиолдоно. Зарим баавгай цагаан цээжтэй байх нь бий.

Амьдрах орчин: Хэнтий, Хөвсгөл, Монгол Алтайн нурууны баруун хойд хэсэг, Умарт Хангай, Их хянганы салбар уулсын ойт нутгаар тархсан (Дуламцэрэн, 1970). Хөвч тайга, хуш-шинэсэн ой, холимог ойд идээшин амьдарна (Batsaikhan et al., 2014).
Тоо толгой: Монгол орны баавгайн тоо толгойн талаарх сүүлийн үед гаргасан мэдээ, баримт хомс.

Тоо толгойн чиг хандлага, нөлөөлж байгаа


хүчин зүйлс: Олон улсын хэмжээгээр уламжлалт анагаах ухаанд бүх эрхтнийг хэрэглэдэг учраас хараа хяналтгүй ба хууль бусаар агнадаг. Монгол орны хүрэн баавгайн арьс, мах, савар, доньд (цөс)-ийг хууль бусаар худалдаалж байна (Wingard & Zahler, 2006).

Худалдаа: Арьс, мах, савар, доньдыг ихээр ашиглаж байна.

Экологи, эдийн засгийн үнэлгээ: Монгол улсын ЗГ-ын 2011 оны 23-р тогтоолоор баталсан “Ан амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ”-гээр эр нь 6,500,000 төгрөг, эм нь 7,500,000 төгрөг болно.

Хууль эрх зүйн орчин: Агнах, барих тусгай зөвшөөрөл: ЗГ-ын 2013 оны 93-р тогтоол; Амьтны аймагт учирсан хохирлын нөхөн төлбөр: Эко-э.з. үнэлгээг 2 дахин өсгөж төлөх тухай АТХ-ийн 37-р зүйл; Гадаадад гаргах, худалдах зөвшөөрөл, гэрчилгээ: ХАУТГЭЗГХЗТХ-ийн 8-р зүйл; Хуулийн хариуцлага: ЗТХ-ийн 7.3.1., 7.6.1.-7.6.5., 11.22.3., 11.22.4.; ЭХ-ийн 24.5.1.-р зүйлд заасан хариуцлага хүлээнэ.

-60-



ТАХЬ

Багийн нэр: PERISSODACTYLA

Латин нэр: *Equus przewalskii*

Түгээмэл буюу англи нэр: Przewalski's wild horse

Адилцах нэр: Takhi, *E. caballus przewalskii*

Конвенцийн хавсралт: I

Олон улсын ховордлын статус: Устаж болзошгүй

Бүс нутгийн ховордлын статус: Устаж байгаа

Амьдрах орчин: Тахийн уугуул нутаг нь Зүүнгарын говь, цөлөрхөг хээрийн бэсрэг уулсын бэл, хөндий, нам аараг толгод, уудам хотос хоолой, сайр садарга бөгөөд Хустайн нуруунд нутагшуулж байгаа тахийн сүрэг нь уулын хээр ба ойт хээрт тохиолдоно (Батсайхан нар, 2010).

Тоо толгой: Энэ зүйл амьтан нь байгаль дээр устсан учраас 1992 оноос эхлэн Монгол оронд сэргээн нутагшуулах ажил эхэлсэн. Одоогоор Хустайн нуруунд 314 бодгаль (Өсөхжаргал, 2014), Зүүнгарын говьд 113 бодгаль (Ганбаатар, аман мэдээ), Хомын талд 45 бодгаль (Feh, 2014) амьдарч байгаа.

Тоо толгойн чиг хандлага, нөлөөлж байгаа хүчин зүйлс: Махчин амьтны нөлөө, халдварт өвчин, ган, зуд зэрэг хүчин зүйлс тоо толгойд сөргөөр нөлөөлж байна.


Худалдаа: Энэ зүйл амьтан ба түүний эд, эрхтний худалдаа одоогоор бүртгэгдээгүй.

Экологи, эдийн засгийн үнэлгээ: Монгол улсын ЗГ-ын 2011 оны 23-р тогтоолоор баталсан "Ан амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ"-гээр нэг эр тахь 11,000,000 төгрөг, эм тахь 13,000,000 төгрөг болно.

Засгийн Газрын 2010 оны 23 дугаар тогтоолын II хавсралтаар баталсан "Ан амьтны нөөц ашигласны төлбөр, ан амьтан агнах, барих зөвшөөрлийн хураамжийн хэмжээ"-г соёл шинжлэх ухаан, эмчилгээний зориулалтаар агнах, барихад нэг эр тахийн хувьд 2,200,000 төгрөг, эм тахь 2,600,000 төгрөг байхаар тогтоожээ.

Хууль эрх зүйн орчин: АТХ-ийн 7.2.-ийн агнах барих зөвшөөрөл: Судалгаа, шинжилгээнээс бусад зориулалтаар барихыг хориглоно. Амьтны аймагт учирсан хохирлын нөхөн төлбөр: Эко-э.з. үнэлгээг 2 дахин өсгөж төлөх тухай АТХ-ийн 37-р зүйл; Гадаадад гаргах, худалдах зөвшөөрөл, гэрчилгээ: ХАУТГЭЗГХЗТХ-ийн 8-р зүйл; Хуулийн хариуцлага: ЗТХ-ийн 7.3.1., 7.6.1.-7.6.5., 11.22.3., 11.22.4.; ЭХ-ийн 24.5.2.-р зүйлд заасан хариуцлага хүлээнэ.

ШҮ, сургалт ба бусад зорилгоор гадаадад гаргасан байдал: Шинжлэх ухаан, судалгааны зорилгоор 1996 оноос хойш хугацаанд тахийн 65 ширхэг толгойн яс, 35 ширхэг тахийн эд эрхтэн экспортолсон нь тэмдэглэгдсэн байна.



ХУЛАН

Багийн нэр: ARTIODACTYLA

Латин нэр: *Equus hemionus*

Түгээмэл буюу англи нэр: Asiatic wild ass or Khulan
Конвенцийн хавсралт: I

Олон улсын ховордлын статус: Ховордож болзошгүй

Бүс нутгийн ховордлын статус: Устаж болзошгүй

Таних шинж: Монгол хулан хул хонгор зүстэй, улирал болон бодгалиас хамаарч ухаа хонгор, цайвар хул, бор хул зүстэй ч тохиолдоно. Хэвлий, цавь, суга, гуяны зураа орчим цайвар зүстэй. Мундаанаас зоо нуруу дагуу сүүлний цацаг хялгас хүртэл бор тууш хүрэн судалтай. Дэл босоо, ахар, хар өнгөтэй, сүүлний годонгийн төгсгөл хар бараан цацаг хялгастай. Толгой данхар, чих урт. Толгойн ясаар нь тахь, адуунаас хялбар ялгах гол шинж түүний дээд эрүү завсрын ясны нийлэх хэсэгт байрлах товгор юм.

Амьдрах орчин: Монгол орны Зүүнгарын говь, Алтайн өвөр говь, Умард говь, Алашань говь, Дорнод говийн Их нартын чулууны БНГ-ын хойд хэсэг ба тархалтын зүүн хязгаар нь Улаанбаатар-Бээжингийн чиглэлийн төмөр замаар хязгаарлагдана.

Цөл, цөлөрхөг хээрийн өдлөг хялгана-хөмүүл, баглуур-бударганат бэсрэг уулсын бэл, хөндий, нам аараг, толгод, уудам хотос, хоолой, сайр, садарга, дэнжээр бэлчээрлэнэ. Задгай булаг, шанд, тойром шүтэх авч, сайранд татаал гаргаж ундаална (Batsaikhan et al., 2014).


Тоо толгой: ШУА-ийн судалгаагаар Монгол оронд 2000 оны байдлаар нийт 19,000 толгой хулан байна. Хулангийн тоо 2003 оны байдлаар 1997 оныхоос 60% буурсан.

Тоо толгойн чиг хандлага, нөлөөлж байгаа хүчин зүйлс: Арьс, махыг нь ашиглах зорилгоор хууль бусаар их хэмжээгээр агнаж байгаа нь ховордлын гол шалтгаан болж байна (Stubble et al., 2005). Мөн сүүлийн жилүүдэд малтай бэлчээр нутаг ба үст цэгийн төлөөх өрсөлдөөнд орох, уул уурхайн сөрөг нөлөө, Улаанбаатар-Бээжингийн чиглэлийн төмөр зам нь шилжилт хөдөлгөөнд саад болох зэрэг шалтгаануудаас болж цөөрч байгаа.

Эд, эрхтэн, бүтээгдэхүүн, тэдгээрийн хэрэглээ, таних онцлог: Арьс, махыг нь ашиглахаас гадна уяачид туурайг нь мөнгөөр бүрж бэлэг, дурсгалд хэрэглэнэ.

Экологи, эдийн засгийн үнэлгээ: Монгол улсын ЗГ-ын 2011 оны 23-р тогтоолоор баталсан “Ан амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ”-гээр эр хулан 9,700,000 төгрөг, эм нь 11,000,000 төгрөг болно.

Хууль эрх зүйн орчин: Агнах, барих тусгай зөвшөөрөл, нөхөн төлбөрт Эко-э.з. үнэлгээг 2 дахин өсгөж төлөх, АТХ-ийн 37-р зүйл; Гадаадад худалдах: ХАУТГЭЗГХЗТХ-ийн 8-р зүйл; Хуулийн хариуцлага: ЗТХ-ийн 7.3.1., 7.6.1.-7.6.5., 11.22.3., 11.22.4.; ЭХ-ийн 24.5.1.



СААРАЛ ЧОНО

Багийн нэр: CARNIVORA

Латин нэр: *Canis lupus*

Түгээмэл буюу англи нэр: Gray wolf

Адилцах нэр: Grey wolf

Конвенцийн хавсралт: II

Олон улсын ховордлын статус: Анхааралд өртөхөөргүй

Бүс нутгийн ховордлын статус: Ховордож болзошгүй

Амьдрах орчин: Монгол орны бүх амьдрах орчинд түгээмэл тархалттай махчин амьтан.

Тоо толгой: Монгол орны чонын популяцийн тооны талаарх сүүлийн үеийн судалгааны мэдээ байхгүй. ШУА-ийн судалгаагаар 1980 оны үед 30,000 бодгаль байсан.

Тоо толгойн чиг хандлага, нөлөөлж байгаа хүчин зүйлс: Тоо толгой нь хууль бус болон спорт агнуураас болж буурч байгаа учраас зарим бүс нутагт агнахыг хориглосон.

Худалдаа: Чонын арьс ба эд эрхтний хууль бус худалдаа сүүлийн үед ихэсч байна. Хамгийн ихээр 1933 онд 18,000 бодгаль (Scharf et al., 2003), 1942-оос 1960 онд жилд дунджаар 5,827 ширхэг арьс бэлдэж байсан (Stubbe, 1965).

Экологи, эдийн засгийн үнэлгээ: Монгол улсын ЗГ-ын 2011 оны 23-р тогтоолоор баталсан “Ан амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ”-гээр нэг эр чоно 510,000

төгрөг, эм чоно 600,000 төгрөг болно. “Ан амьтны нөөц ашигласны төлбөр, ан амьтан агнах, барих зөвшөөрлийн хураамжийн хэмжээ”-г соёл шинжлэх ухаан, эмчилгээ ба ахуйн зориулалтаар агнах, барих зөвшөөрлийн хураамжийн хэмжээг 102,000 төгрөг байхаар тогтоожээ.

Хууль эрх зүйн орчин: Амьтны аймагт учирсан хохирлын нөхөн төлбөр: Эко-э.з. үнэлгээг 2 дахин өсгөж төлөх тухай АТХ-ийн 37-р зүйл; Гадаадад гаргах, худалдах зөвшөөрөл, гэрчилгээ: ХАУТГЭЗГХЗТХ-ийн 8-р зүйл; Хуулийн хариуцлага: ЗТХ-ийн 7.3.1., 7.6.1.-7.6.5., 11.22.3., 11.22.4. болон УТХГН-т агнасан барьсан тохиолдолд ЭХ-ийн 24.5.1.-р зүйлд заасан хариуцлага хүлээнэ.

ШУ, сургалт ба бусад зорилгоор гадаадад гаргасан байдал: Саарал чонын хамгийн олон бодгалийг 1996, 2005 онд гадаадад гаргажээ. Саарал чонын 1996-2012 онд гадаадад гаргасан эд, эрхтний дотор арьс 675, чихмэл 315, бусад дагавар эд, эрхтэн 291, толгойн яс 81, хэлхээ яс 27, шүд 24, амьдаар 22, бусад эрхтэн, эд 9 ширхэг эзэлж байна.



МАНУУЛ

Багийн нэр: CARNIVORE

Латин нэр: *Otocolobus manul*

Түгээмэл буюу англи нэр: Pallas's cat or Manul

Адилцах нэр: *Felis manul*

Конвенцийн хавсралт: II

Олон улсын ховордлын статус: Ховордож болзошгүй

Бүс нутгийн ховордлын статус: Ховордож болзошгүй

Амьдрах орчин: Ойт хээр, бүх хэв шинжийн хээр, хад чулуут бэсрэг уулс, өндөр уулархаг нутаг, говь цөлийн хадат уулсаар тохиолдоно. Хуурай ба гандуу орчинд илүү түгээмэл.

Тоо толгой: Тоо толгойн талаарх мэдээ байхгүй.

Тоо толгойн чиг хандлага, нөлөөлж байгаа хүчин зүйлс: Хууль бус агнуур ба идэш тэжээл бологч амьтад химийн хорт бодист өртөснөөс шалтгаалан цөөрснөөс идэшгүйтэж тоо толгой нь буурч байна.

Худалдаа: Манай улс 1958-1960 онд жилд 5,500 мануулын арьс бэлтгэж байсан (Stubbe, 1965). 2005 онд 6 бодгалийг экспортолсон (UNEP-WCMC, 2006).

Экологи, эдийн засгийн үнэлгээ: Монгол улсын ЗГ-ын 2011 оны 23-р тогтоолоор баталсан “Ан амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ”-гээр нэг эр мануул

440,000 төгрөг, эм мануул 500,000 төгрөг болно. Мөн ЗГ-ын 2010 оны 23 дугаар тогтоолын II хавсралтаар баталсан “Ан амьтны нөөц ашигласны төлбөр, ан амьтан агнах, барих зөвшөөрлийн хураамжийн хэмжээ”-г соёл шинжлэх ухаан, эмчилгээ ба ахуйн зориулалтаар агнах, барих зөвшөөрлийн хураамжийн хэмжээг 88,000 төгрөг байхаар тогтоожээ.

Хууль эрх зүйн орчин: Амьтны аймагт учирсан хохирлын нөхөн төлбөр: Эко-э.з. үнэлгээг 2 дахин өсгөж төлөх тухай АТХ-ийн 37-р зүйл; Гадаадад гаргах, худалдах зөвшөөрөл, гэрчилгээ: ХАВТГЭЗГХЗТХ-ийн 8-р зүйл; Хуулийн хариуцлага: ЗТХ-ийн 7.3.1., 7.6.1.-7.6.5., 11.22.3., 11.22.4. болон УТХГН-т агнасан барьсан тохиолдолд ЭХ-ийн 24.5.1.-р зүйлд заасан хариуцлага хүлээнэ.

ШҮ, сургалт ба бусад зорилгоор экспортлогдсон байдал: Ан агнуур, судалгаа шинжилгээ, худалдаа гэх мэт зорилгоор мануулыг амьдаар болон арьс, өөр бусад бүтээгдэхүүнийг экспортодлог.



ХҮДЭР

Багийн нэр: ARTIODACTYLA

Латин нэр: *Moschus moschiferus*

Түгээмэл буюу англи нэр: Siberian musk deer

Адилцах нэр: Баданга хүдэр

Конвенцийн хавсралт: II

Олон улсын ховордлын статус: Эмзэг

Бүс нутгийн ховордлын статус: Устаж болзошгүй

Амьдрах орчин: Жинхэнэ уулын тайгын амьтан. Шигүү навчит болон шилмүүст ой ба уулын арын бутлаг ургамалтай энгэрт илүү байршина (Dulamtseren, 1977; Dulamtseren et al., 1989; Цэнджав, 2002).

Тоо толгой: Монгол орны популяцийн хэмжээ 1970-аад онд 60,000-80,000 бодгальд хүрсэн (Dulamtseren, 1977). ШУА-ийн Биологийн хүрээлэнгийн 1986 оны судалгаагаар нийтдээ 6 аймгийн 63 суманд 43,000 бодгаль байжээ (Dulamtseren, 1989). Түүнээс хойш нягтшил нь буурсаар 1990-ээс 2000 оны байдлаар 1 км² талбайд 1.2-оос 0.2 хүрч буурч байв (Цэнджав, Бүжинханд, 2000; Цэнджав, 2002).

Тоо толгойн чиг хандлага, нөлөөлж байгаа хүчин зүйлс: Хууль бус агнуур ба амьдрах орчны хуваагдлаас болж тоо толгой тогтмол буурч байна.

Худалдаа: Тодорхой мэдээлэл байхгүй.

Экологи, эдийн засгийн үнэлгээ: Монгол улсын ЗГ-ын 2011 оны 23-р тогтоолоор баталсан “Ан амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ”-гээр нэг эр хүдэр 3,000,000 төгрөг, эм хүдэр 3,500,000 төгрөг болно. Мөн ЗГ-ын 2010 оны 23 дугаар тогтоолын II хавсралтаар баталсан “Ан амьтны нөөц ашигласны төлбөр, ан амьтан агнах, барих зөвшөөрлийн хураамжийн хэмжээ”-г соёл шинжлэх ухаан, эмчилгээний зориулалтаар агнах, барих зөвшөөрлийн хураамжийн хэмжээг эр хүдэрт 600,000 төгрөг, эм хүдэр 700,000 төгрөг төлөхөөр тогтоожээ.

Хууль эрх зүйн орчин: АТХ-ийн 7.2.-ийн агнах барих зөвшөөрөл: Судалгаа, шинжилгээнээс бусад зориулалтаар барихыг хориглоно. Амьтны аймагт учирсан хохирлын нөхөн төлбөр: Эко-э.з. үнэлгээг 2 дахин өсгөж төлөх тухай АТХ-ийн 37-р зүйл; Гадаадад гаргах, худалдах зөвшөөрөл, гэрчилгээ: ХАУТГЭЗГХЗТХ-ийн 8-р зүйл; Хуулийн хариуцлага: ЗТХ-ийн 7.3.1., 7.6.1.-7.6.5., 11.22.3., 11.22.4.; ЭХ-ийн 24.5.2.-р зүйлд заасан хариуцлага хүлээнэ.

ШҮ, сургалт ба бусад зорилгоор гадаадад гаргасан байдал: Баданга хүдрийн заар болон зарим эд зүйл экспортолсон цөөн тохиолдол байдаг.



БӨХӨН

Багийн нэр: ARTIODACTYLA

Латин нэр: *Saiga tatarica mongolica*

Түгээмэл буюу англи нэр: Saiga antelope

Адилцах нэр: Saiga antelope, Mongolian saiga

Конвенцийн хавсралт: II

Олон улсын ховордлын статус: Устаж байгаа

Бүс нутгийн ховордлын статус: Устаж болзошгүй

Амьдрах орчин: Монгол орны цөлөрхөг хээрийн бүсийн уулсын шил, хоолойн тачир сийрэг ургамалтай задгай тал газарт амьдарна.

Тоо толгой: Тоо толгой нь 1998 онд 2,950, 2000 онд 5,250 бодгальд хүрсэн (Дуламцэрэн, Амгалан, 2003) бөгөөд дараалсан ган ба зуднаас шалтгаалж 2002 онд ойролцоогоор 1,020 бодгаль, 2003 онд 750 бодгаль болж цөөрчээ. 2004 оны байдлаар 800 бодгаль байна (WWF, 2004; Zahler et al., 2004). ДБХС-ийн хэрэгжүүлж буй “Баруун Монголын Их нууруудын хотгорын бөхөнгийн хамгаалал” төслийн үр дүнд 2007 онд 2,860 толгой байсан бөхөнгийн тоо 2013 оны тооллогоор 14,600 бодгаль өсөв.


Тоо толгойн чиг хандлага, нөлөөлж байгаа хүчин зүйлс: Популяцийн хэмжээ нь хууль бус агнуур, бэлчээрийн доройтол, ган, зуднаас болж буурч байна (Lkhagvasuren et al., 2001).

Худалдаа: Тоо толгойн бууралтанд хууль бусаар гадаад худалдаа тодорхой хэмжээгээр нөлөөлсөн.

Экологи, эдийн засгийн үнэлгээ: Монгол улсын ЗГ-ын 2011 оны 23-р тогтоолоор баталсан “Ан амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ”-гээр нэг эр бөхөн 2,000,000 төгрөг, эм бөхөн 2,200,000 төгрөг болно. Мөн Засгийн Газрын 2010 оны 23 дугаар тогтоолын II хавсралтаар баталсан “Ан амьтны нөөц ашигласны төлбөр, ан амьтан агнах, барих зөвшөөрлийн хураамжийн хэмжээ”-г соёлшинжлэх ухаан, эмчилгээний зориулалтаар агнах, барих зөвшөөрлийн хураамжийн хэмжээг эр бөхөнд 400,000 төгрөг, эм бөхөнд 440,000 төгрөг байхаар тогтоожээ.

Хууль эрх зүйн орчин: АТХ-ийн 7.2.-ийн агнах барих зөвшөөрөл: Судалгаа, шинжилгээнээс бусад зориулалтаар барихыг хориглоно. Амьтны аймагт учирсан хохирлын нөхөн төлбөр: Эко-э.з. үнэлгээг 2 дахин өсгөж төлөх тухай АТХ-ийн 37-р зүйл; Гадаадад гаргах, худалдах зөвшөөрөл, гэрчилгээ: ХАУТГЭЗГХЗТХ-ийн 8-р зүйл; Хуулийн хариуцлага: ЗТХ-ийн 7.3.1., 7.6.1.-7.6.5., 11.22.3., 11.22.4.; ЭХ-ийн 24.5.2.-р зүйлд заасан хариуцлага хүлээнэ.

ШҮ, сургалт ба бусад зорилгоор гадаадад гаргасан байдал: Бөхөнгийн эд эрхтэнийг 1999, 2009 онд хилээр гаргасан байна.



АРГАЛЬ

Багийн нэр: ARTIODACTYLA

Латин нэр: *Ovis ammon*

Түгээмэл буюу англи нэр: Argali sheep

Адилцах нэр: Argali

Конвенцийн хавсралт: II

Олон улсын ховордлын статус: Ховордож болзошгүй

Бүс нутгийн ховордлын статус: Устаж болзошгүй

Амьдрах орчин: Монгол орны уулархаг нутгийн хад асгат налуу, бэсрэг уулс, говь цөлийн бүсийн зарим нам уулс ба тагийн бүсийн дэвсгэг, ойгүй нутгаар түгээмэл амьдарна.

Тоо толгой: Монгол орны хэмжээнд энэ зүйл амьтны популяцийн үнэлгээг янз бүрийн цаг хугацаанд олон янзын аргаар хийсэн байна. Тухайлбал, популяцийн тоо толгойг 1970 онд 40,000 бодгаль, 1975 онд 50,000 бодгаль, 1985 онд 60,000 бодгаль, 2001 онд 13,000-15,000 бодгаль болж буурчээ (Dulamtsuren, 1970; Amgalanbaatar et al., 2002; Clark et al., 2006).

Тоо толгойн чиг хандлага, нөлөөлж байгаа хүчин зүйлс: Хууль бүс агнуур, спорт агнуур, ган, зуд, бэлчээрийн талхагдал ба уул уурхайн нөлөөнөөс амьдрах орчин алдагдаж байна.


Худалдаа: Монгол орноос жил бүр спорт агнуурын зориулалтаар агнах зөвшөөрлийг өгдөг. Конвенц батлагдсан 1973 оноос хойш манай орноос угалз олон тоогоор

гарч байсан ч Монгол улс Конвенцид нэгдээгүйтэй холбоотой баримт байхгүй.

Экологи, эдийн засгийн үнэлгээ: “Ан амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ”-гээр нэг угалз 11,000,000 төгрөг, хомь 13,200,000 төгрөг болно. Мөн ЗГ-ын 2010 оны 23 дугаар тогтоолын II хавсралтад баталсан “Ан амьтны нөөц ашигласны төлбөр, ан амьтан агнах, барих зөвшөөрлийн хураамжийн хэмжээ”-г соёл шинжлэх ухаан, эмчилгээний зориулалтаар агнах, барих зөвшөөрлийн хураамжийн хэмжээг угалзанд 2,200,000 төгрөг, хомьд 2,600,000 төгрөг байхаар тогтоожээ.

Хууль эрх зүйн орчин: Агнах, барих тусгай зөвшөөрөл: ЗГ-ын 2013 оны 93-р тогтоол; Амьтны аймагт учирсан хохирлын нөхөн төлбөр: Эко-э.з. үнэлгээг 2 дахин өсгөж төлөх тухай АТХ-ийн 37-р зүйл; Гадаадад гаргах, худалдах зөвшөөрөл, гэрчилгээ: ХАУТГЭЗГХЗТХ-ийн 8-р зүйл; Хуулийн хариуцлага: ЗТХ-ийн 7.3.1., 7.6.1.-7.6.5., 11.22.3., 11.22.4.; ЭХ-ийн 24.5.1.-р зүйлд заасан хариуцлага хүлээнэ.

ШУ, сургалт ба бусад зорилгоор гадаадад гаргасан байдал: Түүнийг 1999 болон 2002 онд хамгийн олон тоотойгоор гадаадад гаргажээ.



УРГАМАЛ

Конвенцийн хавсралтад бүртгэгдсэн нийт 8 зүйл ургамлын худалдааны талаарх мэдээ, баримт одоогоор хомс.

Судалгаа шинжилгээний зорилгоор бага хэмжээтэй гадаадад гарчээ.

ЦӨЛИЙН АРГАМЖИН ЦЭЦЭГ (ЦАГААН ГОЁО)

Багийн нэр: MAGNOLIOPHYTINA

Овгийн нэр: OROBANCHACEAE

Латин нэр: *Cistanche deserticola* Ma.

Түгээмэл буюу англи нэр: Desert cistanche

Олон улсын ховордлын зэрэглэл: Үнэлгээ хийгдээгүй.

Монгол улсын ховордлын зэрэглэл: Устаж болзошгүй (Nyambayar нар, 2012).

Таних шинж: Элсэн хөрсөнд ургадаг, 30-150 см өндөр, махлаг салаалдаггүй, баганархуу бөөрөнхий иштэй ургамал. Голч нь 5-15 см, шар өнгөтэй. Ишний гадаргууд 1.5 см урт, 4-8 мм өргөн олон хайрсан илтэстэй. Тэдгээр нь ишний суурьт бөөгнөрсөн, дээшлэхдээ сийрэг. Ишний үзүүрт хөрснөөс дээш цухуйсан махлаг бүдүүн голтой, түрүү баг цэцэгтэй. Цэцгийн дагавар навч 2.5-3.5 см урт. Цоморлиг хонхорхуу 11-15 мм урт, таван салбанлаг. Дэлбэ хоолойрхуу 30-45 мм урт, бага зэрэг бөхгөр, шаравтар, цайвар бор туяатай, хатахдаа улбар хүрэн болдог, салбангийн үзүүр мохоо дугариг. Дохиурын доод хэсэг, тоосовч нь буржгар урт зөөлөн үсэрхэг, тоосовчийн үзүүр хурц шовгор. Үр боловсрох орон зууван, угтаа шар балавчтай.

Дэлхийн тархац: БНХАУ-ын Гансу, Шанши, Чинхай, Шинжан, Ниншиа, Өвөр Монголын хойд, Монголын өмнөд бүс нутаг тархсан.

Монгол орон дахь тархац: Монгол Алтай, Их нууруудын хотгор, Нууруудын хөндий, Дорнод-говь, Алтайн цаад говьд тархдаг.

Ургах орчин: Говь цөлийн элсэнд заг модны үндэс дээр шимэгчлэн ургадаг.


Амьдралын онцог: Хуурай дулаан уур амьсгалд дасан зохицсон, олон наст, өвслөг, шимэгч (паразит) ургамал. Үндэслэг ишээр түгэн ургах ба үрээр үржих нь харьцангуй удаан.

Нөөц хомсдох шалтгаан: Байгаль дахь нөөц тун бага энэ ургамлыг худалдаа, эмчилгээний зориулалтаар хууль бусаар олборлох нь ховордлын нэг гол шалтгаан болно. Загийг түлшинд хэрэглэх, цөлжилт, амьдрах орчны доройтлын улмаас нөөц нь хомсдож байна.

Хамгаалсан байдал: Конвенцийн II хавсралтад бүртгэсэн. Байгалийн ургамлын тухай Монгол улсын хуулийн 3.3 дахь заалтаар нэн ховор ургамлын жагсаалтад бүртгэн ашиглалтыг хязгаарласан (1995). Монгол улсын Улаан ном (2013)-д орсон нэн ховор ургамал.

Худалдаа: БНХАУ-д хууль бусаар худалдаалдаг. Хил, гааль дээр их, бага хэмжээгээр хураагдсан мэдээ баримт бий.

Экологи, эдийн засгийн үнэлгээ: Үнэлгээ хийгдээгүй.



Д. Суран

ЦООХОР СААДГАН ЦЭЦЭГ (ТОЛБОТ СААДГАН ЦЭЦЭГ)

Багийн нэр: MAGNOLIOPHYTINA

Овгийн нэр: ORCHIDACEAE

Латин нэр: *Cypripedium guttatum* Sw.

Түгээмэл буюу англи нэр: Lady-slipper, Mocassin flower

Олон улсын ховордлын зэрэглэл: Үнэлгээ хийгдээгүй.

Монгол улсын ховордлын зэрэглэл: Үнэлгээ хийгдээгүй.

Таних шинж: Нарийхан үндэслэг, 15-25 см өндөр иштэй. Түүний доод хэсэгт 5-10 см урт, 3-4 см өргөн, бараг зэрэгцээ хоёр зууван навчтай. Навчис хатахдаа хар болдог. Цэцгийн доод навч уртавтар нарийн 1.5-2 см урт. Ишний үзүүрт ганц цэцэгтэй. Шадар эрхтний навчинцар 4, мохоо, 1.5-2 см урт, уруул нь уутархуу, 2 см урт, цагаан, юмуу шаравтар дэвсгэр дээр ягаан өнгийн толботой.

Дэлхийн тархац: Беларусь, ОХУ (Оросын Европ тивийн хэсэг, Сибирь болон Алс Дорнодын мужууд), БНХАУ (Хэбэй, Хэйлонгжан, Жилин, Лайонин, Өвөр Монгол, Ниншиа, Шаанши, Шандон, Шанси, Сичиуан, Төвд болон Юнан), Солонгос, Бутан, Аласк, Канадын хойд хэсэг (Юкон болон Баруун хойд мужууд)-т тархсан.

Монгол орон дахь тархац: Хөвсгөл, Хэнтий, Хангай, Монгол-Дагуур (баруун хойт), Хянган (Хан-Чандмань уул)-д тархсан.



Д. Суран

Ургах орчин: Шинэс, нарс-хус, хусан ой, ойн нугад ургадаг.


Амьдралын онцог: Ногоон навчтай, олон наст өвслөг ургамал.

Нөөц хомсдох шалтгаан: Амьдрах орчны доройтол, мод огтлол, эмийн болон гоёл чимэглэлийн зориулалтаар түүх, бүс нутгийн худалдаа, ойн түймэр, байгалийн ган гачиг, агаарын хэмийн өөрчлөлт, нөхөн төлжих чадвар муу, тархац нутгийн хязгаарлагдмал байдлаас болоод ховордож байна.

Хамгаалсан байдал: Конвенцийн II хавсралтад бүртгэсэн. Байгалийн ургамлын тухай Монгол улсын хуулийн 3.3 дахь заалтаар нэн ховор ургамлын жагсаалтад бүртгэн ашиглалтыг хязгаарласан (1995). Цоохор саадган цэцгийн үндсэн тархац нутгийг улсын тусгай хамгаалалттай газруудад хамруулсан.

Худалдаа: Мэдээ баримт хомс.

Экологи, эдийн засгийн үнэлгээ: Хийгдээгүй.



ТОМ ЦЭЦЭГТ СААДГАН ЦЭЦЭГ

Багийн нэр: MAGNOLIOPHYTINA

Овгийн нэр: ORCHIDACEAE

Латин нэр: *Cypripedium macranthum* Sw.

Түгээмэл буюу англи нэр: Grand lady's slipper

Олон улсын ховордлын зэрэглэл: Үнэлгээ

хийгдээгүй.

Монгол улсын ховордлын зэрэглэл: ДБХХ-ны Улаандансны шалгуураар бүс нутгийн хэмжээнд “Устаж байгаа” гэж үнэлэгдсэн (Nyambayar нар, 2012). Монгол улсын Улаан ном (2013)-д “Нэн ховор” ургамал статусаар бүртгэгдсэн.

Таних шинж: Бүдүүн үсэрхэг үндэслэг иштэй. Ишиндээ 3-5 энгийн зууван навчтай. 20-40 см өндөр. Навчис цуваа байрлалтай, ишээ тэвэрсэн, навчны илтэс 8-15 см урт, 5-8 см өргөн. Ишний суурьт хайрсан угларгатай. Ишний үзүүрт гол төлөв нэг, хаяа хоёр том ягаан цэцэгтэй. Уруул нь 4-4.5 см урт, цул улбар ягаан. Шадар эрхтний навчинцар мөн адил ягаан ба 4-5 см урт, нарийн шовх үзүүртэй.

Дэлхийн тархац: Беларусь, ОХУ (Оросын Европ тивийн хэсэг, Сибирь болон Алс Дорнодын мужууд), БНХАУ (Хэбэй, Хэйлонгжан, Жилин, Лайонин, Өвөр Монгол, Шандон, Тайван), Япон, Солонгос.

Монгол орон дахь тархац: Хөвсгөл (баруун тал), Хэнтий, Монгол-Дагуур (баруун тал)-т тархсан.

Ургах орчин: Сийрэг шинэс, шинэс-хус, улиангар-хус, нарс, хусан ой, ойн нуга, ойн захаар ургана.

Амьдралын онцог: Ногоон навчтай, олон наст өвслөг ургамал.

Нөөц хомсдох шалтгаан: Амьдрах орчны доройтол, мод огтлол, эмийн болон гоёл чимэглэлийн зориулалтаар түүх, бүс нутгийн худалдаа, ойн түймэр, ган гачиг, агаарын хэмийн өөрчлөлт, нөхөн төлжих чадвар муу, тархац нутгийн хязгаарлагдмал байдлаас шалтгаалан ховордож байна.


Хамгаалсан байдал: Конвенцийн II хавсралтад бүртгэсэн. Байгалийн ургамлын тухай Монгол улсын хуулийн 3.3 дахь заалтаар нэн ховор ургамлын жагсаалтад бүртгэн ашиглалтыг хязгаарласан (1995). Том цэцэгт саадган цэцгийн үндсэн тархац нутгийг улсын тусгай хамгаалалттай газруудад хамруулан хамгаалж байна.

Худалдаа: Мэдээлэл байхгүй.

Экологи, эдийн засгийн үнэлгээ: Үнэлгээ хийгдээгүй.



Д. Суран



ШАР СААДГАН ЦЭЦЭГ

Багийн нэр: MAGNOLIOPHYTINA

Овгийн нэр: ORCHIDACEAE

Латин нэр: *Cypripedium calceolus* L.

Түгээмэл буюу англи нэр: Yellow lady's slipper

Олон улсын ховордлын зэрэглэл: Үнэлгээ хийгдээгүй.

Монгол улсын ховордлын зэрэглэл: ДБХХ-ны Улаан дансны шалгуураар бүс нутгийн хэмжээнд “Эмзэг” зэрэглэлээр үнэлэгдсэн (Nyambayar нар, 2012). Монгол Улсын Улаан ном (2013) “Нэн ховор” ургамал статусаар бүртгэгдсэн.

Таних шинж: Үерхэг нугачаа, бүдүүн, хөндлөн хар үндэслэг иштэй. Ишэндээ (3) 4-5 навчтай. 20-40 см өндөр. Навч зууван бөгөөд 6-10 см урт, 2-4 см өргөн, шовх үзүүртэй. Ишний үзүүрт 2-3 (хааяа 1) цэцэгтэй. Цэцгийн уруул 2-3 см урт, шар өнгөтэй ба хүрэн ягаан торлог судалтай. Шадар эрхтний навчинцар улбар хүрэн ба 4-5 см урт, хажуугийнх нь бусдаасаа нарийхан, хурц үзүүртэй.

Дэлхийн тархац: Европ тивээс зүүн тийш Ази хүртэл өргөн тархсан: Испаниас зүүн тийш

Номхон далайн эрэг хүртэл; Европын бүх улсууд, ОХУ, БНХАУ-ын зүүн хойд хэсэг (Хэйлонгжианг, Жилин, Лайонинг, Өвөр Монгол), Монгол Солонгос, Японы Ребун арал хүрнэ.

Монгол орон дахь тархац: Хэнтий, Монгол-Дагуур (Ноён уул, Хараа гол).

Ургах орчин: Ойн бүсийн гол горхийн эрэг, хусан төгөл, ойн нуга, ойн хаяанд ургана.

Амьдралын онцог: Ногоон навчтай, олон наст өвслөг ургамал.

Нөөц хомсдох шалтгаан: Амьдрах орчны доройтол, мод огтлол, эмийн болон гоёл чимэглэлийн зориулалтаар түүх, бүс нутгийн худалдаа, ойн түймэр, ган гачиг, агаарын хэмийн өөрчлөлт, нөхөн төлжих чадвар муу, тархац нутгийн хязгаарлагдмал байдлаас хамааран тархац нутаг нь хумигдаж, тоо толгой нь цөөрч байна.


Хамгаалсан байдал: Конвенцийн II хавсралтад бүртгэсэн. Байгалийн ургамлын тухай Монгол улсын хуулийн 3.3 дахь заалтаар нэн ховор ургамлын жагсаалтад бүртгэн ашиглалтыг хязгаарласан (1995). Шар саадган цэцгийн үндсэн тархац нутгийг улсын тусгай хамгаалалттай газруудад хамруулан хамгаалж байна.

Худалдаа: Мэдээлэл байхгүй.

Экологи, эдийн засгийн үнэлгээ: Үнэлгээ хийгдээгүй.



Д. Суран



БУЛЦУУТ ТҮДЭН ХАВХ

Багийн нэр: MAGNOLIOPHYTINA

Овгийн нэр: ORCHIDACEAE

Латин нэр: *Calypso bulbosa* (L.) Reichb.

Түгээмэл буюу англи нэр: Calypso

Олон улсын ховордлын зэрэглэл: Үнэлгээ хийгдээгүй.

Монгол улсын ховордлын зэрэглэл: ДБХХ-ны Улаан дансны шалгуураар бүс нутгийн хэмжээнд “Устаж байгаа” гэж үнэлэгдсэн (Nyambaya нар, 2012). Монгол улсын Улаан ном (2013)-д “Нэн ховор” статусаар бүртгэгджээ.

Таних шинж: Өндгөрхүү бяцхан цагаан булцуунаас ургасан 8-20 см өндөр иштэй, түүний доод хэсэгт 2-3 хальслаг урт угларгатай. Булцууны доод хэсэг нарийхан үндэстэй. Булцуунаас шовх үзүүртэй өндгөрхүү, 2.5-4 см урт илтэстэй, 2-7 см урт бариултай ганц навч ургадаг. Ишний үзүүрт ганц том цэцэгтэй. Цэцгийн дагавар навч ланцуйрхуу.



Д. Суран

Шадар эрхтний навчинцар 1.5- 2 см урт. Уруул нь шаравтар, үзүүртээ ягаавар бөгөөд 2 см урт.

Дэлхийн тархац: Арктикийн бүс даган тархсан бөгөөд үүнд Калифорни, Роки уулсын систем, АНУ-ын хойд хэсгийн ихэнх мужууд, Канадын ихэнх хэсэг, Скандинавийн хойг, Европын ихэнх хэсэг, Оросын Азийн хэсэг, Хятад, Монгол, Солонгос болон Японд тархжээ.

Монгол орон дахь тархац: Монгол-Дагуурт тархсан.

Ургах орчин: Хөвдөрхөг сүүдэрсэг шилмүүст ойд ургадаг.

Амьдралын онцог: Ногоон навчтай, олон наст өвслөг ургамал.

Нөөц хомсдох шалтгаан: Амьдрах орчны доройтол, эмийн болон гоёл чимэглэлийн зориулалтаар ашиглах, ойн түймэр, ган, нөхөн төлжих чадвар муу зэргээс шалтгаалан тархац нутаг нь хумигдаж байна.

Хамгаалсан байдал: Конвенцийн II хавсралтад бүртгэсэн. Байгалийн ургамлын тухай Монгол улсын хуулийн 3.3 дахь заалтаар нэн ховор ургамлын жагсаалтад бүртгэн ашиглалтыг хязгаарласан (1995). Булцуут түдэн хавхын үндсэн тархац нутаг нь тусгай хамгаалалттай газарт багтдаг.

Худалдаа: Мэдээлэл байхгүй.

Экологи, эдийн засгийн үнэлгээ: Үнэлгээ хийгдээгүй.



ХӨХӨӨ ЦҮНХРЭГ

Багийн нэр: MAGNOLIOPHYTINA

Овгийн нэр: ORCHIDACEAE

Латин нэр: *Neottianthe cuculata* (L.) Schlechter.

Түгээмэл буюу англи нэр: Cucullated neottianthe

Олон улсын ховордлын зэрэглэл: Үнэлгээ хийгдээгүй.

Монгол улсын ховордлын зэрэглэл: ДБХХ-ны Улаан дансны шалгуураар бүс нутгийн хэмжээнд “Устаж байгаа” гэж үнэлэгдсэн (Nyambayar нар, 2012).

Таних шинж: Үндэс нь нэг бөөрөнхий, 10-12 мм бүдүүн булцуутай ба 10-20 см өндөр. Ишний суурь бараг эсрэг суусан 2-5 см урт, 1-3 см өргөн бөгөөд зөөлөн хос навчтай. Түүнээс дээш урт угларгатай 1-2 бяцхан навчтай. Ягаавар цацаг баг цэцэг нь 3-8 см урт ба 1 см голчтой., бөгөөд суумал. Уруул нь 10 мм урт, урагш илүү гарсан гурван гүн салбанлаг, дундах нь илүү урт, өргөн ягаан, дээд гадаргуудаа хөхлүүртэй. Түүний доор мөн урагш тахийсан, уруулаас хоёр дахин богино нарийн годойтой.



Д. Суран

Шадар эрхтний бусад навчинцар хумигдаж дээш шовойсон.

Дэлхийн тархац: Ази болон Зүүн Европын унаган ургамал. Япон болон Сахалинаас Польш хүртэл тархах ба үүнд Хятад, Сибирь, Украин, Гималайн нуруу багтана.

Монгол орон дахь тархац: Хэнтий, Хангай, Монгол-Дагуурт тархсан.

Ургах орчин: Шинэс-хусан ой, нарсан ойд ургадаг.


Амьдралын онцог: Ногоон навчтай, олон наст өвслөг ургамал.

Нөөц хомсдох шалтгаан: Амьдрах орчны доройтол, мод огтлол, эмийн болон гоёл чимэглэлийн зориулалтаар ашиглах, ойн түймэр, ган гачиг, агаарын хэмийн өөрчлөлт зэргээс шалтгаалан ховордож байна.

Хамгаалсан байдал: Конвенцийн II хавсралтад бүртгэсэн. Байгалийн ургамлын тухай Монгол улсын хуулийн 3.3 дахь заалтаар нэн ховор ургамлын жагсаалтад бүртгэн ашиглалтыг хязгаарласан (1995). Энэ зүйлийн тархац нутгийн зарим хэсэг тусгай хамгаалалттай газарт хамрагддаг.

Худалдаа: Мэдээлэл байхгүй.

Экологи, эдийн засгийн үнэлгээ: Үнэлгээ хийгдээгүй.



СЭРХЭН ХӨХӨӨ ЦЭЦЭГ

Багийн нэр: MAGNOLIOPHYTINA

Овгийн нэр: ORCHIDACEAE

Латин нэр: *Gymnadenia conopsea* (L.) R. Br.

Түгээмэл буюу англи нэр: Fragrant orchid

Олон улсын ховордлын зэрэглэл: Үнэлгээ хийгдээгүй.

Монгол улсын ховордлын зэрэглэл: Үнэлгээ хийгдээгүй.

Таних шинж: Үндсэндээ салаархаг хоёр булцуутай. 20-40 см өндөр иштэй. Ишиндээ 7-20 см урт, 2 см өргөн. 4-7 навчтай. Суумал цэцгүүд нь 5-15 см урт ба өтгөн цацаг баг цэцэг үүсгэнэ. Цэцгийн дагавар навч өвслөг ногоон. нарийхан шувтгар үзүүртэй, үрэвчээсээ урт. Цэцэг нь ягаан, эсвэл цайвар ягаан. Шадар эрхтний гадаад навчинцар өндгөрхүү мохоо 3-4 мм урт, дотоод нь 5 мм, нарийхан 1.5 см урт.

Дэлхийн тархац: Европ, Азийн хойд хэсэг болон Гималайн нурууны хойд хэсгээр тархсан.

Монгол орон дахь тархац: Хөвсгөл, Хангай, Хэнтий, Монгол-Дагуур, Хянганд таардаг.

Ургах орчин: Сийрэг шинэсэн ой, хусан ой, ойн цоорхой, ойн нуга, сөөгөн ширэнгэтэй орчинд ургадаг.

Амьдралын онцог: Ногоон навчтай олон наст өвслөг ургамал.

Нөөц хомсдох шалтгаан: Амьдрах орчны доройтол, мод оглол, түймэр, ган гачиг, агаарын хэмийн өөрчлөлт, нөхөн төлжих чадвар муу, тархац нутгийн хязгаарлагдмал байдлаас шалтгаалан тоо толгой нь цөөрч байна.


Хамгаалсан байдал: Конвенцийн II хавсралтад бүртгэсэн. Байгалийн ургамлын тухай Монгол улсын хуулийн 3.3 дахь заалтаар нэн ховор ургамлын жагсаалтад бүртгэн ашиглалтыг хязгаарласан (1995). Энэ зүйл цэцгийн үндсэн тархац нутгийн зарим хэсэг тусгай хамгаалалттай газруудад хамрагддаг.

Худалдаа: Мэдээлэл байхгүй.

Экологи, эдийн засгийн үнэлгээ: Үнэлгээ хийгдээгүй.



Д. Суран



ГУРВАЛСАН ШҮРЭН ҮНДЭС

Багийн нэр: MAGNOLIOPHYTINA

Овгийн нэр: ORCHIDACEAE

Латин нэр: *Corallorhiza trifida* Chatel

Түгээмэл буюу англи нэр: Trifid coralroot

Олон улсын ховордлын зэрэглэл: Үнэлгээ хийгдээгүй.

Монгол улсын ховордлын зэрэглэл: ДБХХ-ны Улаан дансны шалгуураар бүс нутгийн хэмжээнд “Эмзэг” гэж үнэлэгдсэн (Nyambayar нар, 2012).

Таних шинж: Шүрэрхүү салаалсан үндэслэг иштэй, үндэсгүй. 10-25 см өндөр шаравтар иштэй, түүний доод хэсэгт 2-3 хальсан угларгатай. Ишний үзүүрийн цацаг баг цэцэгт 3-10 ногоовтор бяцхан цэцэгтэй. Шадар эрхтний навчинцар ланцуйрхуу, 4 мм урт бөгөөд тэдгээрийн 3 нь босоо, 2 нь доош унжсан. Уруул нь бараг бүтэн зууван 2-3 мм урт.

Дэлхийн тархац: Хойд Америк, Евразийн эх газруудын Арктикаар тархсан бөгөөд АНУ, Канад, ОХУ, БНХАУ, Япон, Солонгос,

Энэтхэг, Непал, Кашмир, Гринланд, Пакистан болон Европын ихэнх орнуудад бүртгэгдсэн.

Монгол орон дахь тархац: Хөвсгөл, Хэнтийд тархжээ.

Ургах орчин: Чийглэг шилмүүст болон холимог ойд ургадаг.

Амьдралын онцог: Ногоон навчгүй, ялмагаар хооллох (сапрофит) олон наст өвслөг ургамал.

Нөөц хомсдох шалтгаан: Амьдрах орчны доройтол, эмийн болон гоёл чимэглэлийн зориулалтаар түүх, түймэр, ган гачиг, нөхөн төлжих чадвар муу, тархац нутгийн хязгаарлагдмал байдал зэргээс шалтгаалан тоо толгой нь цөөрч, ховордлын зэрэглэлд багтсан.


Хамгаалсан байдал: Конвенцийн II хавсралтад бүртгэсэн. Байгалийн ургамлын тухай Монгол улсын хуулийн 3.3 дахь заалтаар нэн ховор ургамлын жагсаалтад бүртгэн ашиглалтыг хязгаарласан (1995). Шүрэн үндэс цэцгийн үндсэн тархац нутаг нь тусгай хамгаалалттай газруудад багтдаг.

Худалдаа: Мэдээлэл байхгүй.

Экологи, эдийн засгийн үнэлгээ: Үнэлгээ хийгдээгүй.



Д. Суран



КОНВЕНЦИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХЭД ТУЛГАРЧ БҮЙ БЭРХШЭЭЛ, ЦААШИД АНХААРАХ САНАЛ

- Конвенцийн хүрээнд хийсэн ажлуудын үр дүнг нэгдсэн мэдээллийн санд оруулахад талуудын ашиг сонирхол их байдаг тул энэ асуудал одоо хир шийдэгдээгүй. Энэ нь хууль бус худалдааны хуулийн зохицуулалт сайн биш байгааг илэрхийлнэ. Иймээс Конвенцийн хэрэгжилтийг хангахад хууль хяналтын байгууллага, судалгаа шинжилгээ, байгаль орчны төрийн болон төрийн бус байгууллагуудын хамтын ажиллагаа хамгийн чухал байгааг анхаарах нь зүйтэй. Хууль сахиулах, байгаль орчин, эрдэм, шинжилгээ, сургалтын байгууллагуудын хамтын ажиллагааг хамтарсан сургалт, семинар, үндэсний хэмжээний бага хурлыг зохион байгуулах арга замаар нэгтгэх, сайжруулах шаардлагатай.
